

Алдар нэр нь цуурайтаагүй ч аз жаргалын мөртэй хүйн ээж

Монголын хамгийн том буюу 6500 гр жинтэй хүүхэд эх барьж байжээ. >5

Эдийн засаг сэргэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна

ОУВС-гийн хөтөлбөр хүнд байдлаас гаргах сонголт. >11

Нийгмийн сүлжээг "атгах" заль

Өдөрт 3-5 удаа жиргэх нь хамгийн тохиромжтой тоо гэж үздэг. >16



НХС NATIONAL NEWS CORP | БҮРЭГДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO



ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨРТ ЗОРИУЛАВ

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.03.07, МЯГМАР ~ №041, 042 (587, 588)

ҮНЭ: 600Т

## ОНЦЛОХ

### УЛС ТӨР

**УИХ-ын гишүүн Л.Болд** сонгуулийн талаар Ерөнхий сайдад асуулга тавьжээ.  
**Өнгөрсөн сонгуулиар АН 104** суманд ялсан ч 74-ийнх нь Засаг даргыг батламжлаагүй байна.  
**УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар** ОУВС-гийн шаардлага бодит байдалтай нийцсэн гэж тодотгов.  
**Хонконгод суугаа Ерөнхий консул С.Эрдэнэ** хатагтай Тонг Шиолингд бараалхжээ.  
**БЗД-ийн Засаг даргыг** батламжилсан хотын даргын захирамжийг шүүх түдгэлзүүлээ.

### ЭДИЙН ЗАСАГ

**Засгийн газрын анхдагч** зах зээлийн арилжаа өнөөдөр болно.  
**Хөрөнгийн биржийн** индекс 867.98 нэгж болж, 0.36 хувиар өсөв.  
**Хүнд үйлдвэрийн салбар** дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувийг үйлдвэрлэж байна.  
**Монголбанкны нэг долоо** хоногтой үнэт цаасны үлдэгдэл 836 тэрбум төгрөгт хүрээ.  
**Улсын хэмжээнд төлбөрийн** картын үйл ажиллагааг нийт 11 банк эрхэлж байна.

### НИЙГЭМ

**Монгол Улсаас Өмнөд Суданд** үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчид 50 хүний амь аврав.  
**Нийслэлийн нэг дүүрэг, таван** аймгийн 17 суманд хорио цээрийн дэглэм тогтоолоо.  
**Хэнтийд шүлхийтэй тэмцэхэд** 30 сая төгрөг хуваарилах саналыг УОК-оос Засгийн газарт хүргүүлэв.  
**Орон нутагт энэ онд 193 удаа** гал түймэр гарч, 1.8 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.  
**Хуурай сүүний үйлдвэрт** сүүгээ өгсөн фермерчдэд урамшуулал олгохоор болов.

### ДЭЛХИЙ

**Трампа АНУ-ын цагаачлалын** бодлоготой холбоотой шинэ тушаал гаргана.  
**Өрнөд, ОХУ-ын хооронд** Хүйтэн дайн өрнөж болзошгүйг Марин Ле Пен анхааруулав.  
**Фийон Францын Ерөнхийлөгчийн** сонгуульд өрсөлдсөн хэвээр үлдэхээ мэдэгдлээ.  
**Сошиал сүлжээг эсэргүүцэгч,** Ираны экс Ерөнхийлөгч Twitter-т аккаунт нээв.  
**ХБНГУ-ын зэвсэгт хүчин сум** хэрэгслээр дутагдаж байна.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

2017.03.07



-4° | -15°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЖИЙН МЭДЭЭГЭЙН  
11 ДУГААР НҮҮРЭЖ ҮЙНШВЭН ҮҮ.



86580001029112 00587 00588

Бүхэрх хуулиар хамгаалагдана ©

# Зөөлөн хүч



Эмэгтэйчүүдийн хүчийг зөв хуваарилбал тогтвортой бөгөөд өсөлттэй эдийн засагтай байх боломжтой. ▶3

Б.Ганбаяр/ЗГМ©

## ТДВ

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

### ХӨГЖИЛ ДЭВШИЛД ҮРГЭЛЖ ХӨТӨЛДӨГ БИДНИЙ БАНК

Хөгжил дэвшилд хамтдаа

Утас: 1900-1977 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn  
Фэйсбүүк: www.tdbm.mn/facebook | Твиттер: www.tdbm.mn/twitter

## УЛС ТӨР

### Эмэгтэй улстөрч бэлтгэх стратеги хэрэгтэй

Б.Даваатогтох  
@datoZGM

"Гал голомт" үндэсний хөдөлгөөний тэргүүн Д.Мөнхтөмэй шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх талаар ярилцлаа. Тэрбээр шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчин хангалттай байх нь чухал гэдгийг онцлов.

"Гал голомт" үндэсний хөдөлгөөнөөс эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр өнгөрсөн хугацаанд ямар ажил амжуулав?

-Миний бие Монголын

эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд 40 орчим жилийг өнгөрөөсөн, ахмад үеийн төлөөлөгчдийн нэг. 1990-1992 он буюу Монголын нийгэмд томоохон өөрчлөлт болж байсан үед Монголын эмэгтэйчүүдийн хороог тэргүүлж байсан. Хорон нь төр олон нийтийн статустай үндэсний хэмжээнд ажилладаг, төр санхүүжүүлдэг байгууллага байсан юм. Тухайн үеийн нийгмийн өөрчлөлттэй уялдуулан VI Их хурлыг хуралдуулж, Монголын эмэгтэйчүүдийн холбоо нэртэй төрийн бус байгууллага болон өөрчлөгдсөн. Монголын эмэгтэйчүүдийн холбоо нь задарч, бутраагүй цөөхөн байгууллагуудын нэг.

▶2

## ЗГМ: СЭДЭВ

### Шинэ эриний ээжүүд

Гэрээсээ бизнес эрхэлдэг ээжүүдэд олон нийтийн сүлжээ дэм болдог

Г.Сайнзаяа  
@sainzayaZGM

Д.Болормаа сэтгүүлч мэргэжилтэй, бизнесийн удирдлагаар мэргэжил дээшлүүлсэн ажилсаг бүсгүй. Харин Б.Биндэрьяа график дизайнер мэргэжилтэй уран бүсгүй.

Тэд нэг талаараа адилхан, хоёулаа ээжүүд. Гэртээ хүүхдээ асрах хугацаандаа өөрсдийн авьяас, сонирхлоо хөгжүүлж,

түүнийгээ бизнес болгосон овсгоотой бүсгүйчүүд билээ. Д.Болормаа төрөл бүрийн бялуу захиалгаар хийж борлуулдаг бол Б.Биндэрьяа гоёл чимэглэл, бэлэг дурсгалын зүйлс хийж зардаг байна. Эмэгтэйчүүд жирэмсний амралтаа авахад санхүүгийн хараат болж, нийгмээс тусгаарлагдсан мэт санагдах нь элбэг. Хоёр жил хүртэл хугацаагаар амрах нь ганц тэдэнд биш, улсад ч хохиролтой. Тоо баримт сөхвөл хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх жин 2014 оны байдлаар 50.7 хувь байв. Энэ нь эмэгтэйчүүд ажиллах хүчний талаас илүү хувийг эзэлж буйг илтгэх хэл.

▶7

## MSE ALL

867.98  
0.36%

## АЛТ

1232.80  
0.12%

## ЗЭС

5917  
0.22%

## 10-ЧИНГИС БОНД

93.576  
0.03%

## 5-ЧИНГИС БОНД

99.456  
0.1%

## АМ.ДОЛЛАР

2468.55

## ЮАНЬ

357.91

## РУБЛЬ

42.31

## Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

## Эмэгтэй улстөрч бэлтгэх стратеги хэрэгтэй

**АИХ-ын депутатын 24 хувь нь заавал эмэгтэй байх намын шийдвэртэй байсан**

«1

Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг зөвхөн XXI зуунд хөндөөгүй. 1792 онд Английн гүн ухаантан, “банзалтай суутан” хэмээн алдаршсан М.Уолстонкрафт эмэгтэйчүүдийн эрхийн тухай анхны том хэмжээний бүтээлээ гаргаж байсан. Хүн төрөлхтөний соёл иргэншлийн хөгжлийн явцад эмэгтэйчүүдийн эрхийн асуудал байнга хөндөгдөж байсан юм. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд гаргасан орнууд хүний хөгжлийг дэмжсэн, хүн амын үнэмлэхүй дийлэнх нь чинээлэг амьдралтай, нийгмийн өндөр хамгаалалт болж хөгжсөн байдаг.

Харин Монгол Улс эмэгтэйчүүдэд эрх олгох талаараа дэлхийн бусад оронтой харьцуулахад дээгүүрт тооцогддог. Тухайлбал, 1924 оны Үндсэн хуулиараа эмэгтэйчүүд сонгогдох эрхийг нь олгосон байдаг. Гэхдээ эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах асуудал анхаарлын гадна үлдэж болохгүй.

**-Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд төрөөс ямар бодлого баримтлах ёстой вэ. Өнгөрсөн онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийг батлахдаа эмэгтэйчүүдийн квотыг 30 хувь байхаар тусгасан боловч нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 20 болгон бууруулсан шүү дээ?**

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн байснаар асуудал шийдэгддэг гэж ойлгож болохгүй. Нэгдүгээрт, улс төрийн хүчнүүдэд эмэгтэй улстөрчдийг бэлтгэх томоохон стратеги байх ёстой. Хоёрдугаарт, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчин хангалттай байх нь чухал. Манайд УИХ-д хэдэн эмэгтэй гишүүнийг сонгоод, шүүмжлээд байх юм. Үүнтэй би санал нийлэхгүй байгаа. Нийгмийн янз бүрийн салбараас улс төрд орж ирж байгаа хүнд туршлага, мэдлэг, мэдээлэл хэрэгтэй. Үүнд төр ч анхаарал хандуулах ёстой. Мөн сонгосон ард түмэн ч тусалж дэмжих хэрэгтэй гэж бодож байна. Тухайлбал, Скандиновын орнуудад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо 35-49 хувьтай байдаг. Гэтэл энэхүү орнууд бидний мөрөөдөж байсан социализмыг бүтээлээ хэмээн эрдэмтэд дүгнэж байна.

ЭШЛЭЛ



-Нийгмийн чиглэлийн зарим бодлогоо эргэн дүгнэж цэгнэх хэрэгтэй байна. Яагаад гэвэл нийгмийн чиглэлийн хэт их ачаалалтай байвал эдийн засгийн хүндрэлээс гарахад хэцүү. Үүнийг хаана, хаанаа ойлгож байгаа байх гэж найдаж байгаа. Ер нь үйлдвэрлэж байгаагаасаа илүү зарцуулаад байвал эдийн засаг сэхэхгүй нь ойлгомжтой. Тэгэхээр бидний харахыг хүсэхгүй байгаа бодит үнэнийг ОУВС-гийнхан хэлж өгч байгаа гэж ойлгох хэрэгтэй. Энэ утгаараа хүнд биш үнэн, зөв шаардлагыг тавьж байна хэмээн хүлээн авах нь зүйтэй юм.

УИХ-ын гишүүн  
Д.Цогтбаатар



С.Батсайхан / ЗГМӨ

**-УИХ-ын гишүүдийн мэдлэг, боловсролд төр анхаарах ёстой гэсэн үг үү?**

-УИХ-ын сонгуулийн дараа шинэ гишүүдэд сургалт явуулдаг жишиг бий. Социализмын үед төрийн удирдах албан тушаалд томилогдсны дараа олон улсын дипломат протоколын талаар хичээл заадаг байсан. Иймд шинэ гишүүдээс улс төрийн дээд амьдралын арвин туршлага нэхэх нь буруу. Дэмжиж туслах ёстой. Гадаад харилцааны яам ч үүнд ач холбогдол өгөх хэрэгтэй гэж бодож байна. Түүнээс биш хэн нэгний нэр төрөөр тоглож улс

**Хүн амын тодорхой бүлгийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд байх ёстой**

төр хийх хэрэггүй.

**-Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн давуу тал нь юу юм бол?**

-Нэгдүгээрт, эмэгтэйчүүд улс төрд орсноор авлига, хээл, хахуулиас төр тодорхой хэмжээгээр чөлөөлөгддөг. Үүнийг



-Төсвийн үр ашиггүй зардлуудыг танах, төсвийн орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай. Өмнө нь чуулганы нэгдсэн хуралдаанд миний хэлж байсан шаардлагуудтай ОУВС-гийн шаардлага нийцэж байгаа учраас би дэмжиж байна. Манай зардлууд социалист маягтай, орлого тал нь капиталист маягтай болчихсон. Зарлагадаа бид төрөл бүрийн нийгмийн халамжийн бодлогыг ихээхэн өргөжүүлдэг. Орлого талдаа татварыг бууруулж, илүү либерал маягтай нэг шатлалтай татварын тогтолцоо руу шилжчихсэн.

УИХ-ын гишүүн  
Г.Занданшатар

Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд гаргасан орнууд хүний хөгжлийг дэмжсэн, хүн амын үнэмлэхүй дийлэнх нь чинээлэг амьдралтай, нийгмийн өндөр хамгаалалт болж хөгжсөн байдаг.

энэхүү аргыг хэрэглэдэг. Хэрэв тухайн суудалд хүн сонгогдож чадахгүй байвал суудал нь хоосон байдлаар хадгалагддаг. Дараагийн сонгуулиар олон түмний итгэлийг хүлээх хүн гарах хүртэл хоосон хадгалагддаг. Энэхүү суудлыг авахын тулд намууд эмэгтэй улстөрчдийг сонгож, хөгжүүлж, бэлтгэхэд их анхаардаг. Монгол Улс 1962 онд батлагдсан Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенцид нэгдэн орсон. Мөн 1990 оноос өмнө Ардын Их Хурлын депутатын 24 хувь нь заавал эмэгтэй хүн байхаар улс төрийн намын шийдвэртэй байсан. Зарим яамны орлогч сайд нар заавал эмэгтэй хүн байхаар хатуу тогтоосон байсан юм. Харамсалтай нь, өнөөдөр ардчилал хөгжсөн манай оронд ийм зүйл байхгүй юм.

**-Парламентын суудал хадгалах квотыг Монгол Улсад хэрэгжүүлэх боломж байгаа юу. Манайд нэр дэвшигчдийн квот тогтоох аргыг хэрэглэх нэрийдлээр эмэгтэй улстөрчдийг “үхэл”-ийн тойрогт илгээдэг шүү дээ?**

-Би суудал хадгалах квотыг Монгол Улсад хэрэгжүүлэх гэсэн саналыг тавьж байсан. Квот тогтоох асуудалд олон хүн шүүмжлэлтэй хандаж байна. Энэ асуудлыг зөвхөн эмэгтэйчүүдээр хязгаарлаж ойлгох нь буруу. Монголын хүн амын тодорхой бүлгийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд байснаар нийт хүн амын эрх ашгийг хангасан эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. Өнөөдөр Монгол Улсад 350 мянган малчин өрх байна. Гэтэл энэ парламентад малчин хүн байхгүй байна. Намайг УИХ-ын гишүүн байхад малчин, Хөдөлмөрийн баатар Ц.Намхайнямбуу агсан парламентын гишүүнээр ажиллаж байсан юм. Квот тогтоох асуудалд залуучуудын, тариаланчдын, уул уурхайн зэрэг олон салбарын төлөөллийг хамруулж ойлгож болох юм.

Дэлхийн олон орон парламентын хоёр танхимтай байдаг. Дээд танхимд нь нийгмийн төрөл бүрийн төлөөлөл багтсан жишиг ч бий. [ЗГМ]

батлах олон улсын туршлага ч бий. Хоёрдугаарт, эмэгтэйчүүд нийгмийн асуудалд илүү ач холбогдол өгдөг. Тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын бодлогод түлхүү анхаарал хандуулж, энэ чиглэлд шийдвэр гаргахад ихээхэн нөлөө үзүүлдэг. Энэ бол эмэгтэй хүний нийгмийн өмнө хүлээсэн хамгийн том үүрэг. Монголын 840 мянган гэр бүлийн менежерийг хэн хийж байна вэ. 840 мянган өрхийн асуудлыг төрийн бодлогод тусгахад эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоо өндөр байна. Жишээ дурдахад, эмэгтэй хүн сантиметр талбай дээр дөрвөн тонн ачаа дарах хүчээр үрээ төрүүлдэг. Тиймээс эх хүний хайр, эх

хүний сэтгэл гэдэг бол үнэлж баршгүй зүйл. Энэхүү зүйл төрийн бодлогод туссанаар үр хүүхэд, өвгөд хөгшид болон залуу үеийнхэнд ээлтэй бодлого гарна. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог яагаад нэмэгдүүлэх гээд байгааг эрэгтэй улстөрчид ч гэсэн судлах ёстой.

**-Төрөөс ямар бодлогоор дэмжих ёстой вэ?**

-Дэлхийн практикт хоёр арга зүйг хэрэглэж байна. Нэр дэвшигчдийн болон парламентын суудал хадгалах квот гэж байдаг. Суудал хадгалах квот гэдэг нь парламентын 76 гишүүний 15 нь заавал эмэгтэй хүн байна гээд хуульчилсан байх жишээтэй. Энэтхэг, Уганда зэрэг олон оронд

## ТОВЧХОН

» ШАГНАЛ

Ерөнхийлөгчийн зарлигаар УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболдыг Сүхбаатарын одон, УИХ-ын гишүүн З.Нарантуяаг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасныг УИХ-ын дарга М.Энхболд гардуулав. УИХ-ын гишүүн Н.Энхболд, З.Нарантуяа нар тойрогтоо ажиллаж газрын учир өчигдөр шагналаа гардсан юм.

» ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газрын ээлжит хуралдаан өнөөдөр болно. Хуралдаанаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төсвийг батална. Мөн ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2016 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулна.

» АСУУЛГА

УИХ-ын гишүүн Л.Болд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад хандаж асуулга тавьжээ. Тэрбээр 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр Сүхбаатар аймаг болон нийслэлийн Баянзүрх дүүрэгт Ардчилсан нам ялалт байгуулсан ч Засаг даргыг батламжлахгүй байгааг тодруулжээ.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсаас БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бус Хонконгт суугаа Ерөнхий консул С.Эрдэнэ Хонконгийн Ерөнхий захирагч Лян Жөн-инд бараалхав. Энэ үеэр Ерөнхий консул С.Эрдэнэ Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн тусалцаа үзүүлэх тухай хэлэлцээрийг энэ жилд багтаан байгуулна гэдэгт найдаж буйгаа илэрхийлэв.

» НАМУУД

Ардчилсан намын нарийн бичгийн дарга О.Магнай, Нийслэлийн Ардчилсан намын дарга Э.Бат-Үүл нар мэдээлэл хийж, Баянзүрх дүүрэгт үүсээд байгаа нөхцөл байдлыг эрх баригчдын Үндсэн хууль зөрчсөн увайгүй үйлдэл хэмээн дүгнэлээ. Тэд эрх баригчдыг шат, шатны шүүхийн шийдвэрийг зөрчсөн хэмээн үзэж байна.

» ШИЙДВЭР

Нийслэлийн Засаг дарга С.Батболд захирамж гаргаж, Баянзүрх дүүргийн Засаг даргаар Э.Бат-Амгаланг томилсон. Гэвч нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс “Баянзүрх дүүргийн Засаг даргыг томилсон шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлж байна” гэсэн шийдвэр гаргажээ.

» ТОО

800

Шашны байгууллага. 1991 оны үед Монгол Улсад 130 гаруй шашны байгууллага үйл ажиллагаа явуулж байв. Гэтэл өнөөдрийн байдлаар зөвшөөрөлтөй 800, зөвшөөрөлгүй 200 орчим шашны байгууллага ажиллаж байгаа гэсэн судалгаа гарчээ. Энэ нь Төр, сүм, хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийх нэг гол үзүүлэлт гэж үзэж, хуулийн төсөл боловсруулжээ.

ТОДРУУЛГА &amp; ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Шилдэг САНАА

Bloomberg TV Mongolia

Пүрэв гараг /2017.03.09/

20:30

11:30 Баасан гараг

09:30/19:30 Бямба гараг

18:00 Ням гараг

# Нийтлэлчийн булан

## Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс 3-4 пунктээр илүү

Р.Оюунцэцэг  
@oyuntssetsegZGM

Маргааш Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр. Мартын-8 хэмээн нэрлэж заншсан энэ өдөр монголчууд цэцэг, дарс, бэлэг сэлт, бялуухнаар бүсгүйчүүд, ээжүүдээ баярлуулж, бүх нийтээр амрах төдийхнөөр төсөөлж ирсэн нь нийтлэг хандлага. Харин цаад агуулгыг нь ухвал энэ өдөр цаашид эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, улс орноо тогтвортой хөгжүүлэхэд тэдний дуу хоолойг нэмэгдүүлэх зэрэгт анхаарлаа дээшлүүлэхийг жил тутам сануулж буй томоос том дохио.



Б.Ганбаяр/ЗГМ©

# Зөөлөн хүч

### БАЙГАЛИЙН ХУУЛЬ

Хэвлийдээ хүн бүрэлдүүлж, энгэрээсээ сүү урсгадаг болохоор эмэгтэй хүний үнэт зүйл илүү нандин. Эцсийн мөч хүртэл үр хүүхдийнхээ төлөө бүхнээ зориулж, тэднийхээ өмнө үнэнч байж, ирээдүйн нь амьдралын сайн сайхныг цогцлооход гэж байгаа бүхнээ шавхан тэмцдэг. Тиймээс зовлон жаргалыг ойлгож, асуудлын гүн рүү орж, чимхлүүр нарийн бүхнийг гярхай хардаг нь эмэгтэй хүнд байгалиас заяасан үндэс.

Үүнийг дагаад олон ажлыг зэрэг амжуулж, хавьгүй бүтээмж өндөртэй байдаг нь олон улсын судалгаагаар ч хэдийнэ нотлогдсон зүйл. Тийм ч учраас эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд оролцсоноор улс орны хамгийн чухал салбар болох боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд түлхүү анхаарч, эрх нь зөрчигдөж байгаа иргэдийн дуу хоолой болж, хурц асуудлуудыг зөөлөж чаддаг нь маргаашгүй юм. Энэ бол эрчүүдээс ялгарах эмэгтэйчүүдийн хамгийн том давуу тал.

Харин энэ давуу тал эдийн засгийн өсөлтөд гол түлхэц үзүүлж, тогтвортой хөгжих нэгэн түлхүүр болохыг НҮБ-ын гишүүн орнууд хэдийнэ хүлээн зөвшөөрсөн нь хоёр жилийн өмнөөс баталгаажсан. Тодруулбал, 2030 он хүртэл ядуу буурай, хөгжсөн, хөгжөөгүй үл хамааран, Парисын хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн улс орон бүр Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх үүрэг

хүлээсний дотор жендерийн тэгш эрхийг хангах тухай тодорхой заасан байдаг. Улс орнуудыг хөгжүүлэх томоохон хүч нь эмэгтэйчүүд байх болно хэмээн “бууж өгсөн” гэсэн үг. Үүний нэг жишээ нь, НҮБ-ын 2016 оны тайланд эмэгтэйчүүдийн цалингийн хэмжээг эрчүүдийнхтэй ижил түвшинд хүргэж, нийгэм, эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр хүний эрх, хувь хүний хөгжил болон эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэдгийг онцолсон байна. Үүнийг бататгаж, НҮБ-ын экс Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун “Эмэгтэйчүүдийн нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, эдийн засгийн хувьд эрх мэдэлтэй байх нь улс орон, дэлхий нийтийн эдийн засгийн хувьд хийх хамгийн зөв бөгөөд ухаалаг алхам” хэмээн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 71 дүгээр чуулганы үеэр хэлсэн удаатай.

### ЭМЭГТЭЙЧҮҮД БА УЛС ТӨР

Тэгвэл энэ сарын 1-5-нд дэлхийн монгол эмэгтэйчүүд хоёр дахь удаагаа чуулж, улс орноо хөгжүүлэх гарцыг Чикаго хотноо хэлэлцлээ. Дэлхийн монгол эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас зохион байгуулсан

энэ чуулганд боловсрол, мэдлэг, мэргэжил, эрхэлж буй ажил, нийгэмд эзэлж буй байр суурь, эх орноо хөгжүүлэх хүсэл зорилгоороо манлайлагч, Монгол, Герман, Солонгос, АНУ-ын мужууд гээд дэлхийн өнцөг булан бүрт амжилттай ажиллаж яваа 15 бүсгүй илтгэл тавьж, урилгаар 40-өөд хүн оролцжээ. Эрдэм-Хөгжил-Дэвшил уриан дор явагдсан уг чуулганаас хамгийн анхаарал татсан сэдэв нь Үндэсний стратегийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Б.Мөнхсөёлын “Улс төр нийгмийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо” илтгэл. Энэ бол Монгол Улсад дутагдаж байгаа хэрнээ бүрэн хэрэгжүүлж болдоггүй үзэгдэл.

### Эмэгтэйчүүдийн хүчгүйгээр тогтвортой хөгжихөд эрчүүд дангаараа 75 жил зарцуулна

Олон улсын жишгээр бол үндэсний хэмжээнд ажиллах хүчний талаас илүү хувийг эмэгтэйчүүд хангаж байгаа хэрнээ шийдвэр гаргах түвшинд

20 хувийг ч бүрдүүлж чаддаггүй. Эмэгтэйчүүд хавьгүй өндөр боловсрол эзэмшсэн ч эрчүүдийн авдгаас 80 хувьтай нь л тэнцэх хэмжээний хөлсөөр цалинждаг. Манай улсын хувьд цалин хөлсний хэмжээ хүйсээс хамааран хэт зөрүүтэй байх тохиолдол харьцангуй бага гэж болно. Монгол Улсын нийт хүн амын 52.2 хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс 3-4 пунктээр илүү (2016 оны эхний 11 сарын үзүүлэлт). Тэгсэн хэрнээ нийгмийн хамгийн гол салбаруудын гүйцэтгэх түвшний ажлын 70 гаруй хувийг эмэгтэйчүүд нугалж байна. Харин эрчүүд удирдах албан тушаал, шийдвэр гаргах түвшинд ноёлж буй.

Гэтэл бидний хүлээн зөвшөөрч, эгнээнд нь нэгдээд буй Тогтвортой хөгжлийн 17 зорилтын тавдугаар заалтын гол агуулга нь эмэгтэйчүүдийн оролцоог тэгш хангаж, нийгэм, эдийн засгийн хөгжлөөс тэнцүү хүртээх. Гэвч манай улсад хүйсийн тэгш байдал хэтэрхий алдагдсаныг инфографикаас харж болно. Энэ үзүүлэлтээрээ бид дэлхийн 145 орны 56-д бичигдэж байна. Төрийн үйлчилгээний албан хаагч буюу

эмч, багш нарын 90 орчим хувь нь эмэгтэйчүүд байдаг. Бас эмэгтэй судлаачдын тоогоороо Монгол дэлхийд дээгүүрт бичигддэг. Харамсалтай нь шийдвэр гаргах түвшинд тэдний байр суурь зорьсон 30 хувьдаа ч хүрээгүй хэвээр.

2010 оныг бодвол үүнд бага зэргийн ахиц бий. 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа Парламентад дөрвөн хувь эзэлж байсан эмэгтэй гишүүд 2012 онд 14.5, 2016 оны сонгуулиар 17.1 хувьд хүрсэн нь чамлахааргүй амжилт. Гэвч нийслэл, орон нутаг, ИТХ-д эмэгтэйчүүдийн квотыг 40 хувьд хүргэнэ гэсэн том зорилттой манай улсын биелэлт дэндүү хангалтгүй байгаа. Харин энэ удаагийн орон нутгийн сонгуульд зөвхөн МАН-аас нэр бүхий 146 эмэгтэй нэр дэвшсэнээс 88 нь тойрогтоо ялалт байгуулсан амжилттай байна. Түүнээс гадна Улаанбаатар хотын дарга нэг орлогчоороо эмэгтэй хүн томилсныг нь чамлахгүй, чанга амжилт буй.

### ЭМЭГТЭЙЧҮҮД БА ЭДИЙН ЗАСАГ

ОУВС-гийн захирал Кристин Лагард “Хэрвэ Энэтхэг улс эмэгтэйчүүдийнхээ ажил эрхлэлтийн түвшинг эрчүүдийн хэмжээнд хүргэвэл ДНБ-ээ 27 хувиар нэмэгдүүлэх боломжтой” хэмээн нэгэн хурлын үеэр мэдэгдэж байсан удаатай. Тэгвэл Япон, АНУ л гэхэд ажиллах хүчний бодлогодоо жендерийн тэгш байдлыг тусгаснаараа ДНБ-ээ 5-9 хувиар өсгөж чадсан. Мөн Турк улс эмэгтэйчүүдийн хүчээр ДНБ-ээ 22 хувиар нэмэгдүүлэх нөөц байгааг хатагтай Кристин Лагард онцолсон байдаг. Хэрвэ нигери эмэгтэйчүүд эрчүүдтэй нь ижил тэнцүү боломж байсан бол тэд улсынхаа ДНБ-ийг 13.9 ам.доллараар өсгөх нөөц боломж бүрэн байгааг Youth and Technology сангийн тэргүүн Нжидека Харри мөн онцолжээ. Улс орнууд эмэгтэйчүүдийн хүчийг зөв хуваарилбал тогтвортой бөгөөд өсөлттэй эдийн засагтай байх боломжтойг энэ эшлэлүүд тодорхой харуулж байна.

Парламент дахь эмэгтэйчүүдийн тоо өнгөрсөн 100 жилийн хугацаанд дэлхийд 11.7-19.4 хувиар өссөн талаар НҮБ-ын тооцоо байдаг. Тэгвэл 2014 оноос эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд улс орнууд эрчимтэй анхаарах болсон нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн өсөлтийн хурд 66 хувьд хүрснийг “Financial Times” онцолжээ. Үүнд, Их Британи, АНУ, ХБНГУ багтаж буй. Түүнчлэн Ази тивээс Япон улс Абэгийн бодлогын хүчээр эмэгтэйчүүдийн оролцооны өсөлтийг 84.9 хувьд хүргэснээрээ тэргүүлж байгаа аж. Энэ мэтчилэн хөгжиж буй төдийгүй өндөр хөгжсөн орнууд ч жендерийн тэгш байдлыг хангах замаар тогтвортой хөгжих бодлогод гойд анхаарч байна.



### С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



© 2017 S.AT&O & ZGM

### ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШАЛТГААН

Эмэгтэйчүүдийн арга барилын онцлогийг Парисын хэлэлцээргүйгээр аль хэдийнэ хүлээн зөвшөөрсөн Швейцарь, Дани, Норвеги, Канад зэрэг Скандинавын орнууд өдгөө аз жаргалын индексээрээ дэлхийд тэргүүлж байна. Энэ л улс орнуудын хөгжлийг монголчууд хүсэн мөрөөдөж, залуус нь аль болох эдгээр оронд “шингэх” далд хүсэлтэй. Түүний оронд Монгол Улсаа дутахааргүй аз жаргалтай болгох сонголт уг нь бий.

Жилдээ ганц Мартын 8-наар баярлуулсан болоод мартах бус, бүх асуудлаа тэдний оролцоотой шийдвэрлэж, хүссэн хүсээгүй хүлээн зөвшөөрөх цаг ирснийг энэ бүхэн илтгэнэ. Эмэгтэйчүүдийн хүчгүйгээр тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхэд эрчүүд дангаараа 75 жилийг зарцуулна гэсэн сонирхолтой баримтыг Холливудын залуу жүжигчин Эмма Уатсон дурдсан байсан. “Аз жаргалтай гэр бүлийн нууц нь эхнэрийнхээ хэлснийг сонсох” гэсэн жүжигчин Дэнзел Вашингтоны үг ч хоосон наргиа биш. Тэд бүх асуудалд эх хүний байр сууринаас ханддаг тул байгалийн хуулийг дагах нь хамгийн эрсдэлгүй. Эмэгтэйчүүд бол зөөлөн хүч. [ЗГМ]



## Хүмүүс

# Алдар нэр нь цуурайтаагүй ч аз жаргалын мөртэй хүйн ээж

**Монголын хамгийн том буюу 6500 гр жинтэй хүүхэд эх барьж байжээ**

**Б.Бямбасүрэн**  
@byambaZGM

Өвөө минь нэг удаа “Хунд жаргалын дээдийг бэлгэглэхээд харцууд нь баярлалаа гэсэн ганцхан үеийн өглөг авдаг хүмүүс эмч шүү дээ” гэж билээ. Хүний орчлонд ирж буй үл таних зочдыг хамгийн түрүүнд гар дээрээ тосож, халуун дулаан дуу хоолойгоор мэндчилдэг энэ хүмүүсийн гэгээн үйлсийг дүүрэн үнэлдэггүй хэрнээ хамгийн хариуцлагатай үүргээ тэдэнд итгэн үүрүүлдэг. Бид ийм хүмүүсийн нэгтэй уулзахаар болсон юм. Тэр бол сар шинийн босгон дээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс дөрвөнтөө төрийн дээд одон медаль хүртээд буй нийслэлийн Өргөө амаржих газрын ахмад эх баригч Б.Ичинхорлоо гуай. Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цолтой долоон хүний нэг нь тэр юм. Алдар нэр нь цуурайтан тугээгүй ч гэгээн үйлс нь ямагт хайр, аз жаргалын мөртэй байдаг эрхмийг “Хүмүүс” буландаа урьж хөөрөлдөө.



С.Батсайхан/ЗГМӨ

**-Юуны өмнө Төрийн дээд одонгоор энгэрээ мялаасанд тань баяр хүргэе?**

-Би Анагаах ухааны дунд сургуулийг 1974 онд эх баригч, бага эмчийн мэргэжлээр дүүргэсэн. Ажлын гараагаа Архангай аймгийн Хашаат сумын Лүн баригадаас эхэлж байлаа. Тухайн үед биднийг албан томилолтоор хуваарилдаг байсан юм. Тэндээ нэг жил гаруй ажиллаж байгаад хоёр дахь хүүхдээ гаргахдаа Улаанбаатар хотод шилжиж ирсэн юм. Ингээд хуучнаар бол Нэгдүгээр амаржих газар, одоогийн нийслэлийн “Өргөө” амаржих газарт ажилд орж, дагалдан эх баригч, сувилагч гээд бүхий л орон тоон дээр ажилласаар эх баригч, бага эмчийн ажлыг 37 жил хийж, гавьяандаа гараад байна.

**-Та яагаад эх баригчийн мэргэжлийг сонгосон юм бэ. Таны уламд эмнэлгийн салбарын хүмүүс байсан уу?**

-Манай уламд эмч хүмүүс нэг их байхгүй ээ. Намайг төрөхөд манай саахалт айлын эмч эх

барьж авсан юм билээ.

Жаахан байхдаа тэднийд тоглож наадах үед тэр хүн надад эмч гэдэг ямар сайхан мөргөжил болохыг хэлдэг байлаа. Ингээд 10 жилээ төгсөөд анагаахын анги авах гэтэл огт өөр мэргэжлээр худалдааны техникүмд хуваарилсан байсан. Тухайн үед хуваарь авах хэцүү цаг үе байж дээ. Би тэгээд урвайсан хүн “Энэ сургуульд орохгүй, өөр сургуульд ормоор байна” гэж байтал эх барьсан эмч маань анагаахын техникүмд орон тоо байгааг хэлээд, “Чи чадах уу” гэж асууж байсныг тод санадаг юм. Тэгж л энэ сайхан мэргэжлийг эзэмших хувь заяа надад ирсэн юм даа.

**-Ажлаа Хашаат сумаас эхэлж байжээ. Анхны эх барьж авсан үе ямар санагдаж байсан бэ. Айж мэргэж байв уу?**

-Би чинь хотын хүн болохоор адгийн наад зах нь морь унахаас эхлээд чадахгүй зүйл олон байлаа. Дуудлаганд явах гэхээр улс амьтан морь хөтлөөд ирнэ. Морнор явж чадахгүй сандардаг байсан үе бий. Сүүлдээ ч бүх зүйлийг сурсан шүү. Хашаатын Лүнд очиход бага эмч нь тэтгэвэртээ гарах болчихсон, ажлыг нь хүлээж авах хүнгүй гээд намайг хараад бөөн баяр болж байсан. Гэр нь эмнэлгийн хажууханд байдаг байсан юм. Би гэж хүн бөөн онол үзсэнээс биш эм найруулах ч туршлагагүй байсан учир өнөөх эмчээсээ маш олон зүйл сурч, заалгасан. Жирэмсэн эхийн анхны дуудлаганд номоо сугавчлаад гэрт нь очиж байсныг санаж байна.

**-37 жил ажиллахдаа та хэдэн хүүхэд эх барьж авсан бэ?**

-Уг нь тэмдэглэлийн дэвтэр хөтөлдөг л байсан юм. Сая гавьяат авахад тодорхойлноор бол 16849 хүүхэд эх барьсан гэсэн байна билээ. Гэхдээ бичигдээгүй хэд байгаа байх. Ерөнхийд нь тооцвол 17 мянган хүүхэд байгаа болов уу гэж бодож байна.

**-Таныг хараад мэргэжилдэй хайртай, хийсэн бүтээсэн зүйлтэй байна гэдэг сайхан юм хэмээн хувьдаа бодож сууна. Энэ олон жилийн туршид шантрах үе тохиож байв уу?**

-Зах зээлийн үед өөр мэргэжил рүү “урвах” бодол төрж байсан үе бий. Бидний цалин пүнлүү хэд байсан билээ. Гэхдээ л эзэмшсэн мэргэжлээ хаяж зүрхлэхгүй явсаар энэ олон жилийн турш ажилдаа үнэнч зүтгэсэн байна. Үүний гавьяа гарч байна шүү дээ. Маш олон шавь нартай болсон байна. Хүн сэтгэл гаргаж ажиллах юм бол цаашдын ажил үйлс нь бүтдэг жамтай. Эх баригчийг хүйн ээж гэдэг шүү

Төрөлт бол багийн ажиллагаа. Нярайн эмч, эх баригч, сувилагч, асрагч гээд олон хүн оролцож эхийг амаржуулдаг.

хувийн эмнэлэгтэй байдаг нь их сонин санагдаж билээ. Мөн хувиараа Бельги улсын амаржих газраар зочилж байсан удаатай. Аргагүй хөгжингүй орон учир бүхнийг тоног төхөөрөмжөөр хянаад, эхчүүдийг өөрсдийнх нь саналаар төрүүлдэг. Тухайлбал, амаржиж буй ээж хүсвэл гэртээ, эсвэл усанд, эмнэлэгт төрөх боломжтой. Гэртээ төрнө гэвэл эмнэлгийн бүхий л тоног төхөөрөмжөө аваад очих жишээтэй. Усанд төрөхөөр бол маш том усан онгоцууд байдаг. Усанд төрсөн эх харьцангуй тайван байдгаас гадна хярзан нь урагдахгүй байх гэхчилэн олон давуу талтай. Аавууд нь ч хамт байх боломжтой. Манай улсын хувьд цаг агаарын байдалтай холбоотойгоор ар гэрийнхнийг нь төрөхийн өрөөнд оруулахад тийм ч тохиромжтой байдаггүй. Гэхдээ манай амаржих газар ар гэрийнхэнтэйгээ төртлөө байх боломжтой өрөөтэй болсон.

**-Төрөх үедээ нөхрөө өрөөнд хамт байлгах хүсэлтэй ээж нар олон байдаг. Аавууд маань харин айдаг. Тангтай аймхай аавууд хэр олон таарч байв?**

-Нэг хэсэг манай амаржих газар ээж нарын хүсэлтээр аавуудыг төрөхийн өрөөнд оруулдаг байсан. Даанч аав нар зүрх муутай, аймхай. Зарим нь өрөөний үүдээр орж ирвч үү, үгүй юу пэд хийгээл ухаан алдаад уначихна. Тэгэхээр нь бид нар төрж байгаа хүнээ гэх үү, өнөөх аавыг яах вэ гээд тэрүүхэндээ сандралдана. Энэ мэтчилэн хөгжилтэй, хөгтэй олон дурсамжтай үе таарч байлаа. Зарим аав нараас асуудаг юм. Ороод толгойг нь түшээд байж чадах уу гэж. Уг нь гэр бүлийнхээ хүнтэй хамт төрөлтэй ээжүүдийн сэтгэл санаа амгалан, сайхан байсан л даа.

**-Асуухад жаахан эвгүй л юм. Гэхдээ эх баригч нар ээжүүдийг загнадаг, муухай ааштай хүмүүс байдаг гэлцдэг?**

-Төрөх гэж байгаа ээжүүд маань их эмээг байдаг л даа. “Алив нэг эвтэйхэн хэвтээд өгөөч” гэхээр загналаа гээд бодчихдог шиг байгаа юм. Манай эх баригч нар төрөх гэж байгаа ээжүүдийг учиргүй

загнаад байдаггүй юм шүү дээ. Аль болох зааж зааварчилна. Олон жилийн өмнө нэг ээж өвдөөд угаалтуурын доод талын тахир төмрөөс зуурчихаад гарч ирдэггүй ээ. Гараад ирээч дээ гээд гуйлаа, өвдөөд байна гээд хөдлөх янзгүй. Ийм үед чангаа нэг үзнэ, үгэнд орохгүй бол жаахан ширүүхэн хэлэхээс өөр аргагүй шүү дээ. Бас нэг ээж төрөх орон доогуур орчихоод гүрийгээд гарч ирэхгүй байсныг санаж байна. Энэ мэтчилэн зүйл тохиолдвол аргадаж бас аашилж нэг үзнэ ш дээ.

**-Та хамгийн ихдээ ямар жинтэй хүүхэд эх барьж авсан бэ?**

-Тэр хүүхэдтэйгээ ойрд холбогдоогүй юм байна. Монголын хамгийн том буюу 6500 гр хүүхэд эх барьж авч байсан. Жин ихтэй хүүхэд төрүүлэх хэцүү. Төрөлт бол багийн ажиллагаа. Нярайн эмч, эх баригч, сувилагч, асрагч гээд олон хүний оролцоотой эхийг төрүүлдэг. Сүүлийн үед хооллолт, цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан том жинтэй хүүхдүүд төрөх нь ихэслээ. Түүнчлэн хэт таргалалт, чихрийн шижин өвчин ч үүнд нөлөөлж байгаа. Япончууд хүнээ таргалуулдаггүй. Төрөхөд 10 кг нэмэх ёстой, түүнээс илүү хайр ёсгүй гэдэг. Манайх ч бас энэ бодлогыг баримталж, зөвлөгөө өгдөг. Үгүй бол дур дураараа ийм, тийм витамин сайн гэж хамаа замбараагүй хэрэглэдэг нь маш буруу хэвшил болоод байна.

**-Дээхнэ үед аав, ээжүүд эх баригчийг хүүхэдтэй нэр хайрлахыг хүсдэг байсан. Та хэр олон хүүхэдтэй ямар нэрүүдийг бэлгэшээж өгч байсан бэ?**

-Зөндөө л олон хүүхэдтэй нэр өгсөн дөө. Тоог нь мартжээ. Аав маань надад хэлэхдээ хүүхэдтэй хэмээн захидаг байсан. Тухайн төрсөн гараг дээр нь сүрэн юм уу, эсвэл жав нэмбэл монгол нэр болдог учиртай юм билээ. Гэхдээ сүүлийн үед Тэнгис, Цэцгээ, Ананд гэхчилэн орчин үеийн нэр өгч байна. Бас баатруудын нэрийг хүүхэдтэй хайрладаг болжээ.

**-Ярилсанд баярлалаа. [ЗГМ]**

## “МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК” ХХК САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ ШАЛГАРУУЛЖ АВНА



Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг: “МИК Групп” компани болон “МИК ОССК” ХХК, түүний үүсгэн байгуулсан ТЗК-ийн зээлийн хөрөнгийн худалдан авалт, үнэт цаасжуулалтын ирээдүйн мөнгөн урсгал болон бусад хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр ашгийг тооцох, санхүүгийн богино, дунд, урт хугацааны төсөв төлөвлөгөөг хийх, түүний гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх, санхүүгийн төлөвлөлт, ашигт ажиллагааны гүйцэтгэлийн мониторинг хийх, үнэт цаасны үйл ажиллагааны дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, санхүү, хөрөнгө оруулалтын болон актив-пассивын бодлого тодорхойлоход шаардлагатай санхүүгийн шинжилгээ болон зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах.

### Ажлын байранд тавигдах шаардлага:

1. Банк санхүү, эдийн засаг, санхүүгийн удирдлагын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
2. Банк, санхүүгийн байгууллага болон аж ахуй нэгжийн санхүүгийн удирдлага, төлөвлөлт болон няглан бодох бүртгэлийн чиглэлээр 2 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
3. Санхүүгийн мэргэжлийн Англи хэлний зөв бичгийн болон ярилцлага хийх өндөр чадвартай;
4. Хэрэглээний болон санхүүгийн программ хангамж ашиглах чадвартай;
5. Мэргэшсэн няглан бодогч (CPA) болон Мэргэшсэн санхүүгийн шинжээч (CFA) түвшиний анхан шатлалын шалгалтыг өгч гэрчилгээ авсан бол давуу тал болно;

### Нэмэлт ерөнхий шаардлага:

1. Хариуцсан ажилдаа бүтээлч сэтгэлгээтэй, идэвхи санаачлагатай, ажлын цаг ашиглалтын зохион байгуулалт сайтай байх;
2. Санаачлагатай, багаар болон бие даан ажиллах;
3. Багаар болон бие даан үр дүнтэй ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай;
4. Шударга, хөдөлмөрч, компанийн сайн засаглалын мэдлэгтэй, ёс зүйтэй байх;
5. Ажлыг төлөвлөх, манлайлах, удирдан зохион байгуулах дүгнэлт хийх, шийдвэр гаргах чадвартай;
6. Хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлагатай, харилцааны соёлтой;
7. Ажлын ачаалал даах чадвартай, өөрийгөө дайчлан ажиллах боломжтой;
8. Ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн сахилга батыг дээдлэн сахидаг;
9. Урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах.

### Бүрдүүлэх материал:

1. Ажилд орохыг хүссэн өргөдөл (гараар бичсэн);
2. Анкет (www.mik.mn цахим хуудаснаас татаж авна уу);
3. Дипломны хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх);
4. Иргэний үнэмлэхний хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх);
5. 3 үеийн түүх (гараар бичсэн);
6. Өмнө хийж байсан ажил, туршлагын талаар товч бэлтгэсэн мэдээлэл;

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй иргэд материалаа delgermi@mik.mn хаягаар болон СБД-ийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Т1-А хаягт орших Худалдаа хөгжлийн банкны 10-р давхарт 2017 оны 03-р сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**: Анкетийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогч нартай холбоо барина.**  
Утас: 11-328267 (827) Вэбсайт: www.mik.mn И-мэйл: info@mik.mn

# Спорт

## Бэлтгэл дээр бөхчүүдийг “шалны алчуур” болгож буй сурагтай

**Г.Баярсайхан**  
@bayarsaikhanZGM

Энэ сарын 12-нд Японы Осака хотноо мэргэжлийн сүмогийн Харү башё эхэлнэ. Хаврын тэмцээн олон зүйлээрээ онцлог болох тул олны дунд асар их хүлээлт үүсгэжээ. 2003 оноос хойш төрсөн анхны япон аварга Кисеносато хэрхэн барилдах нь хамгийн их сонирхол татаж буй. Өөрөө түрүүлнэ гээд л байгаа. Цол дагаж бяра нэмнэ гэгчээр бие хаа нь томроод, ааг омог нь нэмэгдэж, озки байсан үеэсээ эрс сайжирсан болохыг сүмогийн мэргэжилтнүүд хэлж байна. Бэлтгэл дээр ч үүнийг харуулж, бөхчүүдийг ёстой л “шалны алчуур” болгож буй сурагтай. Хамгийн сүүлд манай Тамаваши Б.Мөнх-Оргилтой 16 барилдахад хоёрхон унасан гэнэ. Тамаваши нь зүгээр нэг амны хүүхэд биш, сэкивакэ цолтой мундаг нөхөр шүү дээ. Мөн маэгиширагийн дөрөвт эрэмбэлэгдсэн Ёшиказэтай 13 барилдаж, бүгдэд нь давжээ. Их л өнгөлөг байгаа нь эндээс харагдана.

Нөгөө талд Монголын гурван аварга өмнөх башёгийн хариугаа авах гээд тэсч ядан байгаа. Өкозүна цолны босго өндөр гэдгийг түүнд мэдрүүлж, хандыг нь дараад өгнө гэсэн бодолтой байгаа нь мэдээж. Хакүхо, Харүмафүжи аваргууд бэлтгэлээ хэрхэн базааж буй талаарх мэдээлэл алга. Харин Какүрюү аварга сүүлийн бэлтгэл дээр комүсүби Сёдай болон



буй, нутгийн аварга төрсөн гэдэг утгаараа хүн бүр башёг үзэхийг хүсэж, тасалбар нь бүгд зарагдаад дуусчээ. Үзэгчдээ татах гэж янз бүрийн арга хэрэглэж буй сүмогийн холбооны хувьд энэ нь таатай мэдээ болж байна.

Дашрамд сонирхуулахад, дөрвөн ёкозүна нэг дор зодоглосон тохиолдол өмнө нь хоёр удаа гарч байв. Хамгийн сүүлд 2000 оны эхээр Акэбано, Мусашимару, Таканохана, Ваканохана гэсэн аваргууд нэгэн үед барилдаж байлаа. Гэхдээ дөрвөн аварга нэг дор жилээс илүү хугацаанд барилдсан түүх үгүй. Хэн нэг нь шахагдаж, зодог тайлахаас аргагүйд хүрч байсан үе нь тиймээс энэ жил юм уу, ирэх оны эхээр одоогийн дөрвөн аваргын нэг нь зодог тайлах магадлал өндөр. Мэргэжилтнүүд Кисеносато, Какүрюү хоёрын нэг нь сүмогийн амьдралаа төгсгөж магадгүй хэмээн тааварлажээ.

Нэгдүгээр сарын тэмцээнд дөрвөн арслан барилдсан бол өдгөө энэ тоо хоёр болоод байгаа. Нэг нь ёкозүна болж дэвшсэн бол нөгөө арслан Котошёгико цолоо алдаж, сэкивакэ болсон. Хоёр тэмцээн дараалад тавхан даваа авсан тул цол буурахаас ч аргагүй. Гэхдээ түүний хувьд боломж бий. Хэрэв энэ башёд 10 болон түүнээс дээш давчихвал цолоо эргүүлэн авах юм. Хамгийн сүүлд Точиазума ийм байдлаас арслан цолоо буцаан авч байв.

Нөгөө нэг озки Тэрунофүжи хэрэв тавиас дээш хувийн амжилтаа үзүүлж чадахгүй бол цолоо алдах аюулд өртөөд байгаа. Тэрбээр сүүлийн долоон башёгийн гуравт нь л тавиас дээш хувийн амжилт үзүүлсэн. Ингэхдээ дөнгөн данган найман даваа авч байв. Өнгөрсөн жилийн эхээр авсан хүнд бэртэл нь өөрийн хэмжээнд барилдахад саад болсоор. Уг нь эрүүл саруул бол түрүү байрын төлөө өрсөлдөх

## ТОВЧХОН

### » ЖҮДО БӨХ

Энэ сарын 10-12-нд Азербайжаны Баку хотноо уламжлалт Их дуулга тэмцээн болно. Бакугийн татамид 32 орны 204 бөх өрсөлдөх мэдүүлгээ ирүүлжээ. Манайхаас гавьяат тамирчин Д.Амартүвшин тэргүүтэй зургаан бөх барилдахаар болсон байна.

### » ЧӨЛӨӨТ БӨХ

Якутын анхны олимпийн аварга, ЗХУ-ын гавьяат дасгалжуулагч Р.Дмитриевийн нэрэмжит залуучуудын олон улсын тэмцээн Саха хотноо хоёр өдөр явагдаж өндөрлөв. 13 орны 166 тамирчин найман жинд өрсөлдсөн тус тэмцээний 120 кг-д “Мегастарс” клубийн Э.Тэмүүлэн мөнгөн медаль хүртсэн байна. Тэмцээнээс медаль хүртсэн тамирчдыг 50, 30, 15 мянган рублиэр урамшуулжээ.

### » ШАТАР

Ираны Тегеран хотноо болсон эмэгтэй шатарчдын ДАШТ Хятадын их мастер Тань Жунигийн ялалтаар өндөрлөлөө. Шилдэг 64 нь хасагдах системээр өрсөлдсөн энэхүү тэмцээнд нанхиад бүсгүй Украины А.Музычукийг нэмэлт тоглолтод 1.5-0.5-аар буулган авч, түрүүлжээ.

### » САГСАН БӨМБӨГ

Зүүн Азийн АШТ зургадугаар сарын 2-8-нд Японы Нагояд болох урьдчилсан тов гараад байна. Энэ тэмцээний эхний дөрвөн байрт орсон баг Азийн аваргад өрсөлдөх эрхээ авах юм.

### » ХӨЛБӨМБӨГ

Францын дээд лигийн сүүлийн тойрогт “Монако” өөрийн талбайдаа “Нант”-ыг 4:0-ээр хожлоо. Ингэснээр тэд “Ницца”, “ПСЖ” багуудыг орхин хүснэгтийг тэргүүлж эхлэв. 18 настай довлогч Мбапе энэ тоглолтод хоёр гоол оруулжээ.

### » ХОККЕЙ

NHL-ийн улирлын тоглолтод “Калгари” баг “Айлендерс”-ийг 5:2-оор илт илүүрхэв. Тэд сүүлийн долоон тоглолтод дараалж хожсоны ачаар плей-оффын байрт бичигдэж эхэллээ.

# Шинэ аварга аатай байна

жоүрёогийн Оянаги нартай 14 барилдаж, бүгдэд нь давжээ. Өмнөх башёг гэмтлийн улмаас дундаас нь орхисон болохоор энэ удаа нэлээд хичээж барилдах нь тодорхой.

Хакүхо аваргын тухайд Осакагийн дэвжээнд урамтай

барилддаг уламжлалтай. “Цагаан гарьд” сүүлийн есөн жилийн Харү башёгийн долоод нь түрүүлсэн бөгөөд үүний гуравт нь 15-0 гэсэн төгс амжилт үзүүлжээ. Сонирхуулахад, тэрбээр ёкозүна цолтой барилдсан башёгийн тоогоор (58) Тайхотой зэрэгцэж,

гуравт бичигдэх болсон байна. Дахин зургаан башё барилдахад дээд амжилтыг дангаар эзэмших юм.

Харүмафүжи аваргын хувьд Харү башёд нэг ч удаа түрүүлж үзээгүй. Осакагийн дэвжээ хагуурхдаг гэж болно. Гэхдээ

тэрбээр гэмтэл аван башёг орхисон бол дараагийн тэмцээнд тун сайн барилддаг. Гайгүй сайн амраад авдаг нь нөлөөлдөг бололтой. 2015 онд гэхэд хоёр башё дараалан өнжсөний эцэст долоо дахь түрүүгээ гардаж байв. Дөрвөн ёкозүна барилдаж

хэмжээний бөх. Жил гаруйхны өмнө башёд түрүүлж, томчуудыг айлгаж авсан хүн цолоо алдвал хайран л байна. Гэхдээ гэмтэл нь овоо эдгээс болзолтой. Саяхан бэлтгэл дээр 20 барилдаан хийж, 19 давсан байна лээ. Гайгүй сайн барилдах болов уу. [ЗГМ]

## СОНИРХУУЛАХАД

### Диокл хамгийн баян нь

Бүх цаг үеийн хамгийн баян тамирчнаар хэн тодорсон гэж та бодож байна. Тэрхүү тамирчин бол хэн нэгэн сагсчин, хөлбөмбөгч, авто уралдаанч, теннисчин биш харин МЭ-ий II зуунд амьдарч байсан эртний Ромын морин тээргний тамирчин Гай Аппулей Диокл байсан гэнэ. Зодог тайлах хүртлээ тэрбээр одоогийн 15 тэрбум ам.доллартай тэнцэх мөнгө шагналд авсан байна.

Диокл 18 настайдаа уралдаж

эхлэн, 42-тойдоо зодог тайлжээ. Энэ хооронд 35.863.120 сестерц олсныг түүнд зориулан босгосон хөшөөн дээр шүтэн бишрэгчид нь бичсэн байжээ. Энэ нь одоогийн 15 тэрбум ам.доллартай тэнцэнэ гэдгийг Чикагогийн их сургуулийн эрдэмтэн Питер Страк тооцоолон гаргасан байна. Тэр үед тамирчид хэвлэл мэдээлэл болон зар сурталчилгаанаас мөнгө авдаггүй байсан гэхээр Диокс үнэхээр гайхалтай тамирчин байжээ. [ЗГМ]

### Бодибилдингийн “загалмайлсан эцгүүд”

Өнгөрсөн зууны 60-аад оныг хүртэл хүмүүс бодибилдингийг төдийлэн сайн мэддэггүй, телевиз, хэвлэлийнхэн ч ойшоодоггүй байв. Харин ах дүү Жо, Бен Уайдеруудын ачаар энэ спорт дэлхий дахинд алдаршсан. Баргийн юманд цочирдохоо больсон

америкчуудын анхаарлыг татаж, тэрхүү асар том зах зээлд хөлөө олох зорилго өвөрлөсөн залуус бизнесээ бодибилдингээр эхэлжээ. Гэвч талх тариа шиг зарагддаггүй бодибилдингийн төхөөрөмж, төрөл бүрийн уураг, аминдэмүүдээ борлуулахын тулд

хэн нэгэн супер одыг гаргаж ирэх хэрэгтэйг ах дүүс ойлгосон байна. Ингээд Лондонд болсон “Мистер олимп”-д аваргалсан Арнольд Шварценеггерт санал тавьсан ч татгалзсан хариу сонсов. Гэвч нутагтаа цагдаагийнхантай таагүй асуудлаар орооцлодох болсон

австри эр удалгүй Калифорнид очихыг зөвшөөрчээ. Арнольд Америкийн бодибилдингийн нүүр царай болох үүргээ сайн гүйцэтгэсний ачаар Уайдерууд тэрбумтны эгнээнд орж, Олон улсын бодибилдинг, фитнессийн холбоог байгуулсан түүхтэй. [ЗГМ]

### Шайбыг яагаад хөлдөөдөг вэ

Хоккейн тоглолт болохоос хэдэн цагийн өмнө шайбыг хөргөгчинд хийдэг бичигдээгүй хууль бий. Учир нь тасалгааны температурт байсан шайб хэтэрхий уян зөөлөн

болчихдог учраас яаж ч хүчтэй цохнод хол явдаггүй аж. Тэгвэл бага зэрэг хөлдсөн шайб мөсөн дээр сайн гулгадаг бөгөөд цохиур модтой шүргэлцэх агшинд үрэлт

бага үүсгэдэг. Шайбын талаар бас бүс зүйлийг сонирхуулахад, Хойд Америк, Европт бэлтгэлийн үеэр тоглогчид улбар шар, хаалгачид хөх өнгөтэй шайб ашигладаг гэнэ.

Шайбын стандарт хэмжээ нь 7.62 см диаметртэй, 2.54 см зузаан, 105-185 грамм жинтэй. Ийм шайбыг 190 км/цагийн хурдтай цохих боломжтой. [ЗГМ]

**ubinfo.mn**  
Улирлын зөвшилго: 5000₮  
Жилийн захиалга: 15000₮  
ТАВХАА: 20170317, 99993381, 99993384  
info@ubinfo.mn  
20070300

## ЗГМ: ИНФОГРАФИК



## ЗГМ: Сэдэв

## Шинэ эриний ээжүүд

**Хүүхдээ харахын хажуугаар сонирхлоо хөгжүүлж, мөнгө олж байна**

Жижиг зургаар харвал нэг өрхийн орлогын тодорхой хэмжээ үгүй болно. Том зургаар харвал улсад ирэх татвар, тухайн хүний оюун ухаан, мэдлэг, ажлын бүтээмж үгүйлэгдэж байгаа юм. Гэтэл эдгээр үнэ цэнэтэй ажиллах хүчин гэртээ хүүхдээ асрах хоёр жилийн хугацааг ашиглан өөрсдийгөө хөгжүүлж, хийх дуртай зүйл, сонирхлоо мөнгө болгож болжээ.

Ээжүүдийн дунд явуулсан бичил асуулгаас үзвэл, эмэгтэйчүүд декриттэй байх үед бизнесийн санаа, аливаа шинэ санал санаачилга хамгийн их төрдөг, өндөр бүтээмжтэй байдаг байна. Нэг хэсэг нь гэртээ хоол, амттан, гоёл, чимэглэл, гоо сайхны бүтээгдэхүүн хийж борлуулдаг. Харин нөгөө хэсэг нь хүүхдийн живх, хувцас, тэрэг, ор, нүүрний будаг тэргүүтэй олон зүйл импортлон зарж байна. Тэд 19.00 цагаас хойш хүргэлт хийдгийн учрыг нь лавлавал нөхрийнхөө ажлыг дууссаны дараа хүргэлтэд туслуулдаг аж.



Д.Болормаа

ловверуулсан хүнсний бүтээгдэхүүнүүд чанаргүй, зарим нь эрүүл мэндэд ч хортой болохыг мэдээд хүүхдэдээ шинэ, эрүүл хоол өгөхийг хүсчээ. Улмаар том хүүгээ төрүүлчихээд гэртээ асрах хугацаандаа бялуу, нарийн боовны сургалтад суусан байна. Түүнээс хойш бялуу хийж аав, ээж, хамаатнуудаа дайлах болж. Энэ нь өргөжсөөр танихгүй хүмүүсээс ч захиалга ирж, бага хүүгээ төрүүлснийхээ дараа хоббигоо бизнес болгосон гэв.


Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон импортлогч компаниуд гэртээ хоол, амттан хийдэг ээжүүдийг идэвхжүүлэлтийн баг болгон, хамтран ажиллахдаа таатай байдаг. Тухайлбал, будаа, гоймон, гурил импортлодог нэгэн компани ээжүүдэд сар бүр тогтмол цалин өгдөг ажээ. Ээжүүд хариуд нь тухайн компанийн бүтээгдэхүүнээр бялуу, жигнэмэг хийж, түүнийгээ олон нийтийн сүлжээнд хуваалцах үүрэгтэй. Энэ мэтээр далд сурталчилгаа явуулах нь тухайн компани болон гэртээ байгаа ээжүүдийн өрхийн орлогод нэмэртэй байдаг. Хүүхдээ асрах хугацаандаа бичил бизнес эрхлэх гэж байгаа ээжүүдэд гадаад хүчин зүйлээс дайралт ирээд байдаггүй нь сайшаалтай. Д.Болормаа хүүхдүүдээ унтуулчихаад захиалгын бялуугаа хийдэг бол Б.Биндэръяа хүүхдийнхээ хамтаар чимэглэл урладаг. Гэрийнхэн нь бүгд л эдгээр бүсгүйг цаг зав, зориулалт, урмаар дэмждэгийг сонсоход

таатай байв. Д.Болормаа “Олон нийтийн сүлжээнд явагдаж тэмцээнүүдэд оролцож, талх баригч, талх шарагч, мах татагч, будаа агшаагч гээд олон зүйл хожиж байлаа. Ингэх бүрт урам авч, бүр ч их хичээмээр санагддаг” хэмээлээ.

“Монгол Улс амаржсан эхийн амралтыг хоёр жилээр тогтоосон нь маш зөв зүйтэй санагддаг. Хоёр нас хүрэхдээ хүүхэд хөтөвч дээр сууж, хоолоо өөрөө идэж, бусдад наад захын хэрэгцээгээ ойлгуулж сурсан байдаг. Харин тэр хүртэл нь хоёр жилд нь хамт байх маш чухал гэж боддог л доо. Ээжүүдийн хувьд төрөх дөхөөд сургалтад сууж, өөрийгөө хөгжүүлж, бэлтгэлээ базаах хэрэгтэй” гэж тэрбээр зөвлөв. Хоёр жил бол ээжүүдэд хонжоотой хугацаа. Магистрын зэрэг хамгаалах, олон улсын шалгалтад бэлдэх, шинэ зүйл сурахад тохиромжтой учраас тэр гэнэ.

**Амаржсан эхийн амралтыг хоёр жилээр тогтоосон нь маш зөв зүйтэй гэв**

Б.Биндэръяа анх шинэ жилийн гацуур модны тоглоомууд урлалын эсгийгээр хийж байлаа. Жоохон хүүхэдтэй айлууд хагарахгүй гээд үүнийг маш их захиалсан. Үүнээс урам



Б.Биндэръяа

Б.Ганбаяр / ЗГМ

авч хүүхдийн нэртэй, хананд өлгөдөг дурсгалын зүйл, гоёл чимэглэл идэвхтэй хийж борлуулах болжээ. Тэрбээр анхны дурсгалын тоглоомоо хоёр өдөр хийж байсан бол одоо ихдээ л таван цагт багтааж дуусгадаг болсон. “Би багадаа ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохиогддог хувцас загварын тэмцээнүүдэд оролцдог байлаа. Уг мэргэжил маань өөр ч гэртээ хүүхдээ

харах хугацаандаа чаддаг зүйлээ хийхийг хүссэн. Хүн бүрт ямар нэг авьяас бий. Олон зүйл туршиж, үүнийгээ олж мэдвэл үр дүнг нь амсана гэж боддог” хэмээлээ.

Цагт баригдаж, хүссэнээрээ сэтгэх боломжоо боолгохоос эхлээд ажлын байранд стресс ихтэй. Харин чөлөөтэй сэтгэж, хүүхэдтэйгээ хамт байж, дуртай зүйлээ хийж, амжилтад хүрэхэд сэтгэл ханамж өндөр

байдгийг тэд ам нэгтэйгээр хэлсэн юм. Б.Биндэръяа “Найз бүсгүйчүүдтэйгээ уулзахаар ажил дээр ийм, тийм зүйл болсон гээд маш их стресстэй байдаг. Би тэднийг сонсоод өөрийгөө азтай хүн гэж боддог шүү” хэмээв.

Гэртээ, гараар хийсэн бүтээл шинэ, найдвартай, буцах хаягтай, чанартай байдаг. Гэвч манайд гараар хийсэн бүтээлийг үнэлэх үнэлэмж төдийлэн хомс тул хүмүүс үйлдвэрийн бүтээгдэхүүнийг илүүд үздэг. Дашрамд сонирхуулахад, Д.Болормаа, Б.Биндэръяа хоёр бялуу хийх, эсгий урлал хийх сонирхолтой хүмүүст сургалт явуулдаг.

Гэртээ хүүхдээ асарч байгаа ээжүүдэд нийгмийн харилцаанд оролцох хүсэл сонирхол их бий. Үүнийг харгалзан үзэж, тэдний хийсэн бүтээлийг үнэлүүлэх, таниулах зорилготой арга хэмжээнүүд манайд зохиогдох болсон. “Холио Солио” тэргүүтэй бартер буюу шинэ, хуучин эд зүйлээ солих өдөрлөгүүд гар урлал, эко бүтээгдэхүүн хийдэг ээжүүдийг урьж оролцуулдаг. Энэ үеэр ээжүүд ижил хүсэл сонирхолтой хүмүүстэй танилцаж, нөхөрлөх, туршлагаа хуваалцах боломж олдож байна.

Эмэгтэйчүүдийг дэмжих алхам өрх айлын дэвээр дороос эхлэх хэрэгтэй хэмээн дэлхийн эмэгтэйчүүдийн төлөөллүүд дуу хоолойгоо өргөж байна. Тиймээс бид ч Монголын ирээдүй болсон үр хойчийг өсгөж, хүмүүжүүлэхийн сацуу биеэ засаад, гэрээ засаж байгаа, цаашлаад төрөө засах хатан ухаантай бүсгүйчүүдийг бүх талаар дэмжих хэрэгтэй буйгаа. [ЗГМ]



Гэрээсээ бизнес эрхэлж байгаа ээжүүдэд интернэт болон олон нийтийн сүлжээ сайтууд ихээхэн дэм болдог. Зурагтаар өндөр үнэтэй сурталчилгаа цацуулж, их мөнгө урэх шаардлага тэдэнд байхгүй. Ухаалаг гар утас, эсвэл компьютер, интернэт байхад л хангалттай.

Д.Болормаа хагас бо-



## REGIONAL IMPROVEMENT OF BORDER SERVICES PROJECT



### VACANCY ANNOUNCEMENT

The Government of Mongolia with support from the Asian Development Bank (ADB) is “Regional Improvement of Border Services Project” (RIBS Project). The RIBS Project objective is to increase trade and competitiveness through reduced cost and time of compliance with trade procedures. Thus, under the project, Ministry of Finance is seeking to recruit a qualified Deputy Project Coordinator.

Objective of the assignment is to engage on an individual basis to be responsible for timely implementation and provision of Customs' Computer Automated Information System (CAIS) upgrades and single window software applications. He/she will ensure adherence to Asian Development Bank and Government of Mongolia's applicable procedures and guidelines.

#### Tasks and responsibilities will include:

- Developing technical specification of CAIS goods and services
- Developing testing strategy and acceptance criteria of CAIS upgrade and single window implementation
- Preparing and/or updating implementation plans for CAIS upgrades and single window implementation
- Preparing progress report on CAIS and single window project activities and focal for all relevant documents
- Preparing and/or reviewing bid documents
- Assisting in bid evaluations and advising on procurement procedures
- Liaising between all the stakeholders in designing, developing and pilot testing of CAIS upgrades and Single Window applications
- Briefing the PIU Project Manager on progress and potential problems
- Assisting the International PIU ICT Specialist
- Coordinate with relevant GOM ICT units Advising on resolving implementation and technical issues

#### Qualifications and Experience

- Suitability of undertake the responsibilities mentioned above at the required field
- Academic/professional qualification in procurement, business, engineering or relevant field A minimum of 10 years of professional experience
- Previous work experience of working with development partners is an important asset. Work experience in ICT related project is an advantage. High standards of professional and work ethics
- Excellent computer and communication skills
- Proficient in English language
- Good leadership

The Consultant will be selected in accordance with the relevant regulations of the Government of Mongolia and the Asian Development Bank.

If you possess the above qualifications, please submit a cover letter indicating why she/he considers her/himself suitable for the position, detailed CV highlighting skills/experience, copy of diplomas or certificates and two reference letters from last two employers no later than 12:00 PM, 20 March 2017. Only those successful

candidates will be contacted. The application documents shall be submitted in person to the below address. The submitted documents will not be returned to the applicants. Incomplete applications would not be considered. If you need any further details, please feel free to contact us.

Contact address: Room 405, Government Building No.2, S.Danzan Street 5/1, Ulaanbaatar, Mongolia. Tel: +(976)51 264694.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017-03-07

Тендер шалгаруулалтын нэр: **Ажлын хувцас нийлүүлэх 3 багц**  
Тендер шалгаруулалтын дугаар: **НАХ-05/2017**

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Ажлын хувцас нийлүүлэх 3-н багц:  
НАХ-05/2017 1-р багц Ажлын хувцас нийлүүлэх

НАХ-05/2017 2-р багц Үйлчилгээний ажилчдын хувцас нийлүүлэх

НАХ-05/2017 3-р багц Тусгай зориулалтын хувцас нийлүүлэх

тус бүрээр битүүжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

#### Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалт нь тендер санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
- Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015, 2016 оныг ирүүлэх
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл 2015, 2016 он (ноглох баримтын хамт лавлагаа авах тодорхой утас, хаяг)

Тендерийн хамт багц тус бүрээр 2%-ийн тендерийн баталгаа (засгийн газрын бонд байж болно) ирүүлнэ.

Дотоодын давуу эрх Багц-1, Багц-2 д тооцно.

Тендерийг 2017 оны 04 дугаар сарын 07-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 311, 310 тоот өрөө  
Утас 7018-1309 7000-1357 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

## Авто

# Автомат жолоодлоготой машины шинэ үе

*Ford компанийн мэргэжилтнүүд санаанд оромгүй шинэ дүгнэлт хийжээ*

О.Мишээл  
ЗГМ


Жолоочийн оролцоогүйгээр бие даан хөдөлгөөн хийх чадвартай, автомат жолоодлого бүхий тээврийн хэрэгсэл бүтээх ажилд автомашин үйлдвэрлэгчид төдийгүй Google, Uber зэрэг компани идэвхтэй ажиллаж байна. Уг салбарт шинэ шинэ дэвшил гаргаж буй Ford компанийн мэргэжилтнүүд туршилтын явцад санаанд оромгүй шинэ дүгнэлт хийснээ Bloomberg-т өгсөн ярилцлагадаа тайлбарлав. Жолоочгүй унаа туршиж буй инженерүүд машин автомат жолоодлогын горимд шилжсэнээс хойш унтаж орхих нь түгээмэл байна.

Ухаалаг машин хотын гудамжаар жигд хурдтай хөдөлгөөн үйлддэг учраас дотор нь зорчиж яваа инженер эрт, орой нэг цагт заавал зүүрмэлх нь гарцаагүй хэмээн Ford-ийн мэргэжилтнүүд өгүүлэв. Туршилтад оролцогч инженерүүд нойроо сэргээхийн тулд хонх дуугаргах, анхааруулах гэрэл

асаах, суудал, жолооны хүрд чичиргэх зэрэг янз бүрийн арга ашигласан ч ажлын байранд заавал унтаж таардаг ажээ. Туршилтын эцэст автомат удирдлагатай машинд хосоороо зорчиж, нэг нь машинаа, нөгөө нь хамтрагчаа хянах арга бодож олсон ч хоёул унтсан тохиолдол цөөн бус гарчээ.

Автомат удирдлагад шилжсэнээс хойш бүхээг дэх зорчигч нойрмог байдалд амархан автаж буйн шалтгаан нь шинэ технологитой машин алдаагүй, жигд хөдөлгөөн үйлддэг явдал хэмээн туршилтад оролцогчид тайлбарлав. Энэ нь технологийн хувьд магтууштай зүйл мөн ч Ford компани эргэцүүлбэл зохих өөр асуудал шинээр үүсгэв. Туршилтад оролцож буй инженерүүд нойроо дийлэхгүй байгаа юм бол ердийн жолоочоос анхаарлаа төвлөрүүлэхийг шаардах нь бүр ч хэцүү хэрэг.

Ердөө ирэх жил гэхэд Audi, BMW, Mercedes-Benz-ийн хагас автомат жолоодлого бүхий шинэ загвар гарах ёстой. Эдгээр загвар замын ихэнх нөхцөлд бие даан хөдөлгөөн үйлдэх чадвартай ч онцгой тохиолдолд хүний туслалцаа шаардана. Шаардлагатай үед хүн ердөө арваадхан секундэд багтаан харуу үйлдэл хийж, жолоог өөртөө шилжүүлэх учиртай. Гэтэл саяхан Саутхэмптоны их сургуулиас явуулсан судалгааг



Жолоочгүй машин ямар байх ёстой талаар санал хуваагдаад байна.

үзвэл автомат жолоодлоготой машины жолооч түвэгтэй нөхцөлд жолоог гартаа авахад 20-30 секундийн хугацаа шаардаж байгаа нь тодорхой болсон. Тэгэхээр машинд суугаа хүн унтаа тохиолдолд сэрэх, эрсэн хойноо жолоо барих хүртэлх хугацаа бүр ч урт байж таарна.

Одоогийн автомат жолоодлоготой машинууд АНУ-ын Автомашин инженерүүдийн холбооноос (SAE) тогтоож өгсөн Автомат жолоодлогын аюулгүй байдлын гуравдугаар түвшинд заасан шаардлагад захирагддаг. Энэ нь нийтийн хэрэглээний замаар автомат машин бие даан зорчих боловч жолооч шаардлагатай үед жолоог өөртөө

шилжүүлэхэд хэзээд бэлэн явах ёстой гэсэн шаардлага юм.

Харин Ford компани гаргасан дүгнэлтдээ тулгуурлан цаашид гуравдугаар түвшинд нийцсэн автомат жолоодлоготой машин бүтээх санаанаас татгалзахаар боллоо. Тус компани ердөө 2021 он гэхэд жолооны хүрд, хааз, тоормозны гишгүүр педаль огт байхгүй машин бүтээхээр зориг шулууджээ.

Ford-ийн зоримог шийдвэрийг Wayno компанийн захирал Жон Крафчик ч зүйтэй хэмээн үзэж байна. Wayno нь Google-ийн жолоочгүй машин бүтээх төслийн хүрээнд байгуулсан, Alphabet-ийн охин компани юм. "Аюулгүй байдлын гуравдугаар түвшин

гэсэн стандарт өөрөө утгагүй ч байж болзошгүй. Тиймээс ийм стандарттай машин бүтээх хэрэг байхгүй л болов уу" хэмээн өгүүлж байна.

Жолоочгүй автомашин ямар байх ёстой талаар эдүгээ технологи хөгжүүлэгчид санал хуваагдаад байгаа юм. Нэг хэсэг нь автомат жолоодлоготой нөхцөлд ч хүний хяналт зайлшгүй хэмээн үзэж байхад нөгөө хэсэг нь огт хүний оролцоогүй, цэвэр робот машинд шилжих нь зүйтэй гэсэн бодолтой. Технологийн энэхүү салбарт хуулийн илүү тодорхой зохицуулалт үүсгэх асуудлаар АНУ-ын Конгресст саяхан хэлэлцүүлэг болсон. [ЗГМ]

## Зөвлөгөө

### Их гэрлийг сэргээх хялбар арга

Машины хуванцар гэрлийн линз нь нарны хэт ягаан туяаны цацраг, машинаас ялгардаг яндангийн утаа зэргийг тэсвэрлэх чадваргүй байдгаас эдэлгээний явцад шарлаж, өнгөө алдааг. Өмнө нь ийм зүйл тохиолдоход гэрлийг шинээр солихоос аргагүй хүрдэг байв. Энэ хэрээр мөнгө урсах нь тодорхой. Харин одоо гэрлийг сэргээж, линзийг нь үйлдвэрийн мэт болгож боломж нэгэнт бүрдсэн. Ингээд их гэрлээ өнгөлөх дөрвөн алхмыг танилцуулъя.

#### БЭЛТГЭХ

Эхлээд урд гэрэл болон түүний ойролцоох хэсгүүдийг сайтар

цэвэрлэ. Дараа нь гэрлийн ойролцоох пластик эд анги байгаа бол авч эсвэл туузаар хамгаалах хэрэгтэй. Ингэснээр засах явцдаа кузовыг санаандгүй зурахаас сэргийлнэ.

#### ЗҮЛГЭХ

Гэрлийн зэвэрсэн хэсгүүдийг арилгаад гадаргууг гөлгөр болгоно. 1200-1600 эргэлттэй брилл ашиглаж, 500-тай зүлгүүрээр шарласан хэсгүүдийг арилгана. Линзий гадаргууг зүлгэхдээ хэт их дарж болохгүй гэдгийг сана. Эхлээд 1000-тай зүлгүүрээр зүлгэнэ. Гэрлийг дахин арчиж, илүү гөлгөр болсон эсэхийг шалгана. 500-тай

зүлгүүрээр арилагүй толбо болон бусад зүйлсийг зүлгэ.

#### НОЙТОН ЗҮЛГҮҮР

3000-ын зүлгүүр ашиглана. Зүлгүүр, гэрлийн линз болон линзийн бүх хэсгийн шарласан болон элэгдсэн хэсгийг арилтал дахин дахин усаар шүршинэ.

Энэ алхмын төгсгөлд гэрлийн линзийн тунгалаг байдал харьцангуй сайжирсан нь илэрхий харагдах болно.

#### ӨНГӨЛӨХ

Хөвсгөр зөөлөн хошуунд өнгөлөгч бодис бага зэрэг дусаана. Үүний дараа шууд асаахгүй бөгөөд гэрлийг тойруулж жигд



арчина. Ингэснээр өнгөлөгч бодис нь гэрлийн шилнээс бусад хэсэгт цацагдахаас хамгаална.

Гэрлийг гялалзтал нь дундаж даралтаар өнгөлөж, шинэ юм шиг харалтат арчина. Урд их гэрэл

200-800 мянган үнэтэй байдгийг бодоход хямд зардлаар ингэж сэргээх нь ашигтай юм. Шөнө тод тусах төдийгүй машины өнгө үзэмжийг сайжруулахад ч тустай. cardoctor.mn

## ЗГМ ТОВЧХОН

» **ХЭРЭГ ЗӨРЧИЛ**  
Өнгөрсөн амралтын өдрүүдэд Замын цагдаагийн албанд 499 дуудлага, мэдээлэл иржээ. Ослын 367 дуудлага бүртгэгдэж, 15 хүн гэмтэл авсан байна. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 75 жолоочийг илрүүлж, арга хэмжээ авчээ.

» **ШИНЭ ЗАГВАР**  
Швейцарийн Женев хотноо энэ сарын 9-19-нд авто шоу болно. Энэхүү арга хэмжээний үеэр салбартаа тэргүүлэгч томоохон үйлдвэрлэгчид шинэ загваруудаа танилцуулахаар төлөвлөжээ. Тухайлбал, "Ferrari" 6.5 литрийн багтаамжтай, V12 хөдөлгүүртэй, 2.9 секундэд 96 км/цаг хүртэл хурдлах чадалтай "812 Superfast" автомашиныг танилцуулахаар эзэх байна.

» **ҮНЭ ХАНШ**  
Германы BMW компани Орос зарагдаж буй автомашины үнэ нэмэхээр болжээ. Үнийн өсөлтөд бүх загвар хамаарах бөгөөд ойролцоогоор дөрвөн хувь нэмэгдэх юм байна. Ханшийн хэлбэлзэл ийм алхам хийхэд хүргэсэн талаар компанийн төлөөлөгч мэдэгджээ.

» **ТӨСӨВ**  
Ирэх жил ОХУ-д хөлбөмбөгийн ДАШТ зохиогдоно. Тэмцээний үеэр ачаалал эрс нэмэгдэх тул зохион байгуулагчид замын засвар арчилгаанд анхаарлаа хандуулж байна. Энэ ажлын хүрээнд орон нутгийн замыг засварлахад 8.5 тэрбум рубль зарцуулахаар төлөвлөжээ.

» **ДЭЭД АМЖИЛТ**  
Шинэ загварын "Lamborghini Huracan" Нюрбургрингийн тойрог замын дээд амжилтыг шинэчлэн тогтоолоо. Энэхүү супер машин 6 минут, 52.01 секундэд зайгаа туулсан нь өмнөх "Aventador" загварын үзүүлэлтээс долоон секундээр илүү байгаа юм. Тус машин 100 км/цагийн хурдыг 3.6 секундэд авах чадвартай бөгөөд дээд хурд нь 320 миль.

UBshop.mn  
ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

### Юу авмаар байна? Юу зармаар байна?

#### АВТОМАШИН

1 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна  
Утас: 96481125, 99087992  
2 Автомашины хагарч цуурсан шил наагч зарна.  
Хүргэлттэй. Үнэ: 35000 төгрөг  
Утас: 99679962  
3 Шинэ дугуйнууд зарна.  
Үнэ: 100.000 төгрөг  
Утас: 88006734  
4 Agiom шинэ дугуйнууд зарна  
Утас:99101688 /Үнэ тохирно/  
5 2009 оны "FX35" хямд зарна.  
Үнэ: 25 сая төгрөг  
Утас: 99111468  
6 "G500" загна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна.  
Утас: 99993434  
7 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай "Grand mark 2" яаралтай зарна. Үнэ 5 сая төгрөг. Утас: 96651794  
8 2009 оны "HUMMER H2" зарна. Утас: 91777877  
9 2008 оны "LX570" зарна. Үнэ: 60 сая төгрөг  
Утас: 99111468  
10 "Full option A8" зарна.  
Утас: 99995108

#### КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

1 Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна.  
Угсралт тохиргоо үнэгүй.  
Утас: 75752020  
2 Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000 төгрөг  
Утас: 88998138  
3 iPad-1 wifi 16gb зарна.  
Утас: 99002508  
4 Төмөр гадаргуутай 2ТВ багтаамжтай зөвөрийн hard диск зарна.  
Утас: 98886655  
5 "Sony Vaio core i5" notebook хямд зарна.  
Үнэ: 500.000 төгрөг  
Утас: 88102740  
6 Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock  
Утас: 88771767  
7 "Kory notebook shop" бүх төрлийн used нөтбүүк, таблет худалдаалж байна.  
Үнийн хувьд хамгийн хямд, өргөн сонголттой. Өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд ажиллана. Утас: 89997986

#### ҮЛ ХӨДЛӨХ


1 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. 2011 онд ашиглалтанд орсон төмөр бетон суурь, төмөр бөс бетон, 38-ийн дан тоосго, гадна талд хөөсөөр дулаалсан 200м2, 2давхар, машины гражтай, 380в цахилгаантай, цахилгаанаар бүрэн халдаг, 96м гүнээс худагийн ус гарсан цэвэр устай, халуун устай, цэвэр бохироо бүрэн шийдсэн өвөл зуны дулаахан чанартай сайн барьсан. - Нийт 6 өрөө, гал тогоо, зочны өрөө, 2 ариун цэврийн өрөөтэй, гал тогоо 00-д халуун устай, вакум цонх, паркетин шалтай дотор интерьер засал сайн. Утас: 99289768  
2 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. Утас: 88192130  
3 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494  
4 -Хүүхдийн Паркийн замын урд зам дагуу төвийн шугамд холбогдох боломжтой 300м2. -22-н товчоо тойргийн хажууд зам дагуу 1га 380 тогтой блокон хашаатай газар. -Хонхорт зам дагуу 9200м2 төвийн шугамд холбогдох боломжтой, худалдааны төв, шатхуун түүгээгүүр, аж ахуй, агуулах, хөнгөн үйлдвэр зориулалтаар ашиглах боломжтой газар. -Эмээлтэд 5га газар. Утас: 99289768  
5 Сансарын тунелд 1 давхарын гал тогоо тусдаа 3 өрөө байр зарна. Утас: 99760217, 99101271

#### НОМ, ХЭВЛЭЛ

1 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна.  
Утас: 99144154  
2 Хуучин номнууд зарна.  
Утас: 94640105  
3 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна.  
Утас 99153637  
4 Ээж ба хүүхэд ном зарна.  
Утас: 99089401  
5 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монгол цөөн байдга уран зургийн ном зарна.  
Утас: 99625921  
6 Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312  
7 Монголын залуучуудад хүн төрөлхтний хөгжлийн их алхаатай хөл нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээлгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбараар илэрхийлж чадсан "Монгол хүний хөгжил төлөвшлийн ДЭЭД УХААН" ном уншигчдын гар дээр очиж байна. Утас: 98111029  
8 Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зурилл ном зарна. Үнэ: 30.500

#### ЦАХИЛГААН БАРАА

1 Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 AAA батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C) Утас: 88512938, 96012938  
2 Модерн загварын ханын цаг (45-55cm) худалдана. Утас: 96012938, 88512938  
3 USB гагнуурын алх. Эгшин зуур хална, хөрнө. 480 С градус хүртэл хална.  
Утас: 96012938



Утас: 96012938


#### ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

## UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бүтсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.





## Нийгэм

### Шинэ паспорт хувь хүний мэдээлэл бүхий чиптэй

Г.Оюунтөгс  
@oyuuntugsZGM

Ирэх оноос гадаад паспортыг олон улсын стандартад нийцүүлэн нууцлал бүхий чиптэй, өндөр зэрэглэлийнх болгохоор болсон. Үүнтэй холбоотойгоор энгийн гадаад паспортын хүчинтэй хугацаа нь дуусаж байгаа иргэд энэ сарын 1-нээс эхлэн сунгахгүйгээр шинээр захиална гэсэн мэдээлэл гарсан. Энэ талаар Оюуны өмч, Улсын бүртгэл ерөнхий газрын иргэний бүртгэлийн газрын дарга Д.Энхцэгээс тодрууллаа.



Б.Ганбаяр/ЗГМ©

# Гадаад паспорт өндөр нууцлалтай болно

-Гадаад паспортыг сунгахгүй гэсэн мэдээлэл гараад байна. Энэ үнэн үү?  
-Өнөөдрийн байдлаар гадаад паспортын сунгалтын үйлчилгээ хэвийн үргэлжилж байна. Иргэдийн гадаад паспортын хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд иргэний бүртгэл мэдээллийн төв дээр 1-5 жилээр сунгаж байгаа.  
-Шинээр гадаад паспорт авах гэж байгаа хүмүүст олгож байгаа юу?  
-Тийм ээ. Иргэд маань Иргэний бүртгэл мэдээллийн төв, “Дунжингарав”, “Драгон” гээд нийслэлийн есөн дүүрэг болон хөдөө орон нутаг, хилийн чанад дахь 40 гаруй дипломат төлөөлөгчийн газруудаас шинэ гадаад паспорт авах, сунгалт хийлгэх боломжтой.  
-Гадаад паспорт шинэч-

лэгдэж байгаа гэсэн. Юуг нь шинэчилж байгаа вэ?  
Олон Улсын иргэний нисэхийн байгууллага 2004 онд сунгалт хийдэг, тамга, тэмдэг дардаг паспортыг хэрэглэжээ гаргах тухай гишүүн орнууддаа тунхаг бичиг гаргасан байдаг. Энэ ажлыг 2015 оны арваннэгдүгээр сарын 24-нөөс эхлэн хэрэглэжээ гаргана гэж хугацаа заасан. Үүнээс хойш манайх цахим гадаад паспортын бэлтгэл ажлыг хийж байгаа бөгөөд ирэх 2018 оны эхэнд цахим гадаад паспортыг иргэдээ олгохоор ажиллаж байна.  
-Цахим гадаад паспорттой болохоор улаан паспортыг хэрэглэхгүй гэсэн үг үү?  
-Цахим паспорт авсан хүмүүс цахим паспортоо хэрэглэнэ. Улаан паспорттой бол түүнийг хэрэглэж болно.

-Шинэ, хуучин гадаад паспортын хоорондын ялгаа гарч ирэх болов уу?  
-Тэгэлгүй яах вэ. Шинэ паспорт 48 хуудастай бөгөөд хувь хүний мэдээллийг хадгалсан чиптэй байх юм. Иргэний нисэхийн байгууллагын стандартыг бүрэн хангасан паспорт олгохоор бэлтгэж байна.  
**Хилийн чанадад гадаад паспорт авах, сунгах бүрэн боломжтой**  
-Гадаад паспортод чипийг хэрхэн суулгах вэ?  
-Манайхан одоо хэрэглэж байгаа иргэний үнэмлэхтэй адил

төсөөлж байгаа байх. Гадаад паспортын эхний хуудсанд чипийг байрлуулдаг юм.  
-Үнийн хувьд хэдэн төгрөг байх вэ?  
-Одоохондоо үнэ ханшийг нь тогтоогоогүй байна. Бэлдцийн үнийн хувьд хуучин паспортоос мэдээж ялгаатай.  
-Шинэ паспортыг хаана хийлгэх вэ?  
-Унгар улсын “Мөнгөн тэмдэгт” хэвлэлийн хувьцаат компани нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм билээ. Үйл ажиллагааны менежментийн систем нь чанарын ISO 9001, хүрээлэн буй орчны ISO14001, мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 зэрэг холбогдох стандартын дагуу явагддаг. Мөн аюулгүй байдлын менежментийн гэрчилгээтэй, арвин туршлагатай компани байгаа. [ЗГМ]

### УЛААНБААТАР Ахмадууд үнэгүй сувилуулна

Хүндэт донор, ахмад настнууд рашаан сувилалд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр амарч сувилуулдаг байсан бол шинэ хууль хэрэгжиж эхэлснээр 100 хувийн хөнгөлөлт эдлэх аж. Мөн хиймэл шүд хийлгэсний төлбөрийг таван жил тутамд нэг удаа авдаг байсан бол хугацааг богиносгож гурван жилд нэг удаа байхаар болгожээ. Ахмад настанд хөнгөлөлттэй үнээр эм олгох, хөнгөлөлттэй

үнээр олгох эмийн нэр төрөл, хэмжээг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна. Хөдөө орон нутгийн ахмадууд нийслэлд ирээд нийтийн тээврийн хэрэгсэлээр үнэ төлбөргүй зорчих боломжгүй байгаа асуудлыг Засгийн газраас холбогдох журмыг гарган зохицуулахаар болсон байна. Дээрх ажлууд нь ирэх долдугаар сараас хэрэгжиж эхлэх юм. [ЗГМ]

### Галын дуудлага буурчээ



Баярын өдрүүдэд Нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэжээ. Нийслэлийн хэмжээнд объектын гал түймрийн 41, ахуйн болон техникийн холбогдолтой ослын ирж Аврах анги, гал түймэр унтраах ангиудын бүрэлдэхүүн шуурхай ажилласан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36.9 хувиар буурсан

үзүүлэлт гэж нийслэлийн онцгой байдлын газраас мэдээлэв. Тухайлбал, энэ сарын 02-ны өдөр Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо Согоотын 17 дугаар гудамжинд байшин шатсан дуудлагаар Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр ангийн бүрэлдэхүүн шуурхай ажиллаж гал түймрийг унтраасан. Мөн түймрийн бүсээс бага насны гурван хүүхдийг гаргаж амь насыг нь аварчээ. [ЗГМ]

### Баянгол эрүүл мэндийн жишиг дүүрэг болно

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг дарга С.Одонтуяа мэдээлэл хийж, 100 хоногт хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагналаа. Тус дүүргийн ЗДТГ өнгөрсөн 100 хоногт сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн сургуульд хамрагдах идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд дүүргийн 77, 95, 242 дугаар цэцэрлэгт өргөтгөл, шинэ барилгын ажлыг эхлүүлсэн байна. Түүнчлэн дүүргийн ахмад настны нөхөн сэргээх болон хүүхдийн эмнэлгийн барилгын ажлыг бүрэн засварлан дуусгаж, харааны бэрхшээлтэй иргэдийн орон сууцны асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлжээ. Дүүргийн хүүхэд залуучууд руу чиглэсэн хэд хэдэн томоохон ажлыг амжилттай эхлүүлж тодорхой үр дүнд хүрээд байгааг ч дүүргийн Засаг дарга С.Одонтуяа

онцолсон юм. Тухайлбал, Техник, технологийн дээд сургуультай хамтран ЕБС-ийн сурагчдыг инженер сэтгэлгээтэй болгох, мэргэжлээ зөв сонгоход туслах зорилгоор “Ирээдүйн инженерүүд” хөтөлбөрийг санаачлан сурагчдыг Япон улсын Коосэн сургалттай танилцуулан, япон багш нараар хичээл заалгаж эхэлжээ. Үүнээс гадна тус дүүрэг “Эрүүл дүүрэг” хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аж. Энэ хүрээнд эрүүл мэндийн жишиг дүүрэг болох зорилт тавьжээ. Түүнчлэн ахмад настанд зориулсан нөхөн сэргээх эмнэлэг болон хүүхдийн 100 ортой эмнэлгийн барилгыг амжилттай дуусгаад нээлтээ хийхэд бэлэн болсон байна. Мөн хараагүй иргэдэд зориулсан 90 айлын орон сууц барьж буйгаа тэрбээр тодотгов. [ЗГМ]

### ЗГМ: ИНФОГРАФИК



### ОРОН НУТАГ Шүлхийтэй тэмцэхэд 30 сая төгрөг шаардлагатай

Зүүн гурван аймагт малын гоц халдварт өвчин гарсантай холбогду ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, онцгой байдлын хурандаа Б.Мандахгэрэлээр ахлуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй

баг Хэнтий аймагт ажиллаж байна. Зарим суманд малын эмчийн хүрэлцээ муу, зам даваа цасанд боогдсоноос болж вакцинажуулалт тааруу хийснийг орон нутгийнхан Ажлын хэсгийнхэнд дуулгажээ.

Тус аймгийн Өмнөдэлгэр суманд 160 мянган тун вакцин шаардлагатай байгаа аж. Иймээс бусад аймгийн нөөцөд байгаа вакцинаас хангахаар болжээ. Малын өвчинтэй тэмцэх ажилд аймгаас 64 сая төгрөг зарцуулаад

байна. Цаашдаа ч хөрөнгө мөнгө нэлээд шаардлагатай байгаа тул Улсын Онцгой комиссоос Хэнтий аймагт шүлхий өвчинтэй тэмцэх зардалд 30 орчим сая төгрөг хуваарилах саналыг Засгийн газарт хүргүүлжээ. [ЗГМ]

### Энхийг сахиулагчид 50 хүний амь аварчээ

Өмнөд Суданы Бентью хотноо энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй Монгол Улсын батальоны цэргүүд дотоодын дүрвэгч 50 хүний амь насыг

болзошгүй аюулаас аварсан талаар UBMISS-д мэдээлжээ. Өмнөд Судан дахь НҮБ-ын төлөөлөгчийн газрын тэргүүн Дэвид Ширэр хэлэхдээ монгол

цэргүүдийн энгийн иргэдийг болзошгүй аюулаас шуурхай ажиллан аварч хамгаалсан эр зоригийг магтсан аж. Төлөөлөгчийн мэдэгдсэнээр,

лхагва гарагийн үдэш фермийн ойролцоо цэргийн хувцастай хүмүүс дотоодын дүрвэгч 11 иргэнийг зодож, биед нь халдсан байна. [ЗГМ]

#### "Цэгц капитал ББСБ" ХХК-ийн 2015.12.31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ /млн.төг/

"ЦЭГЦ КАПИТАЛ ББСБ" ХХК ҮЗҮҮЛЭЛТ	2014.12.31	2015.12.31
<b>А.БАЛАНС</b>		
Мөнгөн хөрөнгө	47,550,405	64,777,300
Эзэл дэвхээр/	345,000,000	352,000,000
Бусад авлага	12,600,000	11,400,000
Эргэлтийн хөрөнгийн дүн	405,150,405	428,177,300
Үндсэн хөрөнгө /дээр/	3,413,856	2,962,525
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,413,856	2,962,525
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	408,564,260	431,139,825
Богино хугацаат өр төлбөр	-	7,053,921
Бусад өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	7,053,921
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	7,053,921
Энгийн хувьцаа	400,000,000	400,000,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	8,564,260	24,085,904
Эзэмшигчдийн өмчийн дүн	408,564,260	424,085,904
НИЙТ ӨР ТӨЛБӨР	408,564,260	431,139,825
<b>Б.ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>		
Хүүгийн орлого	143,400,000	68,313,600
Хүүгийн зардал	-	19,549,386
Цэвэр хүүгийн орлого	143,400,000	48,764,215
Хүүгийн бус орлого	-	-
Хүүгийн бус зардал	33,338,783	-
Цэвэр хүүгийн бус орлого/зардал дүн	(33,338,783)	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг/ алдагдал	110,061,218	48,764,215
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	110,061,218	15,766,159
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-
Ердийн үйл ажиллагааны ашиг/ алдагдал	110,061,218	32,998,065
Ердийн бус орлого	-	-
Ердийн бус зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал	110,061,218	15,766,159
Орлогын татварын зардал	4,876,421	4,876,421
Цэвэр ашиг/ алдагдал	105,184,796	28,121,644
<b>В. ӨМЧИЙН ӨӨРЦӨЛГИЙН ТАЙЛАН</b>		
Эхний үлдэгдэл	400,000,000	408,564,260
Нэмэгдсэн	8,564,260	28,121,643
Хоргогдон	-	12,600,000
Эцсийн үлдэгдэл	408,564,260	424,085,903
<b>Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b>		
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	17,226,895
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	17,226,895

## Экологи

**Жилд гарч буй түймрийн тоо 150-иас буурахгүй байна**


З.Цэлмэг  
@tselmegZGM

Байгаль экологи болон нийгэмд үлэмж хэмжээний хохирол учруулдаг түймрийн улирал ойртож байна. Оншгой байдлын ерөнхий газрын өгсөн мэдээллээр өнгөрсөн сарын 25-нд Ховд аймагт нуурын зэгэс шатаасан мэдээлэл бүртгэгджээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хуурайших, цөлжих үзэгдлийн давтамж ойртож байгаа нь түймэр гарах эрсдлийг улам нэмэгдүүлж буй. Энэ өөрчлөлтийн нөлөөллийг доктор П.Гомболүүдэв судалдаг юм. Тэрбээр “Эль-нино үзэгдэл манай орны уур амьсгалд дам байдлаар нөлөөлж буйг сүүлийн үед ажиглаж байна. Түүхээс харвал, 1997-1998 онд хамгийн хүчтэй Эль-нино үзэгдэл нь тохиосон. Харин үүний дараа 1999-2002 онд манай орны нийт нутгийг хамарсан их халалт болсон. Энэ үед ган, зудаас гадна их хэмжээний түймэр гарсан юм. Үүнээс үзвэл, энэ зунаас мөн хэдэн жил үргэлжлэх халалт эхлэх магадлалтай” хэмээн онцлов.


Харин Байгаль орчны яамны түймрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Чулуунбаатар “Өнөөдрийн байдлаар түймрийн I, II бүс цасан бүрхүүл ихтэй байна. Урьд жилүүдтэй харьцуулахад чийгийн хэмжээ харьцангуй их байгаа тул энэ жил түймрийн аюулын хугацаа нэлээд жожуу эхэлж магадгүй. Гэхдээ хуульд заасан хугацааны дагуу бэлтгэл ажлаа хангаж, Улсын онцгой комиссын албан даалгавар гарахыг хүлээж байна” хэмээв.

Түймэр нь хохирлоос гадна байгаль, биологийн төрөл зүйлд асар их сөрөг үр дагавар дагуулдаг. Ойн болон хээрийн бүсийн экосистемийг устгадаг төдийгүй агаар дахь хүчилтөрөгчийн тэнцвэрийг алдагдуулдаг аж. Түүнчлэн хөрсний бүтцийг ч өөрчилдөг. Ингэснээр хөрс салхи, бороонд



Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн

# Гурван жил үргэлжлэх халуун эхэлнэ



өртөмтгий болж, цаашлаад гол, нуурын тогтоцыг өөрчилдөг аж.

Ойн түймрийн бас нэг аюул нь мөнх цэвдгийг хайлуулдаг. Мөнх цэвдгээс гол чийгээ авдаг манай орны ой түймрийн улмаас цэвдэг нь хайлж, хатаж гандах эрсдэл өндөр юм. Түймэр гарвал хөрсөн дээр үүсэх 800 градусын халуун тэр чигтээ хөрсөнд нэвчдэг байна.

Сүүлийн гурван жилд манай оронд гарсан нийт түймрийн улмаас экологид 80 гаруй тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Үүнээс гадна долоон хүн амиа алдаж, 25 хүн түлэгдэж, эд материалын таван тэрбум гаруй төгрөгийн хохирол амссан байна.

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Зайнаас тандан судлах хэлтсийн дарга М.Одбаярын хэлж буйгаар жилд гарч буй түймрийн тоо 150-иас буухгүй байгаа аж. Мөн нийт түймрийн 95 хүртэлх хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байдаг гэдгийг салбар хариуцсан яамны эх сурвалж дурдав. Тиймээс одооноос иргэд, олон нийтэд түймрээс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээллийг хуурайшилтын улирал эхлэхээс өмнө өгч байх хэрэгтэйг салбарын төлөөлөл учирлаж байна. [ЗГМ]

### АНТИ-ЭКО

## Хулгайн анчныг 155 мянган ам.доллараар торгов

Нэн ховордсон сибирин бар, ховор зүйлийн шувуу, зэрлэг амьтдыг олноор нь устгаж, байгаль орчинд учруулсан хохирлыг нь барагдуулах зорилгоор Оросын нөлөө бүхий бизнесмен Евгений Романовт шүүхээс их хэмжээний мөнгөн торгууль ногдууллаа.

Цагдаа нар Находка хотод байрлах гэрээ нь Оросын зүүн бүс нутгийн уугуул амьтад болох барын арьс зургаа, гималайн болон хүрэн баавгийн 40 гаруй эд эрхтэн илрүүлсэн байна. Энэ бүгд хулгайгаар агнасныг нь илчлэх эд мөрийн хангалттай нотолгоо болж буй аж. Түүнчлэн хөлдөөгчөөс нь Зүүн хойд Азиар нутагладаг стеллерийн нөмрөг бүргэд, тас болон хятад галуу илрүүлжээ. Мөн долоон бор гөрөөс торонд хорьсон байв.

Романовын гэрт 2012 оны дөрөвдүгээр сард нэгжлэг хийхэд дээрх зүйлсийг илрүүлсэн ч шүүхийн яллах шийдвэр одоо л гарч байгаа аж. Түүний хууль бус ангийн тухай мэдээлэл ил болсноос хойш ОХУ зэрлэг ан, амьтдыг хамгаалах хууль тогтоомжоо яаралтай чангатгасны дүнд нэн ховор цоохор ирвэс, сибирин барын тоо толгой өсөж буй.

Харин торгуулийн хэмжээ нь байгаль орчинд учруулсан хор хохирлыг барагдуулахад Приморскт хамгийн өндөрт тооцогдох хэмжээ болсон гэдгийг Орос дахь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн сибирин бар хариуцсан хуулийн ахлах мэргэжилтэн Ольга Зеребкина онцлолоо. Тэрбээр

“Байгаль орчны тухай хуулиудыг сахиулахад түүхэнд тэмдэглэхүйц шийдвэр гаргалаа. Гэхдээ хууль бус агнуурын цар хүрээ асар том. Байгаль эх бүхэл бүтэн зургаан бар, маш олон зэрлэг амьтнаа алдлаа шүү дээ” гэв. Түүнчлэн зэрлэг амьтныг хууль бусаар агнах хууль журмаа улам чангатгах ажиллаж буйгаа Сибирин бар төвийн Алс дорнод дахь салбарын захирал Сергей Арамлиев хэлэв.

Романовын хэргээс гадна 2012 онд Арсеневийн гэх дуулиант хэрэг мөн болж байсан юм. Уг хэргийн зуучлагч этгээд барын найман арьс дамлан худалдсан хэргээс чимээгүйхэн бултсан нь хулгайн ангийн эсрэг хууль тогтоомжоо чангатгах шаардлагатайг харуулсан байна. [ЗГМ]

### ЗӨВЛӨГӨӨ

## Улаан чинжүүгээр ургамлаа арчлаарай

Тасалгааны ургамлаа хөнөөлт арми болох хортон шавьжнаас салгахын тулд улаан чинжүүний хандыг шингэлэн шүршихэд үр дүнтэй.

Сэтгэл, цаг хугацаа, хүч хөдөлмөрөө зориулан, гэрт тань таатай уур амьсгал бүрдүүлэх ногоон ургамлууд бөөс, аалзан хачиг, цагаан далавчтан гээд нэлээд олон төрлийн хортонд нэрвэгддэг. Энэ бүхэнтэй тэмцэхийн тулд нэг кг улаан чинжүүг 10 литр усанд хийж, нэг цаг буцалгаад битүү саванд нэг хоног байлгана. Дараа нь



чинжүүгээ нухаж шүүгээд, долоо дахин шингэлээд дайсны армид шүршихэд бактерлогийн зэвсэг мэт үйлчилдэг байна.

Үүнээс гадна тамхины болон хүчиллэг жимс, балжингарам, савангийн уусмал үр дүнтэй.

Тамхины 400 гр нунтгийг нэг литр усанд хийнэ. 24 цаг дэвтмэгц нэг цаг буцалгаж шүүгээд, таван гр барааны саван хийж нэг литр болтол нь усаар арвижуулаарай. Энэ уусмал нас бие гүйцсэн бөөс, хачиг төдийгүй залуу навч, ишний шүүсийг сорогч “нялх вампир”-уудыг ч устгадаг.

Хэрэв хортон шавьж харьцангуй цөөн үүрлэсэн бол гардан тулалдсан ч болно. Гэхдээ хөнөөлт дайсан залуу цэцэг, навчийг илүү гэмтээж, маш хурдан үрждэг гэдгийг санахад илүүдэхгүй. [ЗГМ]

### СОНИРХУУЛАХАД

## Талх дэлхийн дулааралд нөлөөлдөг

Нэг зүсэм талх тариан талбайгаас эхлээд дэлгүүрийн лангуу, цаашлаад хавчуургатай идэш болох хүртлээ байгаль орчинд ямар нөлөө үзүүлдэг судлаачид тооцоолжээ.

Ур тариаг нь ургуулахад хэрэглэдэг азотын нитратын бордоо азотын исэл их хэмжээгээр ялгаруулдаг байна. Тиймээс талхны үр хүлэмжийн хийг бүрдүүлэгч азотын исэл ялгаруулдаг нь байгаль орчинд үзүүлдэг буй хамгийн том сөрөг нөлөө аж. Бордоо нь хөдөө аж ахуйгаас ялгаруулж буй хүлэмжийн хийн 43 хувийг бүрдүүлдэг аж. Харин дэлхийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбар хамгийн их хүлэмжийн

хий ялгаруулагч салбар болдог юм.

Энэ талаар судлаачдын багийн ахлагч доктор Лиам Гаучер “Арвин ургац авахын тулд тариачид ахиу бордоо хэрэглэж буйгаас зүсэм талх бүр дэлхийн дулааралд хувь нэмэр оруулж байна” хэмээн дүгнэв. Тэрбээр BBC News-д ярихдаа “Хүн бүр талх хэрхэн бүтдэгийг мэддэг. Гэхдээ байгаль орчинд ямар нөлөө үзүүлдэг талаарх ойлголт бага юм. Өөрөөр хэлбэл, хүлэмжийн хийн ялгарлын хэдэн хувийг талх бүрдүүлдгийг мэдэхгүй” гэжээ. Дэлхий дахинаа нийт ургацын 60 хүртэлх хувьд метан, нүүрстөрөгчийн давхар исэл,

аммиак, азот зэрэг химийн гаралтай бордоо хэрэглэж байна. Нийлэг бордоо ургамлын ургалтыг тэтгэж, өгөөжийг нэмэгдүүлэх хэдий ч дэлхийн дулаарлын шалтгаан болсон хүлэмжийн хийг их хэмжээгээр ялгаруулдаг аж.

Профессор Петер Хортон “Жил тутам 100 сая гаруй тонн нийлэг бордоо тариалангийн гарц нэмэгдүүлэхэд ашиглаж байгаа нь ноцтой том асуудал. Харамсалтай нь, энэ бүхний экологийн үнэлгээг гаргадаг тогтолцоо алга. Тиймээс энэ салбарынхан бордоогоо хянаж, хамаарлаа багасгах бодитой санаачилгагүй байна” гэв. [ЗГМ]

**МЭГЭЭ**  
СОНИН АМХ

**НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА**

**ДИЗАЙНЕР:**

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

**ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:**

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:**

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөгдөх болон  
baasan.b@zasag.co и-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

## ЗГМ: Зочин

# Эдийн засаг сэргэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна

**ОУВС-гийн хөтөлбөр хүнд байдлаас гаргах сонголт**

**Б.Баяртогтох**  
@bayartogtokh

*МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш Б.Алтан-цэцэгтэй "Хэрэглэгчийн итгэлийн индекс" судалгааны үр дүн болон ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд ярилцлаа. "Төсвийн сахилга батыг сайжруулах нь хамгийн чухал төдийгүй тулгамдаж буй сорилт болж байна" хэмээн тэрбээр тодотгов.*

**-Хэрэглэгчийн итгэлийн индекс хамгийн сүүлд ямар өөрчлөлт гарсан бэ. Иргэд эдийн засгийн байдлыг ойрын хагас жилд хэр өдрөг харж байна вэ?**

-Хувийн хэрэглээний зардал дотоодын нийт бүтээгдэхүүний хамгийн том бүрэлдэхүүн хэсэг байдаг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн хамгийн том худалдан авагч нь монголын нийт өрхүүд. Албан ёсны статистик үзүүлэлтээр өрхийн хэрэглээ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 60 орчим хувийг эзэлж байна. Өрхүүдээс авдаг хэрэглэгчийн итгэлийн индекс нь 2016 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 78.4 болсон байна. Энэ нь 2015 оны мөн үетэй харьцуулахад 15.5 хувиар өссөн дүнтэй гарлаа. Итгэлийн индексийн энэ өөрчлөлтөд судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох хүлээлтийн индексийн эрс өсөлт нөлөөлсөн. Иргэдийн дунд оны эхний хагаст эдийн засгийн байдал сэргэж, нөхцөл байдал сайжирна гэсэн хүлээлт давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйд эдийн засагт гарах өөрчлөлтийг илүү эерэг гэж өрхүүд дүгнэлээ.

**-Өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж байна вэ?**

-Иргэд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг өнөөгийн байдлын индекс илтгэдэг. Уг индекс жилийн хугацаанд 10.3 нэгжээр буурч 22.3 болсон. Өнөөгийн байдлын индексийн бууралтад бизнесийн орчны нөхцөл байдал тааруу, ажлын олдоц муудсан нь нөлөөлсөн.

**-Иргэдийн худалдан авалтын төлөвлөгөөнд томоохон өөрчлөлт гарсан уу. Ойрын хугацаанд хандлага хаашаа чиглэж байна вэ?**

-Өрхүүдээс ирэх зургаан сарын хугацаанд орон сууц, газар, гэр зэрэг үл хөдлөх хөрөнгө, автомашин, цахилгаан бараа болон аялал жуулчлалын үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж буй эсэх, талаар мэдээлэл авдаг. Өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын байдлаар энэ оны эхний хагаст худалдан авалтын хандлага 2015 онтой харьцуулахад эерэг гарсан. Энэ нь хандлага нааштай байна гэсэн үг. Иргэд өмнө нь худалдан авалтаа танах чигтэй байсан бол ойрын зургаан сард худалдан авалтаа тэлэх хандлага ажиглагдаж байна. Ялангуяа, томоохон эд хогшил худалдан авах сонирхол нь нэмэгдсэн. Удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүн худалдан авалтын буурах хандлага эсрэгээрээ эргэсэн.

**-Манай улсын эдийн засаг өнгөрсөн онд 1.1 хувиар өссөн. Энэ нь Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны таамгаас харьцангуй өндөр дүнтэй гарсан. Иргэдийн хүлээлт эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай юу?**

-Өрхүүд өөдрөг байх үе буюу хэрэглэгчийн итгэлийн индекс 100-гаас өндөр байхад дотоодын



Б.Баяртогтох/ЗГМ

нийт бүтээгдэхүүний улирлын дундаж өсөлт 13 хувь байсан бол хэрэглэгчид гутранги байх үе буюу дээрх индексийн утга 100-гаас бага байхад дундаж өсөлт дөрвөн хувь байна.

Хэрэглэгчийн итгэлийн индексийн төлөв, хандлага эдийн засгийн өсөлт, бууралттай байнгын хамааралтай байж ирсэн. Итгэлийн индекс 2016 оны дөрөвдүгээр улирлаас сэргэж эхэлсэн. Хэрэглэгчийн өөдрөг байдал нэмэгдэж байна. Иргэдийн худалдан авалтын төлөвлөгөөнд нааштай өөрчлөлт гарч байгааг эхэнд тэмдэглэсэн. Чигийн хувьд өсөлт уруудах бус дээшилж байгаа.

**-Монгол Улс Олон улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-г хамрагдахаар болж байна. Таны хувьд хөтөлбөрт хамрагдах нь нэн шаардлагатай гэж үзэж**

**байна уу?**

-Өнөөдөр тулгамдаж буй асуудлаа шийдэх нэг гарц нь ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" болж байна. Уг хөтөлбөрт хамрагдсанаар өртэй холбоотой хүндрэлд нааштай нөлөө гарахаар байгаа. Богино хугацаанд эдийн засгийн одоогийн байдлыг сайжруулахад хөтөлбөр ашиг тусгаа өгөх нь дамжиггүй. Гэхдээ ОУВС-гийн хөтөлбөр нь хүндрэл, хямралаас манай улсын эдийн засаг нэг мөрг гаргах хэмжээний үр нөлөөг авчрах боломжгүй. Зөвхөн нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх, бодлогын алдааг засахад илүү ач холбогдол нь оршиж байгаа. Тиймээс хөтөлбөрт хэт найдах нь өрөөсгөл. Олон жилийн макро эдийн засгийн бодлогын гажуудал өнөөдөр дахин ОУВС-д хандахад хүргэсэн. Бид үүссэн нөхцөл байдлаа сайтар

үнэлж, алдаанаасаа сургамж авч, суралцаж чадахгүй байна.

**-Төсвийн өндөр алдагдал нь эдийн засгийн хүндрэлийн нэг шалтгаан болж байгаа. ОУВС-гийн хөтөлбөр төсвийн алдагдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийг сайжруулахад хэр нөлөөлж чадах вэ?**

-Төсвийн сахилга бат суларч, өрийн дарамт өнгөрсөн хугацаанд огцом нэмэгдсэн. Эдийн засаг халах хэрээр төсвийн зардлыг тэлж, алдагдлын хэмжээг жил ирэх тусам өсгөсөн. Эдгээр нь өнөөдрийн нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" нь төсвийн алдагдлыг дунд хугацаанд бууруулахаар байгаа. ОУВС-гийн зүгээс ч алдагдлаа хумих шаардлагыг Засгийн газарт тавьсан. Тэгэхээр төсвийн алдагдал ирэх жилүүдэд одоогийн түвшнээс буурч, эдийн засагт ирэх дарамт нь саарна гэсэн үг. Энэ нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлнэ. ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах болсон нь гадаадын хөрөнгө оруулагчдад сөрөг бус эерэг "messej" өгч байна. Манай улсын зээлжих зэрэглэл болон бондын үнэлгээнд уг хөтөлбөр тодорхой хэмжээгээр оноо нэмэхээр харагдаж байгаа.

**-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зарим татварын хувь хэмжээг одоо байгаагаас нь нэмэхээр болсон. Хэдийгээр энэхүү шийдвэр албажаагүй ч УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэх гэж байна. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа үед татвар нэмэх нь буруу гэсэн байр суурьтай эдийн засагч цөөнгүй. Та үүнтэй санал нийлэх үү?**

-Манай улсад нөхцөлөө сайжруулах боломж хэлэлцээрийн явцад хэр байсныг сайн мэдэхгүй юм. Одоогийн нөхцөл нь магадгүй хамгийн боломжтой хувилбар байсныг үгүйсгэх аргагүй. Үүнээс өөр нөхцөлөөр хөтөлбөрт хамрагдах боломж байсан уу, үгүй юу. Энэ болгоныг дэнсэлж үзэх хэрэгтэй байх. Нөхцөлийн хувьд хатуу, зөөлөн гэж дүгнэхэд эрт байна. Ер нь татварыг шатлалтай болгох

хэрэгтэй. Манайх шиг санхүүгийн сахилга бат муутай эдийн засагт татварын шатлал нь нэг талаар автомат тогтворжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь сангийн бодлогод эерэг нөлөө авчирна.

» Богино хугацаанд эдийн засгийн одоогийн байдлыг сайжруулахад хөтөлбөр ашиг тусгаа өгөхөөр байна.

» Төсвийн сахилга бат суларч, өрийн дарамт өнгөрсөн хугацаанд огцом нэмэгдсэн.

» Хэрэглэгчийн итгэлийн индексийн төлөв, хандлага эдийн засгийн өсөлт, бууралттай байнгын хамааралтай байж ирсэн.

**-Мөнгөний бодлогыг цаашид хатуу хэвээр хадгалах нь оновчтой гэсэн дүгнэлтийг ОУВС хийсэн. Монголбанкны мэдэлд байсан найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг Засгийн газарт шилжүүлэхээр болж байна. Мөнгөний бодлого хатуу төлөвт байх нь эдийн засаг, бизнесийн орчинд сөрөг нөлөө ихтэй биш гэж үү?**

-Төсвийн алдагдал хэт өндөр байгаа нь мөнгөний бодлогын хүүг бууруулах орон зайг өнгөрсөн хугацаанд хумьж ирсэн. Бодлогын хүү өндөр байгаагийн нэг шалтгаан нь төсвийн хоёр оронтой алдагдлаас гадна төсвөөс гадуурх санхүүжилт зохистой хэмжээнээсээ хэтэрсэнтэй холбоотой. Түүнчлэн төгрөгийн ханш сулрах, гадаад валютын нөөц буурах дарамт одоо хүртэл байсаар байна. Эдгээр нь мөнгөний бодлогын хүүг 14 хувьд хадгалах, хатуу байлгахад хүргэж байгаа. Төсвийн алдагдал буурч, өрийн дарамт аажмаар багасах үед мөнгөний бодлогын хүүг өөрчлөх болов уу. Эдийн засагт юуны өмнө тогтвортой байдал хамгийн чухал болоод байна.

**-Эдийн засаг, бизнесийн орчинд төрийн оролцоо хэр**

**их байна вэ. Энэ нь хүндрэл, хямралын эх сурвалж мөн үү?**

-Төрийн оролцоог эдийн засаг, бизнесийн салбарт хязгаарлах хэрэгтэй байна. Үндсэн үүргээ төр биелүүлж чадахгүй байж эдийн засаг, бизнес, шүүхийн харилцаанд гэр дүрэх нь олширсон. Угтаа өнөөдрийн хүндрэл, хямралын үндсэн эх сурвалж нь төр гэдэгтэй санал нэг байна. Төрийн оролцоо бизнесийн орчинд тогтворгүй байдал үүсгэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг үргээх болсон. Мөн зарим хуульд тооцоо судалгаа, үндэслэл муутайгаар өөрчлөлт оруулж байгаа нь дээрх байдалд сөргөөр нөлөөлсөн. Иргэд болон хувийн хэвшил өөрт буй боломж, нөхцөлд арь болохуйц тохирох бодлого, менежментийг хэрэгжүүлж байна. Бүсээ чангалах байдалд хүргэж байгаа нь манай бодлого тодорхойлогчдын олон жилийн турш төсвийн сахилга батгүй байсны уршиг. Үүнээс болж нөхцөл байдал хүндэрч байна. Эдийн засаг доройтоход төрийн хариуцлагагүй байдал, бодлогын алдаа гол үүрэг гүйцэтгэсэн. Тиймээс алдаа, дутагдлаа бодитой харах нь чухал. ОУВС-гийн хөтөлбөр бол хүнд байдлаас гаргах сонголт төдийгүй богино хугацааны шийдэл.

**"Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжлээ гэхэд эхний ээлжинд 440 орчим сая ам.доллар манай эдийн засагт орж ирэхээр байгаа. Хөтөлбөр авах сургаар ам.доллар болон бусад валютын ханш ялимгүй буурч байна. Дунд болон урт хугацаанд төгрөгтэй харьцах ам.долларын ханш тогтвортой байх боломжтой юу?**

-Богино болон дунд хугацаанд ам.долларын ханш бага зэрэг буурах, улмаар тогтвортой байх боломж, нөхцөл харагдаж байгаа. Гэхдээ урт хугацаанд хөтөлбөрийн нөлөө ханшийн хувьд гарах нь эргэлзээтэй. Учир нь, манай улс ойрын хугацаанд их хэмжээний гадаад өр төлбөрийг эргэн төлөхөөр байгаа. Энэ нь валютын нөөц болон ханшид томоохон дарамт болох бодит эрсдэлийн нэг. [ЗГМ]

## Шилдгүүдийг нэг дороос...

**ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ  
2017 ОНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА.  
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 30,000₮**

УЛИРАЛД

**64 ДУГААР**



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co  
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

## Лавлах

## ЗӨВЛӨГӨӨ

Сав, баглаа  
боодол дээрх  
тэмдэглэгээБ.Бямба  
ЗГМ

- ▲ Энд задална Зөвхөн сум заасан газар задална
- ✶ Дэгээдэж болохгүй Бараа ачихдаа дэгээ хэрэглэхийг хориглоно
- ☞ Ачааг өргөх зориулалтын бэхлэгээний гинж, татлага зэргийг байршуулах газрыг заана
- ✂ Ачааны тэргэ дээр тавихыг хориглоно Энэхүү тэмдэг тавигдсан хэсгээр ачааны тэргэн дээр өргөж тавих, тээвэрлэхийг хориглоно
- ☒ Давхарлахыг хориглоно Энэ тэмдэг тавигдсан тохиолдолд дээр нь өөр ачаа давхарлаж өрөхгүй [ЗГМ]

## БОЛОВСРОЛ

## Туркийн тэтгэлэг зарлагдлаа

Турк Улсын Засгийн газрын 2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын тэтгэлэгт хөтөлбөр зарлагдлаа. Хамрагдах хүсэлтэй иргэд энэ сарын 1-31-нд www.turkiyeburslari.gov.tr цахим хаягаар бүртгүүлэх боломжтой.

Дэлхийн 150 гаруй орны 5000 орчим залууст тэтгэлэг олгодог энэхүү хөтөлбөрийн бүртгэлт зөвхөн цахим хэлбэрээр явагддаг юм байна. Тэтгэлэгт 1996 оны нэгдүгээр сарын 1-нээс хойш төрсөн, дунд сургуулиа төгссөн, эсвэл энэ жил төгсөх хүмүүс хамрагдах эрхтэй. [ЗГМ]

## СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Мөс цөмрөх аюултай

Хүйтний эрч суларч, гол, мөрөн, нуурын мөсний нягт багасч байгаа тул иргэд мөсөн дээгүүр явганаар болон автомашинтай зорчихгүй байхыг ОБЕГ-аас анхааруулж байна. Түүнчлэн мөсөн дээгүүр мал туух, тээвэр хийхгүй байхыг санууллаа.

Хөдөө орон нутгийн хүүхдүүдийн хичээлийн амралт харахан дуусаагүй байгаа тул амралтын өдрүүдэд эцэг, эх, асран хамгаалагчид нь бага насны хүүхдийг хараа хяналтгүй явуулахгүй байх хэрэгтэй. Мөн иргэд хол, ойрын замд зорчихдоо тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг сайтар хангаж, дулаан хувцас, шатахууны нөөцтэй явахыг анхааруулав. [ЗГМ]

## Мах, малын гаралтай түүхий эд тээвэрлэх хориглов

Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий, хонины цэцэг өвчний тархалт нэмэгдэж байгаагаар холбогддог уулын хөвдүүр мэргэдсэнээс бусад аймаг, суманд малын гоц халдварт өвчин тархах эрсдэлтэй байжээ. Харин даваа гарагаас эхлэн уг хязгаарлалтыг цуцалж, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг чөлөөтэй болголоо. Гэхдээ мах, малын гаралтай түүхий эд тээвэрлэхийг хориглосон хэвээр байгаа юм. [ЗГМ]

## ТВ ХӨТӨЛБӨР

ТВ	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	08.10 "Царманд дассан 1000 сарлаг" Архангай аймгаас бэлтгэв	07.00 Америк хэрхэн ажилладаг вэ?	08.05 ЕБС-ийн теле хичээл	06.30 "Өнөө өглөө" хөтөлбөр
12.00	11.20 "Эргэх дөрвөн цаг" Ховд аймгаас бэлтгэв	11.00 Ногоон хот	12.05 "Василий Сталин" ОАК 5, 6 дугаар анги	10.30 "Эмч нар" СОАК 16 дугаар анги
14.00	14.00 "Баасан гараг" цэнгээнт нэвтрүүлэг	15.00 "Бизнесийн төв цэг" хөтөлбөр	14.40 "Монголчууд нийгэм журамд давшин орсон нь" 11 дүгээр цуврал	14.00 Ан амьтдын ертөнцөөр 14 дүгээр анги
18.00	17.45 Соно студи: "Маамуу нааш ир"	17.00 Bloomberg Surveillance	17.00 "Агуу бүтээн байгуулалт" баримтат кино 12 дугаар анги	17.30 "Тог тог тог" 92 дугаар хэсэг
20.00	21.05 "Аглаг бүтээлийн хийд" Оюун санааны бүтээлээр аялахуй	20.00 Made in Mongolia: Эко гэр цэцэрлэг	20.40 "Mongolia's next top model" тойм	19.00 "Ромын түүх" баримтат кино нэгдүгээр анги
22.00	21.50 "Сайхан Серафима" Оросын УСК 3,4 дүгээр анги	22.00 Эзэнт гүрнийг богссон нь	21.00 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг	22.30 "Скандал" ОАК 10 дугаар анги

## ОНЦЛОХ ҮЗВЭР

## Инди урсгалын Braids хамтлаг ТОГЛОЛТОО ХИЙНЭ



2016 оны Канадын хөгжмийн дээд шагнал болох "Juno Awards"-ын оны шилдэг альтернатив цомог төрөлд ялсан Braids хамтлаг энэ сарын 11-нд Улаанбаатар хотод анхны тоглолтоо хийхээр боллоо. Indie rock, Indie pop, Art rock, Experimental rock сонирхогч залууст зориулж буй юм. Уг тоглолтод Монголын шилдэг амьд хөгжмийн хамтлагууд оролцоно. Тодруулбал, The Lemons, Magnolians, Futuroma, Even Tide, The Compass хамтлаг байна. Braids нь 2007 онд Канадын Кальгари хотод байгуулсан гурван хүний бүрэлдэхүүнтэй Experimental Pop, Indie Art Rock урсгалаар тоглодог хамтлаг юм. [ЗГМ]

## ҮЗВЭР



Алдарт зохиолч У.Шекспирийн "Ромео, Жулета" үзэнч хайрын жүжгийг энэ сарын 7, 8-нд 19.00 цагт тоглоно.

## УЛААНБААТАР ЧУУЛГА

СТА, Улаанбаатар чуулгын гоцлол хөгжимчин, хийлч Ч.Дэлгэрцэцэгийн ээжүүдийн өдөрт зориулсан "Хайр" тоглолт өнөөдөр 19.00 цагт болно.

## УЛСЫН ФИЛАРМОНИ

"Бүсгүй минь инээмсэглэж яваарай" олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулсан тоглолтыг энэ сарын 8-нд 19.00 цагт толилууна.

## THE CORPORATE HOTEL &amp; CONVENTION CENTER

Морин хуурын чуулгын "Playing Love" Монголын болон дэлхийн киноны шилмэл хөгжмийн концерт энэ сарын 8-нд 19.00 цагт болно.

"Харанга" хамтлагийн дуучин, МУГЖ Х.Лхавасүрэн энэ сарын 8-нд "Үзэсгэлэнт минь" тоглолтоо хийнэ. Тоглолтод "Хар сарнай" хамтлагийн ахлагч С.Амараа, "Номин талст" хамтлагийн дуучин Т.Дэлгэрмөрөн нар оролцоно. Уг тоглолтод сүүлийн үед хит болсон "Үзэсгэлэнт минь", "Найз", "Толин хул" зэрэг дуунуудаа эгшиглүүлнэ.

## UB PALACE

"Баярлалаа ээжээ" хүндэтгэлийн дуун цэнгүүн энэ сарын 8-нд 15.00 цагт болно.

"Миний ээж хөөрхөн" зохиолын дуучдын нэгдсэн тоглолт энэ сарын 9-нд 19.00 цагт болно.

## ICINEMA

Magnolian хамтлаг бүрэн хэмжээний тоглолтоо ирэх сарын 7, 8-нд 19.00 цагт хийж гэж байна. Уламжлал ёсоор нарийн бүрээ, аргил хөгжим, ятга хөгжимчид байна.

## ЗУРХАЙ



## Билгийн тооллын 10

Хаврын тэргүүн хар бар сарын найман цагаан мэнгэтэй харагчин могой өдөр.

Үс засуулбал: Эрч хүч ихсэнэ.

Наран ургах, шингэх: 07.22-18.44

Барилдлага: Үхэх Шүтэн барилдлага: Сансар Суудал: Уул

## Аргын тооллын гуравдугаар сарын 7, Ангарга гараг. Билгийн тооллын 10, Хэргийн охин одтой, харагчин могой өдөр.

Өдрийн наран 07.22 цагт мандан, 18.44 цагт жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдвэ үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавуулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нэхэ, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохиистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч ихсэнэ.


## ГАЛТ ТЭЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
Эрээн-УБ	18:00	11:15
УБ-Хөх хот	20:00	20:49
Хөх хот-УБ	22:50	11:15
УБ-Сүхбаатар	21:15	05:12
Сүхбаатар-УБ	20:55	05:03
УБ-Эрдэнэт	20:30	07:45
Эрдэнэт-УБ	19:10	05:48
УБ-Замын-Үүд	17:20	07:05
Замын-Үүд-УБ	17:35	08:55
УБ-Зүүнхараа	17:30	21:45
Зүүнхараа-УБ	04:25	08:40
УБ-Сайншанд	09:15	19:15
Сайншанд-УБ	20:25	07:01

## НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	07:10	08:25
Бээжин-УБ	09:30	13:00
УБ-Токио	08:55	13:40
Токио-УБ	14:40	20:10
УБ-Сөүл	09:45	12:50
Сөүл-УБ	14:20	17:50
УБ-Хонконг	14:00	17:30
Хонконг-УБ	18:30	00:10

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



## БОСОГООР:

1. Монголын нэгэн телевиз
2. Шинжлэх ухааны олон салбарт нэвтэрхий, "Математикийн хаан" хэмээн алдаршсан их эрдэмтэн
3. "Надад тулах цэг өг, би дэлхийг эргүүлбэр" гэж хэлсэн эртний Грекийн агуу их эрдэмтэн
4. Хар тэнгистэй хүзүүвчээр холбогдог тэнгис
5. Хөгжмийн нот
6. Тэмүүжингийн загасыг булаасныхаа төлөө түүнд харвуулан алагдсан хүү
7. Мал маллаж аж төрдөг хүн
8. Өвөл нэг сард ороо нь ордог эцэг мал
9. Махан
10. Мал маллаж аж төрдөг хүн
11. Өвөл нэг сард ороо нь ордог эцэг мал
12. Махан

бүтээгдэхүүн 14. 1990 оноос өмнөх Монгол Улсын парламентын нэр 15. Зэвсэг

## ХӨНДЛӨНГӨӨР:


1. Монгол Улсын ХХ зууны шилдэг роман
2. Москвагийн уран зохиолын дээд сургуулийг өөрийнх нь нэрэмжит болгосон алдарт зураач
3. Нохойг турхирах үг
4. УИХ-ын гишүүн асан,

эрдэмтэн, доктор 16. 2.5 см-тэй тэнцэх хэмжээ 17. Бага насныхаа мөрөөдлөөр Монголын говиор аялсан Оросын алдарт зураач 18. Алдарт дуучин

## Өмнөх дугаарын хариу / 03.06



## ЗГМ: СҮДОКУ




4	6	5	3	2	7	8	1	9
9	2	1	8	5	4	7	3	6
3	8	7	9	1	6	2	4	5
7	1	9	2	8	5	4	6	3
8	3	4	1	6	9	5	7	2
6	5	2	4	7	3	1	9	8
5	4	8	6	9	1	3	2	7
2	9	3	7	4	8	6	5	1
1	7	6	5	3	2	9	8	4

(Өмнөх дугаарын хариу)

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР	III.07	III.08	III.09	III.10	III.11
Багавтар үүлтэй	-4° / 6 м/с -15° / 4 м/с	0° / 5 м/с -14° / 4 м/с	4° / 5 м/с -11° / 4 м/с	2° / 7 м/с -10° / 4 м/с	-2° / 7 м/с -11° / 4 м/с



## ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН....

Надад чамд өгчих хонь байхгүй ээ...

Надад ямар ч мөнгө байхгүй. Энэ Сарандавааг дээ!!!

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

NOMADIC COMICS

## Хятадын банкны актив Евро бүсийнхээс давлаа

Хятадын банкны актив хэмжээгээрээ дотоодын эдийн засгийн гарцаас 3.1 дахин их болжээ. > 10

## Нацист арга барилаас салаагүй гэв

"Герман чи ардчилалгүй. Бас ойр дотно ч биш юм. Та бүхний үйлдэл нацистуудын хийж байснаас ялгагдах юмгүй". > 10

## Европын хамгийн том ган үйлдвэрлэгчийн төлөөх тэмцэл эрчээ авчээ

Iiva-г худалдах нь Италийн эдийн засагт чухал тэнцвэрийг хадгалж мэдэх юм. > 10

# Варшав Тускийг зайлуулахаар эрмэлзэж байна

Польш хуучин Ерөнхий сайдаа албан тушаалаас нь зайлуулах зорилгоор өөр хүнийг нэр дэвшүүлсэнтэй уялдан Дональд Туск Европын Зөвлөлийн тэргүүнээр дахин сонгогдох боломж багаслаа.

Варшав нь Европын холбооны улс төрийн ажил үүрэг гүйцэтгэгч гол албан тушаалд Европын парламентын польш гишүүний нэрийг дэвшүүлжээ. Тус холбооны гишүүн улсууд ноён Тускийг дахин сонгох асуудлаар санал хураахаас хэдхэн хоногийн өмнө Варшав өөр хүний нэр дэвшүүлж байгаа юм.

Яцек Сариуш-Вольскийн нэрийг дэвшүүлсэн явдал нь ноён Тускийг пүрв гарагт болох уулзалтаар хоёр жил хагасын хугацаагаар улируулан сонгохоор төлөвлөж буй Брюссельд бэрхшээл учруулна. Грекийн өрийн сүйрэл, дүрвэгч цагаачдын урсгал, Brexit зэрэг хүчир үйл явдал өрнөсөн нөхцөлд Европын холбоонд албан үүргээ амжилттай гүйцэтгэлээ хэмээн гишүүн улсууд үнэлсэн тул ноён Туск бүр хоёрдугаар сард нэрээ дэвшүүлж буйгаа мэдэгджээ. Дахин сонгогдоход нь саад учруулж, өөр хүний нэр дэвшүүлсэн улс саяхан болтол гараагүй байв.

Ноён Тускийг гишүүн 28 улсын ихэнх нь дэмжиж байгаа учраас пүрв гарагт чуулах Европын холбооны уулзалтын үеэр Польш улсын сондгой байр суурийг сөрөх нь тулгамдсан асуудал боллоо хэмээн дипломатууд үзэж байна. Европын зөвлөлийн тэргүүний албанд ноён Сариуш-Вольскийн нэрийг дэвшүүлсэн нь бодлогогүй, "инээдтэй хэрэг" хэмээн Европын умардын нэгэн дипломатч тайлбарлаж байлаа.

Варшав удирдах албан тушаалд ажиллаж байгаагүй Сариуш-Вольскийн нэрийг дэвшүүлсэн нь ноён Туск, Польшийн эрх баригч Хууль зүй, Шударга ёсны намын тэргүүн Ярослав Качинскийн нарын хоорондох улс төрийн өрсөлдөөний илрэл юм. Ноён Туск Европын зөвлөлийг тэргүүлэх хугацаандаа Польшийн эсрэг хуйвалдаанд оролцсон хэмээн Варшав шүүмжилсээр

өдий хүрлээ.

"Засгийн газрынхаа эсрэг тэмцдэг хүний нэрийг дэвшүүлэх нь миний хувьд сэтгэлд багтамгүй хэрэг. Нөгөө талаар Засгийн газар нь дэмжихээ байсан хүнийг Европын холбооны бусад гишүүн улс дэмжээд байгааг би лав ойлгохгүй нь" хэмээн Польшийн Гадаад хэргийн сайд Витольд Вашиковский мэдэгдлээ. Тэрбээр ноён Тускийг Засгийн газрын эсрэг "гөрийн эргэлт" зохион байгуулахыг дэмждэг "Польшийн эрс сөрөг хүчний удирдагчдын нэг" хэмээн тодорхойлсон юм.

Өөрийнх нь нэрийг дэвшүүлсэн явдлыг зөвшөөрч байгаагаа ноён Сариуш-Вольский Twitter-т тайлбарлажээ. Тэрбээр "Эх орноо матан, хориг тавиулахад хүргэхийг хүлээн зөвшөөрөхгүй" хэмээн тайлбарласан нь ноён Тускийг битүү шүүмжилсэн хэрэг байв. Ноён Сариуш-Вольский нь 2004 оноос хойш Европын парламентын гишүүнээр ажиллаж иржээ. Тэрбээр мөн товч барууны байр суурь баримтлагч Европын ардын намын дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв.

Сүүлийн 10 жилийн турш, Польшийн дотоодод ноён Тускийн ширүүн өрсөлдөгч байсан ноён Качинский эдүгээ тус улсын эрх мэдлийг далдуур гартаа атгах боллоо. Тэрбээр ноён Тускийг Европын холбоог удирдахад тэнцэхгүй төдийгүй, тус холбооны зургаа дахь гол эдийн засагтай улсын ерөнхий сайдаар ажиллаж байхдаа хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг нь мөрдөн шалгах ёстой хэмээн битүү анхааруулж байна.

Ноён Качинскийн тэргүүлдэг баруун жигүүрийн нам 2015 онд засгийн эрхэнд гармагцаа тус улсын хуулийн тогтолцоо, төрийн өмчийн мэдээллийн хэрэгслийн менежментийг улс төрийн зорилгоор шинэчлэн өөрчлөх арга хэмжээ авсан. Польшийн үндсэн хуулийн шүүхийн эрх мэдлийг багасгах арга хэмжээг нь ардчилал, хууль ёсонд халдсан үйлдэл хэмээн Европын холбоо буруутгаснаас хойш Брюссель, Варшавын харилцаа эрс хүйтэрчээ.



АНУ, Өмнөд Солонгосын хамтарсан цэргийн сургуулиалтын үеэр Пхеньян пуужин харвалаа.

## Брайан Харрис, Кана Инагаки

Умард Солонгос даваа гарагт Япон тэнгисийн зүг дөрвөн пуужин харвасан нь бүс нутагт байдлыг хурцатгасан алхам болсон талаар Сөүл, Токиогийн албаны хүмүүс тайлбарлав. Дөрвөн пуужингийн нэг нь тив алгасах баллистик пуужин байж болзошгүй талаар Өмнөд Солонгосын цэргийн төлөөлөгч нарийвчилсан тайлбаргүйгээр мэдээлж байна. Уг мэдээлэл батлагдах аваас байдал ноцтой болж хувирна.

АНУ хүрэх, алсын тусгалтай пуужин хөөргөх чадвартай болсноо Пхеньян энэ нэгдүгээр сард зарласан. Тухайн үед Умард Солонгос уг чадвараа батлан харуулаагүй ч АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп эрс няцааж өгч байлаа. Тэрбээр "АНУ-ын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт хүрэх чадалтай цөмийн зэвсэг бүтээх ажил сүүдрийн шатандаа үеэж буйг Умард Солонгос сая мэдэгдлээ. Ийм юм тохиолдох учиргүй!" хэмээн Ерөнхийлөгч Twitter-тээ бичжээ.

Цагаан ордон өнгөрсөн сард Умард Солонгосын талаар баримтлах бодлогоо цогц хянаж үзсэн. Барак Обама халааг нь авч буй хүндээ Пхеньяны дэглэм гадаад бодлогынх нь тулгамдсан

асуудал байсан талаар өгүүлсний дараахан уг арга хэмжээг авсан юм. Ноён Трамп Ерөнхийлөгчийн алба хаших эхний дөрвөн жилд л Пхеньян АНУ-ын нутаг дэвсгэрт хүрэх чадвартай, цөмийн цэнэгт хошуу бүхий пуужин бүтээж амжина гэсэн бодол Вашингтон дахь шинжээчдийн дунд хүчтэй.

Ютай ч Умард Солонгос алсын тусгалт пуужин бүтээж амжсан байх магадлалыг Пентагон хэдийнэ тооцож эхэллээ. Сүүлийн жилүүдэд АНУ-ын тагнуулын байгууллагууд Умард Солонгосын хүч бололцоог байнга дутуу үнэлж ирсэн юм. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жэймс Мэттис Умард Солонгос цөмийн зэвсэг хэрэглэх боломжийг эрс эсэргүүцэж байгаагаа өнгөрсөн сард анхааруулсан. Ийм үйлдэл гарах тохиолдолд АНУ "Хүч түрэх" харуу барина хэмээн ноён Мэттис Сөүлд айлчлах үеэрээ мэдэгдлээ.

АНУ пуужингийн хөтөлбөрийг нь бусниулах зорилгоор Умард Солонгосын эсрэг кибер халдлага үйлдэх давтамжаа ихэсгэсэн талаар The New York Times сонин бямба гарагт мэдээлэв. Тус улс урьд нь Ираны цөмийн хөтөлбөрийн эсрэг мөн ийм арга хэмжээ авсан удаатай. Гэхдээ АНУ-ын шинжээчдийн дунд

Умард Солонгосын цөмийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж чадсан эсэх талаар санал зөрж байгааг тус сонинд тайлбарлажээ.

Пхеньян өнгөрсөн онд 20 гаруй пуужин, цөмийн хоёр төхөөрөмж туршсан. Умард Солонгосын дээд удирдагч Ким Жон Уны эх ондоотой дүү Ким Жон Намын амь насыг хөнөөсөн хэрэгтэй уялдан тус улс сүүлийн хэдэн долоо хоногт мэдээллийн хэрэгслийн анхаарлын төвд байгаа. Пхеньян Япон тэнгист дунд тусгалын пуужин харвасны маргааш нь Куала Лумпурын олон улсын нисэх буудалд Ким Жон Намын амийг бүрэлгэсэн юм. Тухайн үед дунд тусгалын пуужин харвасан явдлыг АНУ-ын шинэ засаг захиргааг туршсан үйлдэл хэмээн шинжээчид үзэж байв.

Ноён Трамп Ерөнхийлөгчийн албаа хашиж эхэлсэн эхний долоо хоногт Умард Солонгосын талын Цагаан ордны бодлогыг хянаж үзэх тушаал өгсөн юм. Энэ удаагийн туршилт орон нутгийн цагаар үдэс өмнөх 7:30-д болжээ. Лавтайяа нэг пуужинг Дунцэнь алсын тусгалт пуужин хөөргөх талбайгаас хөөргөж, Умард Солонгосын нутаг дэвсгүүр ниссээр Япон тэнгист унасан байна.

АНУ, Өмнөд Солонгос хамтран

Foal Eagle цэргийн сургуулиалт хийж буйн хариуд пуужин турших давтамжаа ихэсгэхээр Пхеньян өнгөрсөн долоо хоногт сурдууллээ. "Стратегийн шинэ зэвсэг хөгжүүлэх" талаар Умард Солонгосын эрх баригч намын албан ёсны хэвлэл "Нодон Шинмун" сонин тайлбарлав. Хариуд нь Өмнөд Солонгосын Засгийн газар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг даваа гарагийн өглөө яаралтай хуралдууллаа. Гурван пуужин Японы эдийн засгийн онцгой бүсэд унасан нь батлагдсаны дараа Японы Ерөнхий сайд Шинзо Абэ Умард Солонгосыг буруутган зэмлэв. Эдийн засгийн онцгой бүс нь Японы эргээс гадагш 200 далайн бээр буюу 370 километр зайг багтаадаг.

"Энэ туршилт Умард Солонгос шинэ занал болж хувирсныг гэрчлэв. Умард Солонгос өөрөө шинэ төрлийн пуужин хэмээн мэдэгдэж байгаа учраас бид ч анхааралтай судалж байна" хэмээн ноён Абэ сэтгүүлдэд тайлбарласан юм. Тэрбээр Пхеньяны үйл ажиллагааг Токио эсэргүүцэж байгааг нэмж өгүүллээ. Пентагон мөн үйл явдлын цаашдын өрнөлд дүгнэлт хийж буйгаа мэдэгдэв.



# Тамхины лоббичид Японы шинэ төлөвлөгөөг өөрчлөх арга эрэлхийлсээр

Япончууд 2020 оны Токиогийн Олимпоос өмнө олон нийтийн зориулалттай барилга байгууламж дотор тамхи татахыг хориглох төлөвлөгөө дэвшүүллээ. Япон орныг дэлхийн хөгжингүй туншуудтэй нь мөр зэрэгцүүлж өгөх уг арга хэмжээг тус улсад ихээхэн нөлөөтэй тамхины лобби өрнүүлэгчид эрс эсэргүүцэж байгаа юм.

Японы тамхичид 2003 онд нийт насанд хүрэгчдийн 27.7 хувь байснаа 2015 онд 18.2 хувь боллоо буурчээ. Тамхи татсаар буй үлдсэн хэсэг нь ресторанаар, баар, ажлын байрандаа хорт зуршлаа үргэлжлүүлж, манай гарагийн бусад газарт эдлэх аргагүй болсон эрх чөлөөг эдлэсээр.

Эдүгээ дэлхийн 50 орчим улс олон нийтийн барилга байгууламж дотор тамхи татахыг хоригложээ. Японы нийгмийн хангамжийн яамнаас тус улсын Эрүүл мэндийн хуульд оруулахаар төлөвлөж буй томоохон засвар нь Их Британи,

Франц зэрэг олон улсын жишгийг дагасан хэрэг юм.

Токио болон бусад гол хотыг оролцуулахад Японы 231 хотод 2000-аад оны дунд үеэс эхлэн гудамжинд тамхи татахыг хоригложээ. Гудамжинд тамхи татах нь ариун цэвэр, гоо зүйн хувьд зохисгүй төдийгүй, идэвхгүй дам тамхидалтын шалтгаан хэмээн үзсэнээс уг хоригийг тавьсан түүхтэй. Хоригоос хойш сэрүүцэх асар сэхээвч, ресторанаар, баар зэрэг олон нийтийн барилга байгууламж дотор утаа баагиулж суух хүмүүс олширсон хачирхалтай дүр зураг шинээр үүсэв.

Тамхины борлуулалтаар дэлхийд дөрөвдүгээрт ордог Jaran Tobacco (JT) компани энэхүү хачин нөхцөлөөр шалтгаан Нийгмийн халамжийн яамнаас санаачилсан засварыг батлуулахгүй өнгөрүүлэхээр чармайж байна. Тус компанийн хөрөнгийн 33.35 хувь нь төрийн өмчид харьяалагддаг юм. Япончуудын хувьд гадаа тамхи

татах сонголт байхгүй учраас Их Британи, Европ, АНУ зэрэг оронд барилга байшин дотор тамхи татахыг хориглож чадсан түүхээр жишээ татах нь шударга бус хэмээн JT-ийн төлөөлөгч тайлбарлав.

JT-ийн тайлбар үр дүнгээ өгсөн бололтой. Лхагва гарагт Нийгмийн халамжийн яамнаас гаргасан шинэ хувилбар нь анхны эхтэй харьцуулахад хөнгөрүүлсэн шаардлагатай болж өөрчлөгджээ. Уг шаардлагад нэгдүгээр давхар нь 30 хавтгай дөрвөлжин метрээс үл хэрэх талбай бүхий бүх хоолны газар, бааранд тамхи татахыг зөвшөөрсөн байна.

Тамхидалт, уушгины хорт хавдрын ихэнх хэлбэр хоорондоо холбоотойг сэрэмжлүүлэгч "янз бүр хүмүүс"-ээс анхааруулдаг тамхины хорт нөлөө гэгчид эргэлздэгээ JT-ийн хувьцааны төрийн мэдэлд байдаг хэсгийг хариуцдаг, Японы Сангийн сайд Таро Асо өнгөрсөн сард тайлбарласан. Уг тайлбар нь

Японы 231 хотод 2000-аад оны дунд үеэс эхлэн гудамжинд тамхи татахыг хоригложээ.



эрх баригч Либерал ардчилсан намын гишүүдийг оролцуулах парламентад нийт 100 орчим өөрийн талынхан бүхий Японы тамхины лобби бүлгийн байр суурийн илрэл болж байна. Нийгмийн халамжийн яамны шинэ төлөвлөгөөг эсэргүүцэгч бусад бүлгүүд олон нийтийн зориулалттай барилга дотор тамхи татахыг хориглох нь баар, рестораны салбарыг хямраана хэмээн анхааруулдаг. JT ч дам

тамхидалт уушгины хорт хавдар үүсгэх шалтгаан болж буйг баталсан тохиолдол байхгүй хэмээн тайлбарлах замаар шинэ төлөвлөгөөг эсэргүүцэв.

Япон орон идэвхгүй тамхидалтыг багасгахын тулд хэрэгжүүлсэн арга хэмжээг Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага өндөр үнэлсэн юм. Уг арга хэмжээний дүнд дам тамхидалтад өртдөг япончуудын 40 хувь нь утаа залгих аюулаас салж

чадсаныг тус улсын эрх баригчид тооцоолжээ.

Нийтийн барилга байгууламж дотор тамхи татахыг хориглох төлөвлөгөө нь Япон орон Олимпын их наадамд бэлдэж буйн илрэл. Барилга дотор тамхи татаж болдог, болдоггүй бүс тусад нь үүсгэсэн амжилттай туршлагаас санаа авч "Утаа тусгаарлах" бодлого хэрэгжүүлэх боломжтойг JT мөн тайлбарлав.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

# Хятадын банкны актив Евро бүсийнхээс давлаа

Габриель Уайлдау

Хятадын банкны систем активын хэмжээгээрээ евро бүсийнхийг давж, дэлхийд хамгийн томд тооцогдож эхлэв. Энэ нь Хятад улсын нөлөө дэлхийн санхүүд жин дарах болсонтой, нөгөөтэйгүүр санхүүгийн хямралын дараа эдийн засгаа тэтгэхээр их хэмжээний зээл олгосонтой холбоотой аж.

Валют солилцооны зах зээлд Хятадын ДНБ 2011 онд Европын холбооноос давж байсан бол банкны системээрээ гүйцэж түрүүлэх шинж 2016 оны төгсгөл хүртэл ажиглагдаагүйг FT-ийн шинжилгээ харуулав.

Ерөнхийд нь дүгнэвэл, Бээжин санхүүгийн үйлчилгээгээ нийгмийн бүх шатанд жигд үзүүлж чадсантай холбоотой юм. Засгийн газар төсвийн бодлогоо дэлхийн санхүүгийн хямралын нөлөөг сааруулах халхавч болгож, мөнгөний чанга бодлогоо сулласан 2008 оноос хойш банкны зээлийг үлэмж их хэмжээгээр гаргаж эхэлсэн билээ.

“Хятадын банкны салбарын активын энэ өсөлт онцгой үйл явдал гэхээсээ илүү банкинд түшиглэсэн хөрөнгө оруулалтаас тус улсын эдийн засаг ихээхэн хамааралтай байгаагийн илрэл. Үүний цаана нөөцийн үр ашиг муутай хуваарилалт, зээлийн их эрсдлийн тухай асуудал бий” хэмээн Cornell их сургуулийн эдийн засагч, өмнө нь ОУВС-д Хятадыг хариуцаж байсан Эсвар Прасад тайлбарлалаа.

Хятадын банкны нийт актив 2016 оны төгсгөлд 33 их наяд ам.доллар байсан бол евро



BVM©

бүсийнх 31 их наяд байжээ. Харин АНУ-ынх 16, Японых долоон их наяд ам.долларын активтай байв. Хятадын банкны актив хэмжээгээрээ дотоодын эдийн засгийн гарцаас 3.1 дахин их болжээ.

Хөгжингүй орнуудын эдийн засгийн хямрал гүнзгийрч буй энэ цаг үед дэлхийн эдийн засгийн өсөлтийг хадгалахад Хятад төсвийн бодлогоороо дэм болж буйг бусад орны удирдагч, эдийн засагчид сайшааж буй.

Гэсэн хэдий ч одоохондоо төсвийн бодлого нь үр ашиг муутай хөрөнгө оруулалт, аж үйлдвэрлэлийн эрэлтээс давсан нийлүүлэлт, өрийн эрсдэлтэй түвшинд л хүргэж байна гэж харж болохоор.

Хөгжингүй зах зээлүүдээс ялгаатай нь Хятадын орон нутгийн удирдлагуудын санхүүгийн дэд бүтэц банкны их хэмжээний зээлээс хамааралтай байгааг шинжээчид тэмдэглэдэг. Үүнд актив нь хоёр их наяд

ам.долларыг давсан Хятадын хөгжлийн банк зэрэг олон нийтийн хувьцаат бус төрийн өмчийн банкуудын үүрэг нөлөө их байна. Арилжааны банкуудын оролцоо ч мөн бий.

Хонконг дахь Sanford C Bernstein судалгааны компанийн банкны шинжээч Хоу Вэй “Банкны тайлан мэдээг харвал корпорациудын зээлд Засгийн газрын нуун далдалсан зээл их байна. Үүнийг өөр орнуудтай харьцуулж харвал будилж мэднэ.

Бусад улсад бол засгийн газрууд нь шууд л хөрөнгийн зах зээлээс зээл авдаг. Харин Хятадад байдал арай өөр” хэмэв.

Гэхдээ бусад хураангуй мэдээллээс үзвэл Хятадын банкуудын бодит цар хүрээг дутуу үнэлж боломгүй. 2010 оноос энэ улсад сүүдрийн банк эрчимтэй гарч ирсэн. Санхүүгийн тэнцлийн гадуурх гүйлгээнд зээлийн ихэнх нь арилжааны банкинд ногдож байна. Өнгөрсөн сард төв банкнаас далд

баталгааны тархалт тэнцлийн болон тэнцлийн гадуурх тайланд төдийлэн тодорхой тусгагдахгүй байгааг анхааруулсан юм.

Банкууд тэнцлийн гадуурх тайланд тусгагдсан үйлчилгээндээ яаралтай тусламжийг ойр ойрхон үзүүлдэг. Уг нь ийм хариуцлага хүлээнэ гэсэн хууль байхгүй. Сүүлийн хэдхэн долоо хоногийн хугацаанд Хятадын удирдагчид санхүүгийн бодлогоо төсөвт бус эрсдлийг хянахад чиглүүлж эхлээд байна. Гэхдээ бодит өөрчлөлтийн сургахаа ч байсан юм. Нэгдүгээр сарын байдлаар Хятадын зээлийн хэмжээ дахин өсөх эрчээ авсан.

Өрийн хэмжээ нэмэгдэж буйг хянахын тулд эдийн засагчид хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх замаар Хятадын санхүүгийн тогтолцоонд банкны хараат байдлыг багасгах явдал гэж харж байна. Банкнаас хэт хамааралтай байгаа нь бонд болон хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин хязгаарлагдмал байгаагаар зарим талаар холбоотой юм. Гэхдээ Коммунист намын хувьд санхүүгийн тогтолцоо солонгорох тусам мөнгөний урсгалыг удирдах боломж нь хязгаарлагдана.

Ноён Прасадын дүгнэж буйгаар санхүүгийн зах зээлийн талаар баримталж буй Хятадын Засгийн газрын байр суурь нь хоёрдмол юм. Нэг талаар, санхүүгийн тогтолцоог нөөцийн дахин хуваарилалтын хэрэгсэл болгож, үйл ажиллагааг нь чөлөөлөх хүсэлгүй. Хяналт, тогтвортой байдлыг сайжруулна гэдэг нь нүд хуурсан зорилт аж.



Германы эрх баригчид жагсаалыг эсэргүүцсэн нь Туркийн шинэчлэлийг бусниулах зорилготой гэж үзжээ.



The New York Times©

## Нацист арга барилаас салаагүй гэв

Клейр Жонс

Режеп Тайип Эрдоаны Ерөнхийлөгчийн эрх мэдлээ нэмэгдүүлэх төвөглөөг нь дэмжихийг санаархсан Германд амьдарч байгаа 1.5 сая турк иргэний жагсаалыг Берлин бусниуллаа хэмээн Туркийн тал үзэв. Тэд нацист арга барилаас хандаж байна гэх маргааныг дэгдээгээд байна.

Германы улс төрчид НАТО-гийн гишүүн хоёр орны харилцаа эрчимтэй муудахад хүргэж буй уг маргааны эсрэг арга хэмжээ яаралтай авч эхэлжээ. Канцлер Ангела Меркелийн Христийн ардчилсан холбооны дэд дарга Юлия Клэкнер Туркийн Ерөнхийлөгчийн уг зүйрлэлийг “аймшигтай” гэх ганц үгээр тодорхойлов. Тэрбээр “Ноён Эрдоан яг л толгойдоо аливааг бодох сөхөөгүй хорлонтой хүүхэд шиг аашилж байна” гээд, эл үйлдлийнхээ төлөө уучлал гуйх учиртайг нэмж онцоллоо.

Эрдоанд Ерөнхийлөгчийн эрх мэдлийг түргэлжлүүлэн хадгалуулах тухай Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Гаггенау, Кёльн хотод жагсаал зохион байгуулах зөвшөөрөл өгөхөөс орон нутгийн удирдлага татгалзсаны дараа уг маргаан дэгдэжээ. Үндсэн хуульд

оруулах өөрчлөлтийн асуудлаарх бүх нийтийн санал асуулга дөрөвдүгээр сарын 16-нд болох товтой.

Ням гарагт Истанбул хотноо болсон нэгэн арга хэмжээн дээр ноён Эрдоан “Германчууд бидний анд болсонгүй. Герман чир ардчилалгүй. Бас ойр дотно ч биш юм. Та бүхний үйлдэл нацистуудын хийж байснаас ялгагдах юмгүй. Бидэнд ардчилсан харилцаа өнгөрсөн зун Туркт засгийн эрхийг хүчээр авах гэсэн оролдлогын дараа сэтгүүлдид, сөрөг хүчнийхнийг хамарсан баривчилгаатай холбоотойгоор ээдрээтэй болж эхэлсэн.

Ноён Эрдоан уг асуудалд олон улсын форумын анхаарлыг хандуулах бөгөөд дэлхий нийтийн өмнө Германыг шившиг болгоно гэдгээ илэрхийлжээ. Хоёр улсын эрхийн харилцааг хангахад Туркт засгийн эрхийг хүчээр авах гэсэн оролдлогын дараа сэтгүүлдид, сөрөг хүчнийхнийг хамарсан баривчилгаатай холбоотойгоор ээдрээтэй болж эхэлсэн.

Die Welt сонинд ажилладаг Турк, Герман гаралтай сэтгүүлч Дениз Юуселийг баривчилсны дараахан Германы ард түмний эсэргүүцэл нэмэгдэж байна. Харин Канцлер Меркелийн уг баривчилгаанд оролцоогүй гэдгийг бие төлөөлөгч нь мэдэгдлээ. Гэхдээ өнгөрсөн

долоо хоногт Германы Канцлер ноён Юуселийн баривчилгааг “гашуун бөгөөд харамсалтай явдал” хэмээн буруутгасан юм. Ноён Юуселийг тагнуул хэмээн буруутгасан ноён Эрдоаны үгийг Германы эрх баригчид үндэслэлгүй хэмээн дүгнэжээ.

Герман руу цухав Сирийн дүрвэгчдийн урсгалыг хязгаарлахад Турк улс чухал үүрэг гүйцэтгэж буй. Өнгөрсөн жил Европын холбоотой хийсэн тохиролцооны дагуу Европыг зорих дүрвэгчдийг Турк буцааж, хариуд нь их хэмжээний санхүүжилт авч байгаа билээ. Хатагтай Меркель ирэх есдүгээр сард болох сонгуулиар Канцлераар дөрөв дэх удаагаа сонгогдохын төлөө өрсөлдөхөөр бэлтгэж байна. Гэвч нэг сая гаруй дүрвэгчийн их урсгалыг эх орондоо татсан түүний шийдвэр олон нийтийн эсэргүүцлийн хамгийн эгзэгтэй шалтгаан болж буй юм.

Түүнчлэн талуудын харилцаа хурцдаж байгаа нь Германы хэвлэлүүдийн анхаарлын төвд байна. Борлуулалтаараа тэргүүлдэг Bild сонин л гэхэд ням гарагийн дугаартаа “Эрдоаныг хязгаарлах бидний улаан шугам хаа байна” гэж бичжээ.



## Хамгийн том ган үйлдвэрлэгчийн төлөөх тэмцэл эрчээ авчээ

Майкл Пулер, Жеймс Полити

Италийн өмнөд хэсгийн үйл ажиллагаа нь доголдсон төмөрлөгийн үйлдвэрийг худалдаж авах үнийн саналыг даваа гараг хүртэл хүлээж авчээ. Ийнхүү Европын хамгийн том гангийн үйлдвэр Пва-ийн хувь заяа хэрхэхийг удахгүй шийдэх нь.

Гол нь хэдэн мянган ажлын байрны тухай биж, харин Пва нь Таранто мужийн аж үйлдвэрийн өмч, боловсруулах салбарын тулгуур юм. Өрсөлдөгч хоёр концернуудын Италийн бараг бүтэн зуун жилийн настай аж үйлдвэрийг хэрхэн сэргээх талаар өөр өөрийн хувилбар гаргасан нь өрсөлдөөнд ялах гол үзүүлэлт болно.

Нэг групп нь гангийн үйлдвэрлэлээр дэлхийд хамгийн томд тооцогдох ArcelorMittal-ийн дэргэдэх Италийн ган боловсруулагч Marcegaglia юм. Нөгөөх нь Италийн нарны нүдний шил үйлдвэрлэлээр тэргүүлэгч Leonardo Del Vecchio-гийн эзэмшдэг Delfin, Италийн Засгийн газрын зээлийн сан болох Cassa Depositi e Prestiti, мөн дотоодын ган үйлдвэрлэгч Arvedi-гийн хамтын эзэмшлийн компани. Уг компанид Энэтхэгийн тэрбумтан Сайжан Жиндалын JSW Steel ч мөн нэгджээ.

Уул уурхай, ган боловсруулагч ArcelorMittal компанийн санхүүгийн албаны дарга Адития Митталын хэлж буйгаар Пва бол бүтцийн хувьд маш том давуу талтай аж. “Гэхдээ эл давуу талыг зөв удирдахаас нааш харах боломжгүй. Хүчин чадлын хувьд хомсдолд орж, эвдэрч гэмтсэн



BVM©

хэдий ч Европдоо хамгийн бага зардалтай, үр дүнтэй байгууламж болох бололцоо бий” хэмээн Адития Миттал тайлбарлалаа.

Үйлдвэр хорт хийгээ агуулах боломжгүй болсны улмаас шүүхээс газар дээрх байгууламжуудыг тусгаарласны дараа 2015 онд Ром Пва-ийн хяналтын хувийг худалдаж авсан байна. Үр дүнд нь санхүүгийн хувьд ч сэргэлт ажиглагдаад эхэлжээ. Өнгөрсөн онд орлого нь таван хувиар өсөж 2.2 тэрбум евро болсон бол алдагдал нь татварын дараах үзүүлэлтээр 220 сая евро болж багасчээ. Уг нь жилийн өмнө 545 сая еврогийн алдагдалтай ажиллаж байв.

Пва-г худалдах нь Италийн эдийн засагт чухал тэнцвэрийг хадгалж мэдэх юм. Ялангуяа тус улсын боловсруулах үйлдвэрийн салбар боломжийн үнэтэй ган бүтээгдэхүүн нийлүүлдэг билээ.

Италийн нөлөө бүхий зарим улстөрч Энэтхэгийн тэрбумтан Жиндалын концернуудын үнийн саналд илүү талтай байна. Ноён Жиндалын зорилго бол Пва-гийн жилийн гарцыг 3-5 жилийн

дотор одоогийнхоос хоёр дахин ихэсгэж, 10-12 тонн хүргэж чадна гэдгээ илэрхийлжээ. Энэ бол өрсөлдөгч ArcelorMittal компанийн санал болгосон найман тонноос хавьгүй өндөр үзүүлэлт юм.

Ноён Жиндалын групп хөрөнгө оруулалт, олборлолтын хувьд илүү өндөр зорилго тавьсан санал гаргасан” хэмээн Италийн Сенат дахь аж үйлдвэрийн хорооны тэргүүн, Ардчилсан намын гишүүн Массимо Муччетти дүгнэжээ. Тэрбээр “Харин ArcelorMittal-ын санал нь байгальд илүү ээлтэй байна. Тэд Европт өөр нэг аюултай шинэ өрсөлдөгч орж ирэхээс зайлсхийж байна” хэмэв.

Италийн эдийн засгийн хөгжлийн яамны төлөөлөгч уг асуудалд ямар нэгэн тайлбар хийхээс татгалзсан нь тус улсын Засгийн газар аль нэг талыг дагаагүй гэдгийг илэрхийлэв. Албаныхан аль алиных нь байгаль орчны үнэлгээ, үйлдвэрлэлийн нөлөөг нь нухацтай үзэх аж.



## Эрүүл мэнд

## Харшил, халдвар идэвхжих улирал

Он гарсаар хачигт халдварын дөрвөн тохиолдол бүртгэгдээд байна

Б.Гандолгор  
@gandolgorZGM

## ШАР ӨВЧНИЙ ТАРХАЛТ НЭМЭГДДЭГ

Хаврын урь орохтой зэрэгцэн зарим төрлийн халдварт өвчин идэвхждэг. Тодруулбал, халдварт шар өвчин, хачигт халдвар, гар, хөл амны өвчний тархалт нэмэгдэж, харшил сэдэрдэг талтай. Урин дулаан эхэлмэгц хөрсний бохирдол ихэсдэг тул эдгээр хөл амны өвчин элбэг тохиолддог билээ. Ялангуяа бага насныхан илүү өвчилдөг аж. Өнгөрсөн онд л гэхэд ойролцоогоор 8000 гаруй хүүхэд шарын халдварт өртсөн байна. Өвчлөгсдийн 80 гаруй хувийг 0-14 насны буюу сургууль, цэцэрлэгийнхэн эзэлж буй талаар эмч нар хэллээ.

Халдварт шар гэдэг нь бохир гараар дамждаг, вирусээр үүсгэгдэн элгийг гэмтээдэг, цочмог халдварт өвчин юм. Дэлхий дахинд элэгийн үрэвсэл үүсгэдэг есөн төрлийн вирус тогтоогдоод байна. Монголд бохир гарын шар буюу А гепатит маш их байгаа бөгөөд нийт тохиолдлын 85-90 хувийг эзэлдэг аж. Шарын вирус нь цусанд хуримтлагдаж ялгадасгай хамт гадагшилдаг. Ялаа, бохир ус, хоол хүнс, сав, гэр ахуйн эд зүйл, бохир гараар дамжиж, ходоод гэдсэнд нэвтэрсний дараа цусаар дамжин элгэнд очдог. Ийнхүү элэгийн эсүүдэд үржиж, ялгадасаар хүний биеийг хордуулдаг байна. А вирусээр үүссэн шар өвчний халдвар үе нь долоо хоногоос сар гаруй хугацааны турш үргэлжилдэг. Тиймээс халдвар авсан эхний үед буюу нууц үедээ төдийлэн илэрдэггүй байна. А гепатитаар өвдсөн тохиолдолд амархан

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Сонголтгүй хүүхдийн тоо нэмэгджээ

Манай улсад сүүлийн жилүүдэд сонголын бэрхшээлтэй хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа аж. Улаанбаатар хотод 2010 оны байдлаар эмнэлэгт хандан сонголын бэрхшээлтэй гэж оношлогдсон хүүхдийн тоо 5431 байсан бол 2014 онд 7302 болж өсчээ. Дэлхий дээр 360 сая хүн сонголын бэрхшээлтэй байгаагаас 32 сая нь хүүхэд байна.

ДЭМБ эдгээр хүүхдүүдийн 60 хувийг сонголт бууралтаас урьдчилан сэргийлэх боломжтой гэж үздэг. Энэ эмгэгээс урьдчилан сэргийлж, эрт илрүүлж, зохих арга хэмжээг авснаар хүүхдийн хэл ярианы хөгжил саатах, суурь боловсрол эзэмшиж чадахгүй болох, нийгмээс гадуурхагдах зэрэг сөрөг үр дагавар арилах юм. [ЗГМ]

Дэлхий дээр хэдэн мянган зүйл ургамал ургадаг боловч ердөө л 50 гаруй нь харшил буюу поллиноз өвчин үүсгэдэг аж.

цуцаж, бие сулбайх, хоолонд дургүй болж, аманд гашуун амт амтагдаж, цээж хорсох, дотор муухайран бөөлжис цутгаж, гэдэс базлах, толгой өвдөх, нойр хүрэх, ялгадас цайвар цагаан өнгөтэй болох, шээс, өтгөн хүрэн болж өөрчлөгдөх зэрэг шинж тэмдэг илэрдэг. Уг өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд гараа тогтмол угааж занших хэрэгтэй. Гараа тогтмол угаах, түүхий ус уухгүй байх нь халдварын эсрэг хамгаалалт болно. Бохирдсон эд зүйлсийг буцалгах, ууранд жигнэх, нэг хувийн хлорамины уусмалаар халдваргүйжүүлэх хэрэгтэй.

## ХАЧИГТ ХАЛДВАР

Манай улсад хачигт халдварын тохиолдол жил ирэх тусам нэмэгдэж байгаа талаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс мэдээлсэн. Монголд одоогоор ойн болон бэлчээрийн хачиг, говь цөлд оршдог хачиг зэрэг гурван төрөл

бүртгэгдээд байна. Мал амьтан хачигт хазуулсан тохиолдолд элдэв төрлийн халдварт өвчний нянгаар өвчлөх эрсдэлтэй байдаг талаар малын эмч нар анхааруулдаг.

Хачигт халдварын оргил үе нь 3-6 дугаар сар байдаг. Хачигт хазуулсан тохиолдолд мэдрэлийн тогтолцоонд нөлөөлж эрхтэн системийг гэмтээхээс гадна үхэлд хүргэж болзошгүй тул халдвараас сэргийлэх вакциныг эрүүл мэндийн төвүүдээр хийлгэвэл зохилтой. Хачигт халдварын вакциныг гурав, долоо, есдүгээр саруудад хийлгэх шаардлагатай байдаг.

Дэлхий дахинд элэгийн үрэвсэл үүсгэдэг есөн төрлийн вирус тогтоогдоод байна

Сэлэнгэ, Хэнтий, Булган, Хөвсгөл, Дорнод, Архангай зэрэг аймагт хачигт халдварын тохиолдол хамгийн их илэрдэг байна. Мөн говийн бүс, баруун аймгууд болон нуур ус, гол мөрөнтэй газрууд байгалийн дамжуулагчийн идэвхжилттэй газар нутаг гэсэн ангилалд багтжээ. 2017 он гарсаар Өмнөговь аймгийн Ханхонгор сум, Архангай аймгийн Цэнхэр сум, Улаанбаатар хотын Багануур, Чингэлтэй дүүрэгт хачигт халдварын дөрвөн ч тохиолдол илэрч Зоонозын өвчин судлалын үндэсний төвд бүртгэгдлээ. Ялангуяа өтгөн шигүү ойтой

газар хачиг их тархдаг тул ойд зугаалахдаа тод өнгийн хувцас өмсөхийг эмч нар анхааруулдаг.

Сүүлийн жилүүдэд хот суурин газрын иргэд өвчилдөг болсон талаар судлаач эрдэмтэд хэлж байлаа. Хойд хөрш л гэхэд хачигт халдвараас сэргийлэх хоёр төрлийн шинэ вакцин гаргажээ. Оросын эрүүл мэндийн байгууллага энэ халдварын вакциныг заавал хийлгэхийг иргэддээ санал болгодог аж.

## УРГАМЛЫН ХАРШИЛ СЭДРЭХ ҮЕ

Дэлхий дээр хэдэн мянган зүйл ургамал ургадаг боловч ердөө л 50 гаруй нь харшил буюу поллиноз өвчин үүсгэдэг аж. Поллиноз нь харшлын эмгэгүүдийн дотор 25 орчим хувийг эзэлдэг бөгөөд голдуу 3-9 наснаас эхлэн илэрдэг байна. Харшлын илрэл нь голчлон амьсгалын замын ба нүдний салст бүрхүүлд улирлын шинжтэйгээр жил бүр илэрч, ялангуяа ургамал цэцэглэх, тоосоо гөвөх үеэр хурцдаг. Энэ төрлийн харшилд удамшлын хүчин зүйл ихээхэн нөлөөтэй байдаг талаар мэргэшсэн эмч хэлж байна. Ургамлын тоосонцорын харшил нь хүүхдүүдэд хамрын салст, нүдний салстын үрэвсэл үүсгэдэг. Хүүхэд угсруулан найтаах, хамар битүүрэх, хамраас усархаг нус гоожих, нүд загатнах, улайх зовиур илэрнэ. Мөн хоолны дуршил буурч, нойргүйдэн амархан ядарна.

Ургамлын гаралтай зарим хүнс нь тоосонцрын адил харшлын урвал үүсгэж болох тул хүүхдийн хоол хүнсэнд онцгой анхаарах хэрэгтэйг эмч нар зөвлөж байгаа юм.

Модны тоосны харшилтай бол улаан лооль, киви, петрушка, хар чавга, лууван, интоор, алим, самар, тоор жимс өгч болохгүй. Зэрлэг ургамлаас харшилдаг бол шийгуа, тарвас, халва, наранцэцгийн самар, майонез, гич, хүрэн манжин, хаш зэргийг идэхээс татгалзах хэрэгтэй. Үрт ургамлын харшилтай бол гурил, квас, улаан буудай, манны каш, пудинг, зайрмаг, эрдэнэ шиш, хиам, кофе орлуулагч зэргийг хэрэглэж болдоггүй байна.

Харшлын эмчилгээнд эмнээс дутуугүй ач холбогдолтой нэг чухал зүйл нь харшлуулагчаас зайлсхийх, түүнийг биеэс гадагшлуулах юм. Харшлын улирал эхэлмэгц хүүхдийг ургамал ногооноос аль болох хол байлгахыг хичээх хэрэгтэй. Хаалга цонхыг хаалттай байлгах, чийгтэй самбай материалаар хаалт хийх, хүүхдэд чийгтэй амны хаалт зүүлэх нь ихээхэн ач холбогдолтой. Өглөөний агаарт ургамлын тоос их байдаг тул хаалга цонхыг өглөөгүүр биш орой, эсвэл борооны дараа онгойлговол зохимжтой. Харшилтай хүүхдийн гэрт чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр хийж байх ёстой. Хүүхдийг гаднаас орж ирмэгц гарыг нь угаах, хамар хоолойг зайлуулах, нүдийг цэвэр усаар угаах нь ихээхэн ач холбогдолтой. Мөн хувцсыг нь заавал солино. Харшлын илрэл арьсанд гардаг бол аль болох урт ханцуйтай цамц, даашинз, урт өмд өмсүүлэх хэрэгтэй. Тасалгаанд нь цэцэг ургуулах, амьд ба хатаасан ургамал байлгахыг хориглоно. Мөн харшлын чиглэлээр мэргэшсэн эмчид хандаж, эмчлүүлэхийг сануулахад илүүдэхгүй болов уу. [ЗГМ]

## ТОВЧХОН

## » СУДАЛГАА

Монгол Улсын Засгийн газар, “Глобаль” сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, ДЭМБ-ын хамтарсан санхүүжилтээр “Хүн амын дундах сүрьеэгийн тархалтыг тогтоох судалгаа хийжээ. Судалгаанд Улаанбаатар хотын найман дүүргийн 45 хороо, 15 аймгийн төвийн 21 баг, хөдөөгийн 32 сумаас нийт 50300 хүнийг сүрьеэгийн илрүүлэлтэд хамруулсан байна. Гэвэл манай улсын хүн амын дундах уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тархалт нь жил бүр бүртгэгддэг сүрьеэгийн тохиолдлоос өндөр гарчээ.

## » БАГА ХУРАЛ

Бельгийн нийслэл Брюссель хотноо болсон “Эмэгтэй хүн өөрөө шийддэг” сэдэвт олон улсын Сайд нарын бага хуралд Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Хуралд 50 орчим улсын Засгийн газрын төлөөлөл оролцож, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, санхүүжилтийн талаарх олон улсын хандлага, чиглэлийг хэлэлцэв. Хуралд оролцсон улс орнууд үүний санхүүжилтэд зориулж нийт 181 сая еврогийн хөрөнгө босгохоор болжээ.

## » ТОО

40

Он гарсаар Хөвсгөл, Ховд, Хэнтий, Увс, Говь-Алтай, Өмнөговь, Булган, Орхон, Дундговь аймгийн 10 сум, Улаанбаатар хотын Чингэлтэй, Багахангай Хан-Уул дүүрэгт галзуугийн эрсдэлд өртсөн 40 тохиолдол бүртгэгдэж, шаардлагатай вакцинаар хангажээ.

## » ШУВУУНЫ ТОМУУ

БНХАУ-ын шувууны нэгэн аж ахуйд шувууны томуугийн H5N2 вирус халдварын дэгдэлт бүртгэгдлээ. 16000 шувуу өвчилснөөс, 730 шувуу нь үхэж, 15270-ыг нь устгаж, ариутгал хийсэн байна.

## » ТЭМДЭГЛЭЛТ ӨДӨР

Дэлхийн 160 гаруй оронд 2006 оноос эхлэн “Бөөр хамгаалах дэлхийн өдөр”-ийг тэмдэглэж иржээ. Манай улс 2009 оноос энэ өдрийг тэмдэглэн, хүмүүнлэгийн арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг болсон. Эл өдөр УНТЭ-ийн Бөөрний төвийн эмч нар Төв аймгийн Баяндэлгэр суманд сайн дурэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээ хийлээ. Үзлэгт 170 гаруй иргэнийг хамруулж, гурван сая төгрөгийн эм үнэгүй өгчээ.

САЙН УУ  
ДЭЛХИЙ

“Сайн уу, Дэлхий” цувралын энэ удаагийн дугаараар бидний аялал Сиднейн далайн эргээс эхэлж, Мельбурн хотын чамин хээнцэр гудамж хүртэл үргэлжилнэ. Агуйд төөрч, цох хорхойгоор газарчлуулна. Үүнээс гадна Интернэтийн плейбойтой загасанд явж, үлэг гүрвэлүүдтэй ч найз болсон. Энэ бүгдийг “Сайн уу Дэлхий” нэвтрүүлгийн энэ удаагийн дугаараас хүлээн авч үзнэ үү.

Мягмар гараг /2017.03.07/

20:30

09:30 Лхагва гараг

13:00/17:00 Бямба гараг

20:30 Ням гараг

Bloomberg  
TV Mongolia

# Амьдралын хэв маяг

## Фэйсбүүкийн нэг пост дунджаар 90 минутын дотор боломжтой бүх хэрэглэгчид хүрдэг

Б.Баярмаа  
@bayarmaaZGM

Нийгмийн сүлжээ сайтуудыг хил хязгааргүй хот гэвэл тэнд 100 саяаас илүү хүнтэй аварга хотууд олноороо бий болжээ. Хамгийн нүсэр нь 1.8 тэрбум

3-5 удаа жиргэх нь хамгийн тохиромжтой тоо гэж үздэг. Үүнээс цөөн байвал бусдын жиргээнд дарагдан алга болно. Их байвал хүмүүс залхаж эхэлнэ. Мөн өдрийн хэдэн цагт жиргэх вэ гэдэг чухал. Үдийн 13.00 болон үдээс хойш 15.00-17.00 цаг хамгийн үр дүнтэй байдаг аж. Харин амралтын өдөр үүнээс арай бага жиргээг, илүү оройн цагаар оруулаарай. Хэрэв эдгээр цагуудад амжихааргүй бол өмнө нь бэлдэж оруулаад, цагийг нь тааруулдаг тохиргоо ихэнх нь сошиал хуудсуудад бий.

Харин фэйсбүүкийн хувьд “алтан тоо” нь хоёр. Алдартай брэндүүд фэйсбүүк хуудастаа



# Нийгмийн сүлжээг “атгах” заль

хүнтэй Фэйсбүүк. Түүний араас WhatsApp нэг тэрбум, Инстаграм 600 сая, Твиттер 317 сая, Снапчат болон Скайп 300 сая “оршин суугч”-тайгаар жагсаж байна. Энэ олон сая иргэдтэй хэрхэн зохицож амьдрах, өөрийн зорилгодоо хэрхэн үр дүнтэй ашиглах талаар хүргэж байна.

дунджаар өдөрт хоёр, долоо хоногт 10 пост оруулдаг байна. Мэргэжилтнүүд нэг пост болон Скайп 300 сая “оршин суугч”-тайгаар жагсаж байна. Энэ олон сая иргэдтэй хэрхэн зохицож амьдрах, өөрийн зорилгодоо хэрхэн үр дүнтэй ашиглах талаар хүргэж байна.

аль болох товч тодорхой бичих, сонирхолтой зураг ашиглах, содон “эможи”-гоор чимэх зэрэг аргуудыг хэрэглэж болно. Мөн ямар сошиал сувгаар юу постлох вэ гэдгээ ялгавал сайн. Мэдээллийн чанартай бол твиттер, зураг бол инстаграм, ажлын зар бол линкед-ин гэх мэт. Мэдээж, гутаан доромжилсон, хууль зөрчсөн постыг бичих байтугай, бусдынхыг хуваалцах ч хэрэггүй.

### БҮГДИЙГ НЭГ ЦЭГЭЭС

Ажлын ч бай, хувийн ч бай олон сошиал сувгийг хөтөлнө гэдэг цаг орсон ажил. Тиймээс үнэт цаг хэмнэхийн тулд Hubspot, Hootsuite зэрэг платформыг ашиглаарай. Ингэснээр нэг талбараас фэйсбүүк, твиттер, инстаграмаа хянаж, мөн нэг зэрэг пост оруулах боломжтой. Эдгээр

платформ илүү олон боломж олгох тусмаа төлбөр нь өндөр байдаг. Hubspot бол сошиал хуудсуудаас гадна и-мэйл, форум, блог гээд олон сувгуудыг автоматжуулах боломжтой бөгөөд сарын төлбөр нь 200 ам.доллараас эхэлдэг. Гэхдээ хувьдаа ашиглах гэж байгаа бол нэг сарын үнэгүй эрхийг нь сонгох боломжтой. Сарын дараа дахиад л шинэ хаягаар шинэ эрх авах бяцхан заль ч хэрэглэхэд гэмгүй. Сул тал нь, шинээр сувгуудынхаа тохиргоог хийх шаардлага гардаг. Шинэ зүйл гэж халгах хэрэггүй, нэг удаа эдгээр платформыг ашиглаад амтанд нь орох болно.

### ТӨЛБӨР ТӨЛӨХ АШИГТАЙ ЮУ

Фэйсбүүк, твиттерийн хэдэн мянган хэрэглэгчид өөрийнхөө постыг хүргэхэд төлбөртэй үйлчилгээ тусална. Фэйсбүүк гэхэд хоёр ам.доллараар 6000 хүнд хүргэх жишээтэй. Гэхдээ фэйсбүүк таны хуудсан дахь лайкны тоо, тухайн үед бусад хүмүүс хэр олон сурталчилгаа явуулж байгаагаас хамааран янз бүрийн үнэ санал болгодог. Сонгуулийн үеэр л гэхэд фэйсбүүк сурталчилгааны үнэ

“хаданд” гардаг. Олон хүн төлбөртэй сурталчилгаа явуулах тусам тэд үнэ өсгөдөг.

## Өдөрт 3-5 удаа жиргэх нь хамгийн тохиромжтой тоо гэж үздэг

Гэвч төлбөртэй сурталчилгаа хувь хүмүүст тохиромжгүй. Учир нь “төлбөртэй сурталчилгаа” гэсэн бичиг таныг бариад өгчихнө. Харин үүний оронд “инбаунд” маркетингийг санал болгоё. Зөвхөн байгууллага л маркетинг ашигладаг цаг хол хоцорсон. Алдартнуудын хувьд сошиал хуудас хөтлөх нь нэр хүндээ өсгөх, хамгаалах бас нэг талбар болсон байдаг. Инбаунд маркетинг гэдэг нь бусад хүнд хэрэгтэй хөнгөн, зугаатай таван пост оруулсны дараа өөрийнхөө хамгийн чухал мэдээллээ оруулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэл хөнгөн мэдээллээр бусдыг татсаны дараа өөрийнхөө гол

“мессеж”-ийг хүргэнэ гэсэн үг.

### ҮНЭГҮЙ ТУСЛАХУУД

Интернэтээр хайхад сошиал сувгуудыг илүү хялбараар ашиглахад зориулсан програмууд олноороо гарч ирнэ. Зураг эвлүүлэх, пост хийх цаг тохируулах, бусдын харуульд дүн шинжилгээ хийх гэх мэт. “Canva”-д зургаа оруулаад бэлэн загваруудыг ашиглан сурталчилгаа бэлдэж болно. Сонирхолтой нь, гар утаснаас энэ програмыг ашиглаж болдог. Мөн 10 асуулттай бичил судалгаанд 100 хэрэглэгчээс хариулт авах боломжтой “Monkey survey” программ бий.

Эдгээрээс гадна сошиал сайтыг үр дүнтэй ашиглах гэвэл фэйсбүүкийн 2-3 групп болон пэйж, твиттерийн мөн тооны акаунт хэрэгтэй. Өөрт тань биш гэхэд бусдын мэдээллийг түгээхэд тун хэрэг болно. Тухайлбал, сонгуулийн үеэр 100 мянган дагагчтай фэйсбүүкийн хуудас 2-3 сая төгрөг хүрч байсан. Мөн твиттерийнхэн нэгдэж, далд сурталчилгаагаар багагүй мөнгө олчихдог. Тиймээс ажлынхаа хажуугаар, эсвэл гэрээсээ мөнгө олох нэг арга байж болох юм. [ЗГМ]

## “IMAX AWARDS” ёслолын арга хэмжээ болно



“Монголын кино урлагийг хөгжүүлэх сан”, “Өргөө” кино театрт хамтран кино урлагийн дээд шагнал олгох “Imax awards” ёслолын арга хэмжээг зохион байгуулах гэж байна. Энэ хүрээнд “Imax awards”-ын цом бүтээх уралдаан болж, тэргүүлсэн бүтээлийн эзнийг нэг сая төгрөгөөр шагналаа. Уралдаанд 10 гаруй уран бүтээлч оролцсоноос “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн инженер А.Соджаргалын бүтээл тэргүүн байрт шалгарчээ.

Тэрбээр бүтээлээ тайлбарлахдаа “Оскарын шагнал гардуулах ёслолыг үзэж байхад дүрс бичлэгийн дамартай хальс сонирхолтой санагдсан. Тиймээс дамартай хальсыг монгол гэрийн тулга болгон ашигласан. Ер нь цомын харьцаа, хэлбэр, донж зэргийг “Оскар”-ын цомтой харьцуулж хийсэн. Энэ цом нь тойргийг тав хуваасан шийдэлтэй. Дээд хэсэг нь дэвшиж буй баганыг бэлгэдсэн. Нэг талаар хүний дүрс мэт харагдах ч нөгөөтэйгүүр, киноны таван амин сүнснийг илтгэж байгаа юм. Үүнд зохиолч, найруулагч, продюсер, жүжигчид, техникчид орно” гэлээ.

“Imax awards”-ыг ирэх дөрөвдүгээр сарын сүүлээр зохион байгуулах юм. 2016 онд Монголд нийт 47 кино албан ёсоор нээлтээ хийжээ. Эдгээрээс 25 шилдэг киног шалгаруулж, 16 төрөлд нэр дэвшүүлэн тодруулах юм байна. Ингэхдээ “Өргөө” кино театрын цахим хуудас, албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан үзэгчдээс 21 хоногийн турш санал авах аж. Санал асуулгад оролцохыг хүсвэл [www.urgoo.mn](http://www.urgoo.mn) сайтад хандаарай.



### сууц

## Хонконг хамгийн өртөг ихтэй нь

Хонконг, Сидней, Ванкувер хотууд дэлхийн өөр бүсүүдэд байдаг ч нэг зүйлээрээ ижил. Эдгээр хотод орон сууц худалдаж авна гэдэг бараг л боломжгүй. International Residential Property Services байгууллагаас хотуудын орон сууцны үнэ болон иргэдийн өрхийн орлоготой харьцуулсан судалгааг 13 дахь жилдээ явууллаа. Энэ жил уг жагсаалтыг Хонконг долоо дахь жилдээ тэргүүлэв. Түүний араас Сингапурын Сидней, Австралийн Ванкувер хотууд орж байна.

Долоон сая хүнтэй энэ жижиг арал дээр есөн ам.метр жижиг өрөөг сарын 385 доллараар түрээсэлдэг. Жил ирэх тусам оршин суугчид нь нэмэгдэж байгаа учраас орон сууцны үнийг буулгана гэдэг “үлгэр”. Харин яаж тогтоон барих вэ гэдэг нь толгойн өвчин болоод буй. Гуравдугаарт жагссан



Ванкувер хотод газрын хомсдол асуудал биш. Харин Орос, Хятад, Дундад Ази зэрэг орнуудын хөрөнгөтнүүд хотын төвийн орон сууцуудыг үнэ цохин авч байгаа аж. Тэд үүнийгээ бусдад түрээслэхгүй, хоосон хадгалж байгаа нь гол асуудал болжээ.

Тэгвэл хамгийн өртөг багатайгаар АНУ-ын хотууд тодорчээ. Эхний аравт АНУ-ын Бэйсити, Лима, Элмира зэрэг жижиг хот болон Австралийн Каррата, Канадын Монктон багтсан байна. [ЗГМ]

### ХЭРЭГЛЭЭ

## Эрүүл амьдралыг хэвшүүлэх аппликэйшнүүд

**Runkeeper.** Гүйж байхдаа ямар хугацаанд хэр урт зам туулснаа мэдэхэд тусална. Өмнө нь хэр хугацаанд гүйсэн талаарх мэдээллийг он сартай нь хадгалахаас гадна хэрхэн үр дүнтэй гүйх талаар сонирхолтой зөвлөгөөнүүд бий.

**1 Gallon a day.** Нэг өдөрт уух усныхаа хэмжээг энэ аппликэйшнээр нарийн тохируулах боломжтой. Эхлээд биений өндөр, жин, насныхаа талаар мэдээллийг оруулна. Дараа нь зөвхөн ганд зориулсан нарийн дэглэмийн дагуу ус уух боломжтой. Хэрэглэхэд

хялбар бөгөөд 0.99 ам.доллар нэмж төлөөд тохиргоонуудыг хүссэнээрээ өөрчлөөрэй. **MyFitnessPal.** Өдөр тутамд хэрэглэж буй хүнснийхээ хэмжээ, илчлэгийг хянахад зориулсан. Та хэрэглэж буй хүнсний нэр төрөл, хэмжээг сонгоход нийт илчлэгийг нь хормын дотор бодож гаргана.

**Runtastic.** Ноёр муутай хүмүүст зориулсан аппликэйшн. Унтах, сэрэх бүртгээ ганцхан товч дараад өөрийнхөө хангалттай унтаж чадаж байгаа эсэхээ мэдэж болно.

**Moves.** Биенийн хөдөлгөөнөө

байнга хянах боломжийг “Moves” олгоно. Таны хэдэн удаа алхсаныг тооцохоос гадна явсан зай, шатаасан илчлэгийн хэмжээг ч хэлж өгнө. Гүйх, дугуй унах, машинаар явах зэргийг ялгаж, мэдээллийг нь тусад нь харуулдаг. Энэ аппликэйшнээс та өдөр тутамдаа ямар үйлдэл хийдэг вэ гэдгээ мэдэж аварай.


**Elevate.** Ой тогтоолт, шийдвэр гаргалтыг сайжруулахад зориулсан олон төрлийн тоглоомтой. Эдгээр тоглоомыг хэрхэн тогтоосон үр дүнг харьцуулан таны оюуны чадавхыг үнэлж харуулна. [ЗГМ]





## Эдийн засаг

### Газрын тосны ханш уруудлаа



Brent-ийн ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

Газрын тосны томоохон хэрэглэгч болох БНХАУ эдийн засгийн өсөлтийн төлөвөө 0.5 хувиар таналаа. Үүнтэй зэрэгцэн тус түүхий эдийн гол нийлүүлэгчдийн нэг ОХУ гарцаа танах зөвшилцлөөс ухарч магадгүй байна. Олон улсын зах зээлд өрнөж буй эдгээр үйл явдал газрын тосны ханшийг унагалаа. Гурван өдөр дараалан чангарсан газрын тосны ханш шинэ долоо

хоногийн эхэнд буурав. Даваа гарагт Brent төрлийн газрын тосны ханш 0.5 хувиар хямдарчээ. Ингэснээр баррель газрын тос 55.6 ам.долларт тэнцлээ. Мөн АНУ-ын түүхий газрын тос West Texas-ийн ханш 30 центээр доошилж, 53 ам.долларт хүрээд байна. Гэхдээ газрын тосны өнөөгийн ханш өмнөх улиралтай харьцуулахад 1.5 орчим хувиар өндөр байгаа юм. [ЗГМ]

Засгийн газрын  
МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ  
ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581


#### МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.13	▲ +1.99%	3/6/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.048	▲ +2.08%	3/6/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	32.625	▲ +1.95%	3/6/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.027	▲ +12.5%	3/6/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	3/6/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.15	▼ -4.6%	3/6/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.38	▼ -1.57%	3/6/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.4	▲ +21.21%	3/6/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.225	▲ +2.27%	3/6/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.72	▼ -4%	3/6/2017

#### ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1231.7	▼ -0.25%	3/6/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	992.8	▼ -0.13%	3/6/2017
МӨНГӨ	SIA	унци	17.845	▲ +0.59%	3/6/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	267.85	▼ -0.67%	3/6/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	85.86	▼ -1.95%	3/6/2017
WTI ТОС	CLA	баррель	52.85	▼ -0.9%	3/6/2017
БРЕНТ	COA	баррель	55.43	▼ -0.84%	3/6/2017
БЕНЗИН	XBA		164.27	▼ -0.63%	3/6/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.911	▲ +2.97%	3/6/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	344	▼ -0.32%	3/6/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	80.05	▼ -1.84%	3/6/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.195	▼ -0.71%	3/6/2017
БУДАА	RRA	центнер	9.595	▲ +0.1%	3/6/2017
БУУДАЙ	WA	бушель	458.75	▲ +1.16%	3/6/2017
КАКАО	CCA	тонн	1955	▲ +1.4%	3/6/2017
КОФЕ	KCA	фунт	1.43	▼ -0.73%	3/6/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



#### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	332.68	▼ -4.91%	3/6/2017
ГОВЬ ХК	GOV	14390	▲ 7.63%	3/6/2017
МАХИМПЕКС ХК	MMX	2586	▼ -0.54%	3/6/2017
СҮҮ ХК	SUU	130	▲ 0.15%	3/6/2017
АДУУН ЧҮЛУУН ХК	ADL	2000	▲ 1.01%	3/6/2017
БИ ДИ СЕК ХК	BDS	1400	▲ 0.72%	3/6/2017
УБ-БУК ХК	BUK	378	▼ -0.26%	3/6/2017
АРИГ ГАЛ ХК	EER	2299	▲ 9.32%	3/6/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	140	▲ 6.87%	3/6/2017
ЖЕНКО ТҮР БҮЮР ХК	JTB	50.05	▼ -5.96%	3/6/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	533.18	▼ -4.79%	3/6/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	399	▼ -0.05%	3/6/2017
РЕМИКОН ХК	RMC	47.18	▼ -5.62%	3/6/2017
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2314	▲ 0.61%	3/6/2017
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	4801	▲ 0.63%	3/6/2017
МОНГОЛ САВХИ ХК	UYN	600	◀▶ 0%	3/6/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

#### ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5870.753	+9.53	▲ +0.16%	3/6/2017
DAX INDEX	DAX	12027.36	-32.21	▼ -0.27%	3/6/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15608.5	+71.85	▲ +0.46%	3/6/2017
S&P/ASX 200	AS51	5746.512	+16.91	▲ +0.3%	3/6/2017
S&P 500	INX	2383.12	+1.2	▲ +0.05%	3/6/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3233.865	+15.55	▲ +0.48%	3/6/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	21005.71	+2.74	▲ +0.01%	3/6/2017
TOP 20	MSETOP	13167.83	+89.17	▲ +0.68%	3/6/2017
FTSE 100	UKX	7374.26	-8.09	▼ -0.11%	3/6/2017
HANG SENG	HSI	23615.31	+62.59	▲ +0.27%	3/6/2017
NIKKEI 225	NKY	19379.14	-90.03	▼ -0.46%	3/6/2017



Mongolia  
**Forbes**

ШИНЭ ДУГААР ХУДАЛДААНД ГАРЛАА  
ТҮГЭЭЛТИЙН БҮХ САЙН ЦЭГҮҮДЭЭР

+976 77074646

## Аяллын хөтөч

## Сена мөрний эрэгт уулзъя



Францыг зорих нь хамгийн өртөг өндөртэй аяллын тоонд багтаж буй.

BVM©

### Заавал аялах ёстой 20 орны тоонд Франц багтдаг

**Б.Баяртогтох**  
@bayartogtokhZGM

Франц руу нисэх хамгийн том шалтгаан нь Парис. Дэлхийн хотуудаас эрс ялгарах тус хотод удах тусам дасаж мэдрэмж сэдэрч мэднэ. Аз жаргал, зугаа цэнгэл. Эдгээрийн эх сурвалж болохуйц бүхнийг Парис өөртөө нууцхсан гэлтэй ижилгүй төрхөөр угтах нь донжтой. "Хөгшин" Европын өрнүүн хотын "уур амьсгал" цаанаа л хөгжмийн ая эгшигтэй гойд нийцсэн мэт хөгжүүн. Энэ нь тийшээ тэмүүлэх хэн бүхний "зүрх"-ний цохилтыг түргэсгэх яруу зохиол байж таарна. Хотын "хэмнэл" дунд уусах аваас язгууртан олны хөлд үрэгдэж мэдэхүйц эрхэмсэг бүхнийг Парис өөртөө нууцхсан "тулгана". Үүнийг Парисын өдрүүд улам тодотгох нь лавтай. Далайн чанадад хүртэл газар нутагтай Франц нийслэлэй хайр дурлалын хот гэсэн ойлголтоор даян дэлхийд тунхаглаж чадсан. Үүнд нь бид итгэж, ой ухаандаа очих ёстой, аялах учиртай газрын нэг юм байна гэсэн бодлыг зузаалсан.

Хэв маяг, сэтгэл татам төрх байдал нь Франц орныг, тэрчлэн нийслэл Парис хотыг илэрхийлэх үгс. Зөвхөн эдгээр үгээр төсөөлөх нь нэг талдаа яамаг ч байж мэдэх юм. Гэхдээ үүгээр баримжаалахад буруудахгүй болов уу. Дэлхийн хэмжээний үзэсгэлэнг зургаан удаа зохион байгуулж байсан тус хотод алдартай барилга байгууламж олон. Үүнийг онгоцны буудалд дөнгөж газардаад л ажиглаж болно. Парис хотын төв архитектурын сор дурсгалуудаас гадна Тюильри, Люксембургийн цэцэрлэг, Булоний ой зэрэг гайхамшигт ногоон байгууламж энд буй.

Сена мөрний эрэгт орших

энэхүү үзэсгэлэнт хот Францын түүхийн олон чухал үйл явдлын гэрч болон үлдсэн. Тухайлбал, 1789 онд Парисын ард олон Бастилын цайзыг дайран эзэлж, Францын хөрөнгөтний хувьсгалыг эхлүүлж байв. Жил тутам бөмбөрцгийн өнцөг булан бүрээс ирсэн дугуйчид оролцох, дэлхий нийтийн анхаарлыг Парис хот руу татдаг Тур-де-Франс уралдааны шилдгүүд Елисейн өргөн чөлөөнд тодордог.

Конкордын талбайгаас Ялалтын хаалга хүртэл үргэлжлэх эл домогт Елисейн өргөн чөлөөний хоёр талаар зүйл бүрийн мод, бут, усан оргилуур, үй олон кафе, ресторан эгнэн байрладаг. Парист зочилсон хэн бүхэн Елисейн өргөн чөлөөг заавал очиж сонирхдог. Энэ нь тэнд саатсан хэний ч заавал хийх үйлдэл мэт ёс болжээ. Ялалтын хаалга нь Эгуалийн талбайн төв хэсэгт оршдог бөгөөд жуулчдын харааг булаасан нүсэр байгууламж юм. Хаалганыг нь тал талаас 12 гудамж уулздаг. Энэ нь тэнгэрээс ажихад, од хэлбэртэй харагдах агаад талбайн нэр нь ч угтаа үүнээс үүдэлтэй юм билээ. Наполеон Бонапарт Аустерлицийн тулалдаанд байгуулсан ялалтаа алдаршуулан энэхүү ёслолын хаалгыг барих санааг анх гаргаж, барилгын ажил 1806 онд онд эхлэн, гучин жилийн дараа дууссан гэдэг. Ялалтын хаалганы өндөр нь 51 метр.

Эйффелийн цамхаг. Парис хотын бэлгэ тэмдэг болсон Эйффелийн цамхгийг 1889 онд Дэлхийн үзэсгэлэнд зориулан барьжээ. 300 метр өндөр энэхүү цамхаг 1930 онд Нью-Йорк хотын Крайслер-Билдинг баригдах хүртэл дэлхийн хамгийн өндөр барилгад тооцогдож байлаа. Манай гарагийн хамгийн олон хүн зочилдог байгууламжийн орой болох Эйффелийн цамхгийн нэгд жилд зургаан сая орчим хүн гардаг гэсэн статистик үзүүлэлт бий. Цамхгийн гурван ажиглах тавцангийн хамгийн дээд талын буюу 276 метрийн өндрөөс Парис хот нэн

үзэсгэлэнтэй харагдана. Шөнийн цагт цамхгийн гэрлэн чимэглэл асан солонгороод, хотын өнгө төрхийг улмаар нэмэх агаад ихэд ялгарах шалтгаан нь энэ юм.

Сена мөрний баруун эрэгт, XII зууны үеийн хуучны ордон байрлах нь Францын үндэсний урлагийн музей. Нийт 300 мянган үзэмэртэйгээ зарим нь үнэлж баршгүй ховор нандин бүтээл гэдэг. Луврийн музейд дэлхийн хамгийн алдартай уран зураг гэгддэг Леонардо да Винчигийн "Мона Лиза" бий. Музейн үүдний ойролцоо 1989 онд нэрт уран барилгач И.М.Пейн төслөөр босгосон шилэн пирамид байрладаг.

### Франц нийслэлэй хайр дурлалын хот гэсэн ойл- голтоор дэлхийд тунхаглаж чадсан

Түм түжигнэж, бум бужигнах Парис хотын дундуур тогтуун, долгөөн урсгалт Сена мөрөн зүүнээс баруун тийш урсана. Мөрний дээгүүр ойролцоогоор 30 гаруй метр урттай гүүр дамнасан байх агаад хэд хэдэн жижиг арал энд бий. Тэдгээрээс хамгийн алдартай нь Нотр-Дамын сүм байрладаг Сте. Хотын төвд Сена мөрний эрэг дагуу ном, эртний эдлэлийн жижиг лангуунууд эгнэн үргэлжилнэ. Жуулчдад зориулсан завь мөрөөр зорчин хотын үзэмжит газруудыг өөр өнцгөөс харах боломжийг олгодог. Парис бол Францын дотоод усан замын хамгийн том боомт. Сена мөрний эргээс зөөлөн салхи сэвэлзэх нь аядуухан. Урин чийглэг хотын үдшээр зугаалах хэнд ч гэртээ харих цагийг нь энэ байдал мартуулах шидтэй. Бидний дуулж байсан атлаа мэдэхгүй зүйл энд их. Жуулчдыг өөртөө татсаар ирсэн Парис хотын удирдлагууд сүүлийн үед ард

иргэдийнхээ аюулгүй байдалд ихээхэн анхаарал хандуулах болсон. Энэ нь дэлхий нийтийг цочроосон гэмт халдлагуудаас үүдэлтэй юм.

Францыг зорих нь хамгийн өртөг өндөртэй аяллын тоонд багтаж буй. Монголчуудын хувьд бал сараа тэмдэглэх зорилгоор тус хотод тухлан саатах болсон. Аяллын хугацаа найман өдөр,

долоон шөнөөр хэмжигдэж байгаа. Онгоцны тийз аяллын үнэ нийлээд нэг хүний 4.5 сая төгрөг. Бал сараа тэмдэглэх хосуудын хувьд ес орчим сая төгрөгийн зардал гарна гэсэн үг. Энэхүү аяллын үйлчилгээг "Тэнгэр трافل" компани санал болгожээ. "Жуулчин" компанийн зүгээс Европын тойрон аяллыг зохион байгуулах болсон. Тус

аяллыг сонгосноор гурван өдөр Парист зугаалах боломжтой юм байна. Аяллын үнэ 6.6 сая төгрөг бөгөөд Парисаас гадна Женев, Милан, Венец хотоор нэг дор аялах нь. Заавал аялах ёстой 20 орны тоонд Франц багтдаг. Дэлхийн хамгийн романтик улс жилд хүлээж авах жуулчны тоогоороо тэргүүлсэн хэвээр байна. [ЗГМ]

**NATIONAL NEWS CORP.**

**Bloomberg**  
TV MONGOLIA

## НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

**СЭТГҮҮЛЧ:**

*Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд мэдээ сурвалжилга бэлтгэж нийлүүлэх, хөтөлбөрт мэдээ танилцуулах, мэдээний болон техникийн ажилтнуудтай багаар хамтран ажиллах.*

**ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:**

- Эдийн засаг, бизнесийн тодорхой салбарыг хариуцан ажиллаж, мэдээ сурвалжилга бэлтгэх
- Салбарын бизнес, зах зээлийн судалгаа хийх, биржид бүртгэлтэй компаниудын тайлан, гол үзүүлэлтүүдэд анализ хийх, төлөв таамаг бэлтгэж танилцуулах
- Шууд болон шууд бус хөтөлбөрт мэдээ, сурвалжилга танилцуулах, зочидтой ярилцах, яриа авах

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, бизнес, санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, зах зээлтэй холбоотой аль нэг салбарт ажиллаж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийх туршлагатай
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Мэдээллийг цуглуулах, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай.

**ОРЧУУЛАГЧ:**

*Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд гадаад мэдээ сурвалжилгыг орчуулан бэлтгэж нийлүүлэх, шууд хөтөлбөрт гадаад мэдээний синхрон орчуулга хийх, гадаад нэвтрүүлгийн орчуулга хийх, бүтээлийн багуудтай хамтран ажиллах.*

**ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:**

- Олон улсын харилцаа, эдийн засаг, улс төр, бизнесийн салбарын мэдээлэл орчуулах
- Дээрх сэдвээр шууд болон шууд бус хөтөлбөрт орчуулга хийх,
- Олон улсын сүлжээ, агентлагуудаас хүлээн авсан мэдээ сурвалжилга, ярилцлагыг орчуулах, дуу оруулах

**ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Англи хэлний орчуулагчийн бакалавраас доошгүй зэрэгтэй (орос хэлтэй бол давуу тал болно)
- Эдийн засаг, бизнесийн салбар, танин мэдэхүйн нэвтрүүлгийн орчуулга хийх бүрэн чадвар, туршлагатай (аман болон бичгийн орчуулга хийж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Англи, монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажилд туршлагатай
- Эдийн засгийн аль нэг салбар, зах зээлтэй холбоотой ажил хийж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно.

**ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:**

- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Бусадтай харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Интернэтийн орчинд ажиллах, компьютер ашиглах мэдлэгтэй, программ дээр ажиллах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх.

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:**

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

**Анкетыг "BLOOMBERG TV MONGOLIA" телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.**

**Хаяг: Блю Скай таур, 4 давхар, № 403, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол Улс, Холбоо барих утас: 70102020**

### ЗӨВЛӨГӨӨ

## Эрсдэлээ даатгуулахаас аялал эхэлнэ

Та гадаад улс орнуудад аялахаар шийдсэн бол гадаадын зорчигчдын амь нас, эрүүл мэндийн даатгалд хамрагдахыг зөвлөж байна. Манай улсын ихэнх даатгалын компаниуд энэ төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа. Тухайн аялагчийн аялах улс орны бүсчлэл, явах хугацаанаас хамаарч даатгалын хураамж нь даатгалын компани бүрт харилцан адилгүй. Тодруулбал, 3-250 ам.долларын хооронд хэлбэлзэж байна. Аялал бүрийн

даатгалын хугацаа дээд тал нь 90 хоног байдаг. Хэрэв та гадаад улс орнуудад байнга зорчдог бол бүтэн жилээр даатгуулж бас болно.

Даатгалын гэрээт баталгаа нь аялагч болон даатгалын компани хооронд байгуулсан гэрээ болох учраас даатгуулагч нь даатгалын нөхцөлтэй урьдчилан сайтар танилцах нь чухал. Гадаадад зорчигчдын иж бүрэн даатгалд хамрагдсанаар үүсэж болзошгүй эрсдэлээс өөрийгөө

хамгаалах боломжтой юм. Нөхөн төлбөрийн хэмжээ нь тухайн даатгалын компанийн нөхцөлөөс шалтгаална. Тиймээс даатгалын нөхцөлд ач холбогдол өгч, ялангуяа нөхөн төлбөртэй холбоотой хэсгүүдийг илүү нягтлах хэрэгтэй. Нэмэлт мэдээллийг хүргэхэд, "Ард даатгал" компани гар утаснаасаа гадаадад зорчигчдын даатгалын үйлчилгээ авах, улмаар 10 хувийн хөнгөлөлт эдлэх боломжийг олгож байна. [ЗГМ]

## Сурталчилгаа



# ХЭРХЭН 18 ХУВИАС ДЭЭШ ӨГӨӨЖ АВАХ ВЭ?

### Бонд болон үүний давуу тал

Бонд нь тогтоосон хугацааны дараа тохирсон хүү болон үндсэн төлбөрийг тодорхой нөхцөлтэйгээр эргүүлэн төлөхийг амлаж буйг баталсан үнэт цаас. Энэхүү санхүүгийн бүтээгдэхүүн нь санхүүжилт хүсч буй болон хөрөнгө оруулах сонирхолтой этгээдийг хооронд нь шууд холбож өгсөнөөр хоёр талдаа ашигтай хүү хүртэх боломж үүсгэдэг. Мөн тус бүтээгдэхүүнийг хугацааны дундуур хоёрдогч зах зээл дээр борлуулах боломжтой ба нэрлэсэн хүүнээс хүүгийн алдагдал хүлээдэггүйгээр хугацаатай хадгаламжаас давуу талтай.

### Бид хэрхэн бонд гаргагч компанийг сонгодог вэ?

Бидэнд бонд гаргах хүсэлтээ илгээсэн компаниудыг нарийвчилсан судалсны үндсэн дээр тухайн компанид бонд гаргахад нь андеррайтинг хийж хөрөнгө оруулагч нарт танилцуулах эсэхээ шийдвэрлэдэг. Нарийвчилсан судалгаагаараа бид бонд гаргах хүсэлтэй байгаа компанийн санхүүгийн тайлан шинжилгээ болон салбарын судалгаа хийхээс гадна тухайн компанийн удирдлагын баг болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц зэрэг чанарын судалгааг хийдэг.

### Бид зөвхөн өөрсдөө хөрөнгө оруулалт хийх бондын андеррайтингийг гүйцэтгэдэг

Бид зөвхөн найдвартай, өндөр өгөөжтэй бондын андеррайтингийг гүйцэтгэж, өөрсдөө гаргасан бондын 10-20 хувийн худалдан авдаг. Учир нь бид зөвхөн итгэлтэй байгаа компанидаа санхүүжилт татаж, харилцагч болон хөрөнгө оруулагч нарт танилцуулдаг.

### Бидний бонд андеррайтинг хийсэн түүх



2016 оны сүүлээр бид Хүннү Эйр компанид сар болгон үндсэн болон хүүгийн төлбөрөө гүйцэтгэх нөхцөлтэй, 18 сарын хугацаатай, сарын 1.2 хувийн хүүтэй 600 мянган доллартай тэнцэх 1.5 тэрбум төгрөгийн бонд босгож өгсөн ба энэхүү бонд нь явцын дундуурх төлбөрүүдээ хугацаандаа төлж, хөрөнгө оруулагчдад амалсан өгөөжөө цаг бүрт нь хүргэсээр байна.



Мөн бид 2017 оны 2 сарын 20-ны өдөр Ард Санхүүгийн Нэгдлийн хаалттай хүрээнд гаргасан 2 жилийн хугацаатай, жилийн 19.2 хувийн хүүтэй, улирал бүр хүүгийн төлбөрөө гүйцэтгэх нөхцөлтэй 2 тэрбум төгрөгийн бондыг анхдагч зах зээл дээр амжилттай арилжаалав.

### Бидний бонд андеррайтингийг хийж буй зорилго

Бид бондын зах зээлийг хөгжүүлж, шилдэг компаниудад найдвартай үнэт цаас гаргах замаар бага өртөгтэй санхүүжилт татаж өгөх, хөрөнгө оруулагчдад өндөр өгөөж (18 хувиас дээш) хүртэх санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгон ажиллаж байна.



### Ард Академи санхүүгийн боловсролоо дээшлүүлэх сургалтанд таныг урьж байна

Ард Секюритиз үнэт цаасны компани нь олон нийтэд санхүүгийн боловсрол олгох "Ард Академи"-ийн сургалтаа 2016 оны 8 сараас хойш 7 хоног бүрийн бямба гарагт тасралтгүй зохион байгуулж байна.

#### Та анхан шатны сургалтанд хамрагдсанаар:

- Хувийн санхүүгээ зөв зохистой удирдах;
- Ирээдүйн хуримтлалаа хэрхэн зохион байгуулж бүрдүүлэх;
- Хөрөнгө оруулалт хийж, банкны хадгаламжнаас өгөөж өндөртэй хөрөнгө оруулалт хийх боломжуудын талаар сурах болно.

#### Ахисан шатны сургалтанд хамрагдсанаар:

- Баланс, орлогын тайлангийн шинжилгээ хэрхэн хийх;
- Компанийн үнэлгээг хэрхэн хийх;
- Өгөөж өндөр хөрөнгө оруулалт хийх боломжуудыг олж мэдэх;
- Хөрөнгө оруулалтын багц хэрхэн сонгож, эрсдэлээ хэрхэн бууруулах;
- Хөрөнгө оруулалт хийх зарчмууд болон хөрөнгө оруулалт хийхдээ анхаарах зүйлсийн талаар сурахаас гадна компанийн хийсэн судалгаа болон сургалтын гарын авлага ном, баланс орлогын тайланд шинжилгээ хийх загвар авна. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын хэлэлцүүлэгт оролцох боломж олгож байна.

Бид 2017 онд Монголын хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвхийг сайжруулах зорилго тавьж, Монгол Улсын иргэн бүрийг хөрөнгө оруулагч болгохоор шамдан ажиллаж байна. Та бүхэн манай сургалтанд хамрагдан хөрөнгө оруулалтын боломжоо бий болгоорой.



MONGOLIAN CASHMERE

## ХУВЬЦАА АВАХ ЦАГ МӨН ҮҮ?

ГОВЬ ХК-ийн хувьцааны  
дэлгэрэнгүй шинжилгээ  
авахыг хүсвэл бидэнтэй  
холбогдоно уу



(976) 8809 0729, (976) 9410 0304, (976) 8803 4942



цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

"Ард Холдингс"-ын байр II давхар, Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Хүчтэй. Хамтдаа.